

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-58
1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	6-8
2.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/	8-14
3.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	14-58

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 9 дүгээр сарын 30-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 24 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Доржханд, Л.Энх-Амгалан;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Баярбаатар, О.Цогтгэрэл, Д.Энхтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Н.Номтойбаяр;
Тасалсан: Л.Оюун-Эрдэнэ.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Бүсчилсэн хөгжлийн дэд хороо хариуцсан референт Б.Баясах, Ёс зүйн дэд хороо хариуцсан референт О.Мөнгөнчавхдас, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хариуцсан референт С.Төрмөнх нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 9 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	6
Бүгд:	18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 7 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 3
Бүгд: 18

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 76 гишүүн 2025.09.21-ний өдөр өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 2
Бүгд: 18

88.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 11 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Ж.Дэлгэрсайхан, А.Энхбат, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн зөвлөлийн Ажлын албаны дарга В.Жавзан, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Пүрэвдагва, Л.Золзаяа, Б.Төгсцэнгэл, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Ерөнхийлөгчийн хот, хөдөөгийн бодлого хариуцсан зөвлөх Г.Ганболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баярмаа, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, Макро эдийн засгийн бодлогын газрын мэргэжилтэн Т.Мягмаржав, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга

П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах шинжээч Н.Уранцэцэг, мэргэжилтэн П.Энхманлай, Г.Үлэмждэлгэр, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Т.Бат-Оргил, Б.Энхжин, Л.Баасандаш, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбямба, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх Д.Энхбаяр, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Д.Энхдалай, А.Цогбаяр, В.Эрдэнэцогт, Б.Долгорсүрэн, И.Эрдэнэцэцэг, С.Нацагдорж, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Д.Нямжаргал, Б.Идэрбалжинням, Э.Баттогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Бүсчилсэн хөгжлийн дэд хороо хариуцсан референт Б.Баясах, Ёс зүйн дэд хороо хариуцсан референт О.Мөнгөнчавхдас, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хариуцсан референт С.Төрмөнх нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Хоёр дахь хэлэлцүүлэг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Ж.Дэлгэрсайхан, А.Энхбат, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн зөвлөлийн Ажлын албаны дарга В.Жавзан, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Пүрэвдагва, Л.Золзаяа, Б.Төгсцэнгэл, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран,

Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Ерөнхийлөгчийн хот, хөдөөгийн бодлого хариуцсан зөвлөх Г.Ганболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баярмаа, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, Макро эдийн засгийн бодлогын газрын мэргэжилтэн Т.Мягмаржав, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн мэргэжилтэн Э.Цолмон, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах шинжээч Н.Уранцэцэг, мэргэжилтэн П.Энхманлай, Г.Үлэмждэлгэр, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Т.Бат-Оргил, Б.Энхжин, Л.Баасандаш, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбямба, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх Д.Энхбаяр, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Д.Энхдалай, А.Цогбаяр, В.Эрдэнэцогт, Б.Долгорсүрэн, И.Эрдэнэцэцэг, С.Нацагдорж, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Д.Нямжаргал, Б.Идэрбалжинням, Э.Баттогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Бүсчилсэн хөгжлийн дэд хороо хариуцсан референт Б.Баясах, Ёс зүйн дэд хороо хариуцсан референт О.Мөнгөнчавхдас, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хариуцсан референт С.Төрмөнх нар байлцав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Ө.Шижир, Ц.Туваан, Ц.Идэрбат, А.Ариунзаяа, О.Саранчулуун, Ч.Номин, М.Бадамсүрэн, Э.Болормаа, С.Зулпхар, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбямба, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх Д.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, А.Ариунзаяа, О.Саранчулуун, С.Бямбацогт, С.Зулпхар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа 2026 оны төсөвт төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн тэтгэмжийг 2026-2027 онд дамнуулан олгохоор оруулж ирсэнд эрх зүйн шинжилгээ хийлгэж, зөвлөмж гаргуулах горимын санал гаргав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан тайлбар хийв.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 8

Бүгд: 22

63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул зөвлөмж гаргуулахаар Байнгын хорооноос албан бичиг явуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 54 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 68.8 хувийн ирцтэйгээр 14 цаг 18 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 11 цаг 24 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл, Аюушийн Ариунзаяа, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Батын Батбаатар, Энхбатын Болормаа, Амгаланбаатарын Ганбаатар, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилигийн Лодойсамбуу, Лхагвын Мөнхбаатар, Чинбатын Номин, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Отгоны Саранчулуун, Цэвэгдоржийн Туваан, Бадарчийн Хэрлэн, Өлзийхүүгийн Шижир гэсэн гишүүд ирснээр ирц хүрсэн байна аа.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Одоо Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя аа.

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал,

2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг.

3.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл, Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа орьё оо. Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудалдаа орьё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн

мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалтыг явуулна аа. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтдаа бэлдээрэй.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүнээс, 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

18 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Энэ нэгжийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гол агуулга нь одоогийн төрийн албаны хуульд сумын ИТХ-ын төлөөлөгчдийн 3-ны 1-ээс доошгүй нь төрийн захиргааны албан хаагч байж болно гэсэн заалт байгаа. Энийг өргөжүүлж, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн 50 хувиас доошгүй нь ТЗ байж болно оо гэсэн ийм хуулийн заалтыг өргөн барьсан байгаа. Агуулга нь энэ юм байна лээ шүү гэдгийг хэлчихье.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 7 гишүүнээс 2025 оны 7 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал. Хураалт байж. Байгаарай 18 гишүүнээс 15 гишүүн дэмжиж 83.3 хувиар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 76 гишүүнээс 2025 оны 9 сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

18 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 88.9 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдааны эхний хэлэлцүүлэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

11.31 цаг

Хоёр дахь асуудалдаа оръё оо. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газраас 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.2-т Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж гишүүд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно оо гэж заасан.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

С.Бямбацогт Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Б.Жавхлан Сангийн сайд, Г.Ганболд Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн бодлого хариуцсан зөвлөх, Л.Цэдэвсүрэн ТАЗ-ийн дарга, Б.Баасандорж Улсын Их Хурлын ЕНБД. Баасандорж дарга хааччихсан юм дуудаач. Ц.Амартөгс ТАЗ-ийн гишүүн Ёс зүйн хорооны дарга, Б.Пүрэвдагва ТАЗ-ийн гишүүн, Л.Золзаяа ТАЗ-ийн гишүүн, Б.Төгсцэнгэл ТАЗ-ийн гишүүн, Н.Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга. Энхбаяр дарга байна уу? П.Дэлгэрнаран СЕХ-ны дарга. Д.Мөнх-Эрдэнэ ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга. Д.Баянбилиг Үндсэн ҮХЦ-ийн Тамгын газрын дарга, Х.Сүхбаатар Монгол Улсын Шадар сайдын зөвлөх, Б.Батбямба Монгол Улсын Шадар сайдын ажлын зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга. Батбямба дарга байна уу? Ажлын алба энэ ирээгүй байгаа албан тушаалтнуудаа дууд. Д.Энхбаяр Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, В.Жавзан ТАЗ-ийн ажлын албаны дарга, Н.Ганбаатар Ёс зүйн хорооны ажлын албаны дарга, Ж.Бямбасүрэн ЗГХЭГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, И.Батхүү Эдийн засаг хөгжлийн яамны ТНБД, Ж.Ганбат Сангийн яамны ТНБД. Ганбат дарга яасан юм? Дуудаарай. Ч.Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, С.Батбаатар Стандартчилал хэмжил зүйн газрын, Т.Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Б.Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга. Санжаадорж дарга байна уу? Хамгийн их асуултад хариулах хүн шүү дээ. Дууд С.Тулга Сангийн яамны санхүүгийн бодлогын газрын дарга. Энэ Сангийн яамныхан чинь хааччихсан юм бэ? Төрийн нарийнаасаа авхуулаад байхгүй юм. Газрын дарга нар нь. Тэгээд хэнээс асуух юм айн. Тэгээд Өргөдлийн байнгын хороо нь дуусчихсан юм биш үү. Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга. Өргөдлийн байнгын хороон дээр ямар Сангийн яамныхан байх юм бол. Б.Лхагвасүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Менежментийн газрын Санхүү хангамжийн үйлчилгээний хэлтсийн дарга, Х.Отгонжаргал ҮАБЗ-ийн Ажлын албаны Санхүү хэлтсийн дарга. Я.Гантөмөр ОБЕГ-ын дэд дарга, хурандаа. Байна уу? Я.Гантөмөр гэж. Сангийн яамныхныг хүлээх юм уу? Д.Эрдэнэбаяр Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн захирал, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ц.Мөнхдэлгэр Эдийн засаг хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого төсөөллийн хэлтсийн дарга, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга. Байна уу? Зарлага нь байна уу? Орлого нь байна. Зарлагынх нь хэлтсийн дарга байна уу? Л.Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Б.Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын

удирдлагын хэлтсийн дарга, Б.Өрболд Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Р.Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага арга зүйн газрын дарга, Н.Уранцэцэг Сангийн яамны төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч, Д.Отгонжаргал Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч, Л.Энхманлай Сангийн яамны төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Г.Үлэмждэлгэр Сангийн яамны төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн. Энэ мэргэжилтнүүд байгаа юу? Хааччихсан юм. Ирэх ёстой юм уу ирэх ёсгүй юм уу. Сангийн яамныхан. Э.Цолмон Сангийн яамны төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн. Ирэхгүй юм бол яах гэж ийм олон нэрүүд өгсөн юм бэ? Б.Энхжин Сангийн яамны татварын бодлогын газрын мэргэжилтэн, Баасандаш Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Б.Баярмаа Эдийн засаг, хөгжлийн яамны ТЗУГ-ын санхүү хэлтсийн ахлах мэргэжилтэн. Т.Мөнх-Эрдэнэ ОБЕГ-ын Санхүү ар талын газрын санхүү хэлтсийн дарга хошууч, П.Чанцалдулам Санхүүгийн аудитын газрын менежер, Д.Энхдалай Санхүүгийн аудитын газрын менежер, Цогбаяр Санхүүгийн аудитын газрын менежер. Аудитынхан байгаа юм уу Наранчимэг дарга.Та л ганцаараа байна уу? Наранчимэг дарга. Гүйцэтгэлийн аудитын газрын менежер Энхтуяа, Нямжаргал Гүйцэтгэлийн авлагын газрын менежер, Идэрбалжинням Гүйцэтгэлийн аудитын газрын менежер, Баттогтох Гүйцэтгэлийн аудитын газрын менежер.

Сангийн яамныхан ирсэн үү? Сангийн яамныхан Санжаадорж дарга. Төрийн нарийн чинь хаачсан юм? Өргөдлийн байнгын хороон дээр юу танилцуулаад байгаа юм бол?

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд хуулийн төсөл 2 зүйлтэй.

Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж болно оо. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Төсвийн хүрээ шүү. Саранчулуун гишүүнээр тасаллаа. Саранчулуун гишүүний микрофоныг. Зөвхөн эрхлэх асуудлынхаа хүрээнд шүү дээ гишүүд.

О.Саранчулуун: Баярлалаа нэг юм асууя нөхөд өө. Ингэх гэж байна СЕХ-ны төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн эрхийг дэмжихтэй холбоотой тусгай зохицуулалтыг хийх шаардлагатай байгаад байдаг. Тийм. Тэгэхээр энэ дээр төсвийн хүрээнд оруулж байж явна. Тэгэхээр ер нь бид нар ингээд жилийн жилд нөгөө хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлаа ярьсан юм чинь эцэст нь тултал ярьчих гээд л үзээд байна л даа. Тэгэхээр нөгөө гол санаа нь хоол унд, эрүүл мэнд, амьдрах орчин, байр гээд ярихаас гадна энэ бүхний чинь хамгийн чухал эрх нь улс төрийн эрх байгаа байхгүй юу. Улс төрийн эрхийг нь үүд хаалгыг нь нээж өгч байж энэ хүмүүсийн бусад эрхүүд нь хангагдана. Тэгэхээр яг энэ СЕХ-ны төсөв дээр бид нарт тийм багц мэдээлэл ер нь нэг багц тойм ирж байгаа болохоор энэ доторх энэ эрхийг хангахтай холбоотой ямар зохицуулалтыг төлөвлөж байдаг юм доо. Энэ байгууллага маань өөрөө энэ дээр ер нь ямар бодолтой байдаг юм, ямар төлөвлөгөөтэй байдаг юм гэдгийг би сонсмоор байгаа байхгүй юу. Яагаад гэвэл энэ чинь НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенцын бүүр 29 дүгээр зүйлийн хэрэгжилттэй холбоотой зүйл байхгүй юу.

Бид нар энэ дээр Засгийн газраас үүрэг хүлээсэн. Биелүүлэх ёстой, хийх ёстой нэг ажил байгаа. Энэ дээр би хариулт авмаар байгаа юм?

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 номерын микрофон. СЕХ-ны дарга Дэлгэрнаран дарга хариулъя.

П.Дэлгэрнаран: Би гишүүний асуусан асуултад хариулъя аа. Гол нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн эрхийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгуульд саналаа өгөх энэ асуудлыг дэмжихэд олон төрлийн зохион байгуулалтын болоод материал, хангамжийн асуудал шаардагддаг. Тэгэхээр энэ асуудлуудыг шийдэхийн тулд бид нар тодорхой төсөв тавьдаг. Урьд нь чингэж явж ирсэн. Одоо энэ тавьж байгаа төсөв маань бол ерөөсөө л өм цөм хасагддаг. Жишээлбэл энэ 2026 онд бид нар бол 578 сая төгрөгийг мэдээлэл сурталчилгаа, гол нь энэ мэдээлэл сурталчилгаагаар дамжиж гол явагддаг ажил. Тэгэхээр энэ дээр 578 сая төгрөг төсөвлөөд өгсөн боловч Сангийн ямаар хянагдсан төсөв нь 10 сая 500 мянга. Ер нь энэ дээр ингээд хэлэхэд бол бид нар гол үйл ажиллагааны маань манай зардал бол энэ юм байгаа юм. Тэгээд жил болгон ингэж зарагддаг. Манайд бол маш их хүндрэлтэй байна. Энэ 10 сая төгрөг гэдэг бол бид ирэх онд өдөртөө 20-оос 30 мянган төгрөгийн төсөвтэй ажиллана л гэсэн үг. Нийт сонгогчид, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүүгээ энийг хуваарилаад үзэх юм бол нэг сонгогчдод 4 төгрөг ердөө л 4 төгрөг оногдохоор. Ийм хэмжээний зардал явж байгаа юм. Тэгэхээр манай үндсэн үйл ажиллагааны зардал маань ингээд өм цөм байхгүй байж байгаа нөхцөлд ер нь бол цаашдаа бол энэ ажлыг эрхэлж явуулахад маш их хүндрэлтэй болж байгаа.

Ц.Сандаг-Очир: Энэ дээр Сангийн яамнаас нэмэлт тайлбар өгөх үү? Саранчулуун гишүүний асуултад нэмэлт хариулт өгөх хүн байна уу? Тайлбар 500 хэдэн сая төгрөгийн санал өгсөн гээд байна шүү дээ. Сургалт сурталчилгаан дээр тэгээд 10 сая төгрөг болсон. Улсын хэмжээнд 10 сая төгрөг. Иргэд олны сонгогчдыг соён гэгээрүүлэх, ухуулга сурталчилгаа хийх, мэдээ мэдээллээр хангах энэ ажлын зардал шүү дээ. Тэгээд улсын хэмжээнд 10 сая төгрөг. Энэн дээр ажлын хэсгийн 8 номерын микрофон Санжаадорж дарга хариулт өгөх үү?

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Асуултад хариулъя аа. Мэдээжийн хэрэг төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлж байгаа хүсэлт бол маш өндөр байж байгаа. Гэхдээ хэд хэдэн шалтгааны улмаас энэ төсөв бол тусахгүй байгаа.

Нэгдүгээрт хамгийн гол асуудал бид нар орлогодоо тааруулж зарлагаа хийх ёстой. Эдийн засгийн хөгжлийн яамнаас бидэнд өгсөн одоо энэ орлого зарлагын дээд хязгаарт багтааж төсөв явахад бол ийм зардал бол тусах боломжгүй байсан.

Хоёр дахь асуудал бол төсвийн ерөнхийлөн захирагчдын хувьд бол хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдээ бол тогтоож чадахгүй байгаа. Жишээ нь СЕХ бол энэ төсвийг аваад юу хийх гэж байгаа юм бэ гэдэг тайлбар танилцуулга байхгүй. Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар бол хамт өргөн баригдсан байгаа энэ зүйл дотор хөгжлийн бэрхшээлтэй хүн гэсэн тийм зорилт байхгүй. Тийм зорилт ч ирүүлээгүй.

Ц.Сандаг-Очир: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Байдаггүй юм байжээ. Тэгвэл улс төрийн эрх эдлээгүй ямар ч мэдээлэл аваагүй санал өгөх ч хэцүү ийм нөхцөлтэй хэдэн иргэд ингээд байсаар байх л юм байна. Тэгэхээр ер нь яах вэ ингээд төсвийг шууд төсөв ингээд орчхоор давхар нөгөө төслийн 2 дугаар хавсралт руу үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг харахаар яг байхгүй байсан нь тэр үнэн л юм байна. Тэгэхээр цаашдаа энэ дээр яах юм? Чиглэл үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг задлах хэрэгтэй шүү дээ. Мэдэхгүй бол би хэлээд өгье өө. Сонгуулийн үйл ажиллагааны хүртээмжийг хангах 1 дүгээр ажил байх ёстой. Энэ дотор биет орчны хүртээмж, мэдээллийн хүртээмж гэж 2 юм байгаа. Технологийн шийдлийг оруулах хэрэгтэй байна.

Гуравдугаарт нь хүний нөөц буюу тэр хүмүүсээ сургах хэрэгтэй байна. 4-д нь хяналт оролцоог сайжруулах чиглэлийн ажлуудаа иргэний нийгмийнхэнтэй хийх хэрэгтэй байна.

Тавд нь энэ эрхийн баталгаажуулалт руу чиглэсэн ажлууд хийх хэрэгтэй байна. Ядаж нэг ийм 5 бүлэг тулгуур үзүүлэлтийг оруулчихвал их зүгээр байна даа.

Ц.Сандаг-Очир: Нэмэлт нэг минут авах юм уу? Нэмэлт нэг минут өгье.

О.Саранчулуун: Тэгэхээр. Яг саяын хэлсэн 5 зүйлийг оруулах боломж ер нь байна гэж та нар харж байна уу? Энэ хэр хол санагдаж байна тэ? Би ингээд биет орчны хүртээмж гээд ярихгүй, дахиад мэдээллийн хүртээмж гэж яриад байна шүү дээ тиймээ? Тэгэхээр энэ хэр хол байна. Одоо ингээд 10 сая төгрөг тавьчихаад энүүгээрээ юуг нь хийх юм бэ?

Нэгдүгээрт тэр шалгуур үзүүлэлтээ тодорхой болгочих л доо. Тэгээд Сангийн яам нь ч гэсэн дээ та нар өөрсдөө ийм юм оруулаагүй гээд ямар сэтгэлгүй юм бэ аль аль талдаа.

Дахиад нэг жоохон сэтгэлтэй хариулт сонсчихъя тэгэх үү? Энийг чинь хүмүүс үзнэ шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 8 номерын микрофон Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Асуултад хариулъя. Ирэх жилийн СЕХ-ны төсөвт бол нөхөн сонгууль болон дахин сонгууль хийх зардал бол 2.5 тэрбум төгрөг бол батлагдаж байгаа. Энэ зардлаасаа бол сонгуультай холбоотой зардлуудаа гаргаад явах ёстой. Тэгээд дутагдах юм бол Засгийн газрын нөөц хөрөнгөөс бол сунгалттай холбоотой зардал гарах ийм хуулийн заалттай байдаг. Энэ зардлууд явах ёстой. Одоо нэгэнт бид нар зарлагаа тэлж чадахгүй нь ингээд ойлгомжтой болчихсон ийм цаг үед бол бид нар яах ёстой вэ гэхлээр төсвийн үр ашгаа сайжруулах ёстой. Төсвийн үр ашгаа сайжруулахдаа байгууллагад үндсэн зорилго зорилт нь юу юм бэ? Энэ дотроо хуулиар хүлээсэн үүргүүд маань юу юм бэ? Энийгээ яаж хэрэгжүүлэх ёстой юм бэ гэдэг асуудал дээрээ хариултаа өгөх ёстой болчихоод байгаа.

СЕХ-ны хийх ёстой ажлууд нь хуулиар бол мэдээж хэрэг бол бүгд заачихсан байгаа? Энэ дундаа байгаа нөхцөл байдал нь юу юм, цаашдаа юугаа яаж сайжруулах вэ гэдэг асуудлыг бол яг байгууллагын өмнөөс бол бид нар ороод удирдлагад нь зохион байгуулалт менежмент нь бол орох боломжгүй байгаад

байдаг. Тэгэхээр энэ дотроо бол зохицуулалтаа хийгээд явах ёстой гэдэг ийм л тайлбар.

Ц.Сандаг-Очир: Дэлгэрнаран дарга ажлын хэсгийн 3 номерын микрофоныг. Хариулт өгөөдөх дөө.

П.Дэлгэрнаран: Би хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн эрхийг хамгаалах, нөхөн болон дахин сонгуулиудыг зохион байгуулах энэ дээр бол бид нар тусгайлан хөтөлбөр боловсруулж Сангийн яаманд хүргэнэ гэдгийг би ойлгохгүй байна. Энэ бол манай хуулиар заагдсан яг үндсэн үйл ажиллагаа тогтмол явагддаг. Тэгэхээр сая гишүүний хэлээд байгаа тэр асуудал бол манай байгууллагын дотоод зорилт ажлын төлөвлөгөөгөөр шууд зохицуулагдаад явдаг байнга гарч байгаа ийм асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр энийг маань санхүүжүүлэхгүй л гэдэг асуудал бол хамгийн гол нь байгаад байгаа юм.

Сая тэр нөхөн сонгууль жил болгоны 6 сард болдог. Сая 2.5 тэрбум төгрөг ирэх жилийн сонгуульд гэж байгаа. Бид нар өөрт байгаа дата мэдээлэл дээр үндэслэж төсөвлөлтийг бол хийж байгаа. Нэгжийн тухай хуульд одоохондоо өөрчлөлт ороогүй байна. Ирэх жилийн сонгууль бол нэлээд олон тойрог дээр орон нутгийн сонгуулиуд явагдана. Тэгэхээр бид нар.

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд хариулчих нэг минут.

П.Дэлгэрнаран: Бид нар бол 5 тэрбум 60 сая төгрөг төсөвлөсөн. 2.5 сая шууд нугалаад хасаж байгаа. Ямар үндэслэлээр хасаж байгааг мэдэхгүй зүгээр ер нь бол сураг сонсох нь энэ ингээд болно оо гэж байгаа. Хэрэв энийг Сангийн яам мэддэг бол сонгуулиа тэд нар зохион байгуулдаг баймаар байна. Шулуухан хатуухан хэлэхэд тэгээд энэ ямар ч үндэслэлгүй хасдаг энэ байдал бол ямар ч утгагүй байна аа.

Ц.Сандаг-Очир: Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-гоос 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ ээ.

Байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Номин танилцуулна.

Та Төсвийн байнгын хорооны гишүүн учраас Төсвийн байнгын хороон дээр байнгын хорооны санал, дүгнэлтээ танилцуулчих.

Хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

3 дахь асуудалдаа орёе. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье ээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд түрүүн уншсаны адил, Сангийн яамныхан нэмэгдэж ирсэн байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т Байнгын хорооны гишүүн хуралдаанд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч Монгол улсын ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлж болно гэж заасан.

Монгол Улсын 2026 оны төсвийн төслүүдийн талаар асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Зулпхар гишүүнээр тасаллаа.

Алтангэрэл гишүүн асуултаа асууя.

О.Алтангэрэл: Энэ Хэрэг эрхлэх газрын даргаас асуулт асуумаар байх юм. Энэ Хэрэг эрхлэх сайдын төсвийн багц дээрээс энэ Шинэ хоршооны хөгжлийн нэгж гэдэг энэ нэгжтэй холбоотой асуулт асууя. Тэр Шинэ хоршооны хөгжлийн нэгж гэдэг нь байна уу? Энэ Шинэ хоршооны хөгжлийн нэгж гээд ийм газар байна. Тэгээд одоо ер нь энэ Шинэ хоршоо бол юу болж хувирсан бэ гэхээр малчид зээл авсан хэдүүлээ нийлээд. Нэг ийм хоршооны бичиг баримт бүрдүүлээд. Авсан зээл дийлэнхдээ юу болсон бэ гэдгийг орон нутгийн гишүүд бүгд мэдэж байгаа. Авсан зээл Приус машин болсон, авсан зээл хүүхдийн сургалтын төлбөр болсон, авсан зээл заримдаа хэдэн мал болсон, дийлэнх нь хурдан морь болсон шүү хэллээ, приус 30 болсон, 20 ч болсон. Одоо тэгэхээр энэ 4.4 тэрбум төгрөг тавьсан юм шиг байна шинэ хоршооны хөгжлийн нэгж гээд.

Тэгээд энэ нэгж өнгөрсөн хугацаанд юу хийсэн юм, одоо юу хийх вэ? Эргээд наад малчид чинь тэр зээлийг төлнө. Хэрвээ одоо ямар нэг байдлаар эхнээсээ тавихдаа л энийг өөр зорилгоор юм уу сонгуулийн санал худалдаж авах зорилгоор ч юм уу тавиагүй л юм бол энэ угаасаа зээл учраас төлөгдөнө өө. Ингээд хүрчихсэн зээлээ яаж төлөх вэ энэ дээр судалгаа байна уу? Энэ зээл үнэхээр тэр Шинэ хоршоо гээд анх ярьж байсан чухам л Монгол Улсын ХАА малчдыг сайхан болгоод хөгжлийн шинэ шатанд гаргана гээд байсан тэр зорилго руугаа ядаж нэг алхам дөхсөн үү? Энэ тавьчихсан байгаа мөнгө юунд зарцуулагдах вэ? Ямар зорилгоор ямар юу хийдэг газар юм? Ямар зорилгоор тавьсан юм? Ямар үр дүн өгөх юм гэсэн ийм асуулт байна.

Ц.Сандаг-Очир: Алтангэрэл гишүүний асуултад ажлын хэсгийн 5 номерын микрофон Шадар сайдын ажлын албаны дарга Батбямба.

Б.Батбямба: Батбямба Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Батбямба байна аа. Алтангэрэл гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын хэмжээнд нэг жил гаруйн хугацаанд 10 гаруй мянган шинэ хоршоо байгуулагдаж нийтдээ 850 орчим тэрбум төгрөгийн зээл олгогдсон байгаа.

Зээлийн зориулалтыг бид нар судалж үзсэн. Энэ судалгаан дээр үзэхээр нийтдээ нийт олгосон зээлийн 60 орчим хувь нь үржлийн малд зориулагдаад, бусад нь бусад зориулалтуудаар ингээд олгогдсон байж байгаа.

Өнөөдрийн хугацаанд зээлийн гэрээний дагуу бусад зээл зээлийн эргэн төлөлтийн байдалд бид нар дүн шинжилгээ хийгээд явж байгаа. Яг графикаараа нийтдээ 98 хувийн төлөлттэй явж байгаа өнөөдрийн байдлаар. Тэгэхээр энэ олон зээлүүд одоохондоо эрсдэлд ороогүй байгаа гэж хэлж болно. Өнгөрсөн жил саяын Засгийн газрын тогтоолоор Засгийн газраас болоод Их Хурлын шийдвэрээр үндэсний хороодууд татан буугдсан. Энэтэй холбогдуулаад Шинэ хоршооны хөгжлийг хангах уялдааг хангах үндэсний хороо татан буугдсантай холбогдуулаад нэлээн асуудал яригдсан. Энэ хүрээнд энэ Шинэ хоршооны үндэсний хорооны ажлын албыг татан буулгах асуудал яригдаад энэ олгосон зээлийнхээ эргэн төлөлт бусад зорилгыг одоо хангах хангуулах үүднээс шинэ хоршооны хөгжлийн нэгж гэж тухайн үедээ яах вэ томъёолж байсан. Одоо бол Шадар сайдын ажлын албанд энэ ажлын албаны хүмүүс харьяалагдаж ирээд энэ 9 сарын 1-ээс ингээд үйл ажиллагаагаа явуулаад эхэлж байна. 4.5 тэрбум төгрөг юунд зарцуулахаар төлөвлөж байгаа вэ гэхээр урсгал зардал, цалин хөлсөд 2 сая арай хүрэхгүйтэй төгрөг зарцуулна. Үлдсэн 2 саяыг нь ерөөсөө энэ хоршоог хөгжүүлэх, бойжуулах хоршоонд элсэн орсон малчид тариаланчдыг одоо бас мэдээллүүдээр хангах, гадаад дотоодын хэрэглэгчидтэй холбох, худалдан авагч нартай холбох сургалт мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулах бүсчилсэн болоод бусад хөгжлийн бодлогуудтайгаа уялдуулж авч явахад зориулахаар ингээд тавьчихсан байж байгаа. Бүх зардлууд гүйцэтгэлээрээ холбогдох Сангийн яам болоод Хэрэг эрхлэх газрын төрийн сангийнхны хяналтын дагуу санхүүжилтэд хийгдээд явж байгаа ийм байдалтай байгаа.

Ц.Сандаг-Очир: Болсон уу? Улсын Их Хурлын гишүүн Шижир гишүүн асуултаа асууя.

Ө.Шижир: Өдрийн мэнд. 2026 оны улсын төсөв дээр хөрөнгө оруулалтын төсөв нь нийтдээ 3.2 их наяд байгаа. Гэтэл зөвхөн сум, аймаг НЗДТГ-ын урсгал зардал 2 их наяд байгаа, 2 их наяд. Үүн дотор улсын төсвийн буюу 22 яам, яамны харьяа байгууллагууд буюу УБЕГ, ЦЕГ, боловсролын ерөнхий байгууллагууд, сургууль, цэцэрлэгийн урсгал зардал ороогүй.

Жишээ хэлье. 2016 онд орон нутгийн төсвийн, төсөвт байгууллагуудын буюу сум, аймаг НЗДТГ-ын урсгал зардал 586 тэрбум төгрөг байсан бол өнөөдөр 2 их наяд болж нэмэгдэж байна. 586 тэрбумаас 9 жилийн дотор 2 их наяд болж. Зөвхөн урсгал засвар нь 2016 онд 3.4 тэрбум байсан бол өнөөдөр 30 тэрбум буюу 9 дахин нэмэгдсэн. Хортон шавж устгах зардал нь 1.1 тэрбум байсан бол 57 тэрбум болж 5 мянган хувиар нэмэгдсэн, 5 мянган хувиар. Байр ашиглалттай холбоотой зардалд нь 2800 хувь буюу 4.5 тэрбумаас 132 тэрбум болж нэмэгдсэн. Бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээ 73.7 тэрбумаас 304 тэрбум болж нэмэгдсэн. Бага дүнтэй түргэн элэгдэх бараа материал 133 саяас 4.2 тэрбум болж нэмэгдлээ. Энэ зөвхөн сумын ЗДТГ, аймаг нийслэлийн ЗДТГ, сум, нийслэлийн иргэдийн Хурал, нийслэлийн урсгал зардал.

Дахиад хэлье. Энэ дотор яамдуудын болон яамдуудын харьяа байгууллага, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байгууллагуудын урсгал зардал ороогүй ээ. Гэтэл 2017 онд 944 мянган төгрөг байсан улсын дундаж цалин. Өнөөдөр 2.5 дахин л

нэмэгдсэн. Урсгал зардал нь хамгийн ихдээ 5 мянган хувиар нэмэгддэг буюу 500 дахин нэмэгддэг ийм гажиг тогтолцоо төрийн урсгал зардлыг дагаад бий болсон байна. Манай улс чинь алт, зэс, нүүрс гээд гуравхан бүтээгдэхүүн ихэнх энгийнээр ярих юм бол зарж амьдарч байгаа. Энэ бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр унах юм бол дараа дараагийн жилүүдэд улсын төсвийн орлого чинь урсгал зардлаа дийлэхгүй болох ийм нөхцөл байдал үүсэж байна. 2016 онд улсын төсвийн орлого нь 6 их наяд байсан бол өнөөдөр 33 их наяд болж өссөн. Бараа бүтээгдэхүүний өргөн нэрийн бараа бүтээгдэхүүн нь хамгийн багадаа нэг дахин өссөн. Хамгийн ихдээ 3 мянга дахин өссөн.

Тэгээд бид нар ийм тохиолдолд ямар эдийн засгийн онол ямар сайхан төсөв болсон гэж яриад байгааг би 1 дүгээрт ойлгохгүй байна. Тийм учраас нэг юм асууя. Урсгал зардлаа яг яаж тодорхой бууруулах юм. Энэ эхний асуулт. Үүн дээр тодорхой хэлээч? Би Сангийн яамнаас албан бичгээр 2016 оноос хойш авсан ингээд урсгал зардлууд нь байна л даа. Яг ингээд бүгдийг нь ингээд тоймлож үзлээ. Тэгээд тоймлож үзэхээр ерөөсөө энд буурсан зардал нэг ч байхгүй. Хамгийн ихдээ 5 мянган хувиар өсдөг ийм зардлууд л байна. Тэгээд бид нар энэ дээр одоо яг Сангийн яам нь ямар бодлого бариад байгааг би ойлгохгүй байна. Бид нар чинь мөнгөтэй улс байгаад байна шүү дээ. Мөнгөгүй биш. Яг үнэнийг хэлэхэд маш их хэмжээний мөнгөнүүдтэй тоглож ямар ч үр дүнгүй сүүлийн 10 жил өнгөрсөн байна.

Сүүлийн 5 жилд Монгол Улсын төсөв 135 их наяд төгрөг зарцуулсан. 135 их наяд төгрөг шүү. Өнөөдөр асуудал нь шийдэгдсэн нэг ч салбар ч алга. Асуудал нь дууссан нэг салбар ч алга. Бүгд дахин дахин асуудалтай. Сумын төвийн нэг арваны тавхан километрийг 3 жил дараалж барьж байна. 2024 онд, 2025 онд, 2026 онд. Энэ чинь өөрөө урсгал зардлыг дахиад нэмэгдүүлж байгаа. Тэнд ажиллаж байгаа албан хаагчдын зардал, тэнд ажиллаж байгаа сул зардал. Тэгээд ийм бодлогоор бид нар яах юм. Ийм Сангийн яамны сайн бодлого гэж байдаг юм уу. Энэ чинь Улсын төсвийн орлого чинь 33 их наяд хүрээд урсгал зардал чинь 5 мянган хүн өсөөд, хүмүүсийн цалин чинь дөнгөж хоёр арваны тавхан хувь өссөн байна шүү дээ.

Энд хар дахиад хэлье яамдын урсгал зардал ороогүй тоо шүү.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 8 номерын микрофон Санжаадорж дарга хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя.

Урсгал зардлын зохистой хэмжээний талаар бол анхаарах Сангийн яамнаас бол нэлээд анхаарч байгаа. Ирэх жилийн хувьд бол 24 хувь дээр бол барихаар тооцоолол оруулж ирсэн. Нийт зарлагын хэмжээг бол 32.1 хувь дээр барихаар орж ирсэн. ДНБ-д эзэлж байгаа хувь маань өөрөө бараг 3 орчим хувиар ингээд буурч байгаа. Энэ тохиолдолд нөгөө талдаа энэ хэмжээгээрээ хувийн хэвшилд орон зай гарах болов уу гэж бид тооцож байгаа. Энэ хэмжээгээрээ төрийн зарлага буурсан тохиолдолд мөнгөний бодлогын хувьд бол арай бага хүүтэй зээлийн олдоц бол нэмэгдэх боломжтой болж гарч ирнэ. Энэ хэмжээгээр буурах болж байна. Ерөнхий бүтцийн хувьд бол би гишүүнтэй бол санал нэг байна. Мэдээж хэрэг бууруулахад асар хүнд зардлууд энэ урсгал зардлын бүтцэд өөрөө байж байна. Энэ нь өөрөөр хэлэх юм бол төрийн албан хаагчдын цалин хөлс бол дийлэнх хувийг бол эзэлж байна. Тэтгэвэр тэтгэмжийн зардал мөн дийлэнх хувийг эзэлж байна. Эдгээр зардлуудыг бол бууруулна бид нар эргээд бууруулна гэдэг маш хүнд болчихсон.

Нөгөө талдаа бол тансаглал гэж хэлээд байгаа төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаагаа хангахад зориулсан томилолт зочны зардал ч байдаг юм уу эдгээр зардлууд маш бага болчихсон. Нөгөө талдаа бол барилга байгууламжийн хувьд бол маш олон барилга байгууламжууд нэмэгдэж баригдсаар байгаад энэ дээр тогтмол зардлууд нэлээд өсчихсөн байгаад байгаа. Тэгэхлээр бол бид нар урсгал зардлыг бол бууруулна гэхээсээ илүү хязгаарлах бодлого бол ирэх жилүүддээ барьж явахаас өөр аргагүй болчихоод байна гэж хэлэх гээд байна гэсэн үг.

Зарлагын хувьд томоохон бүтцийн өөрчлөлттэй өөрөөр хэлбэл төрийн албан хаагчдын орон тоог бид нар тодорхой чиг үүргүүдийг хувийн хэвшил гаргах ч байдаг юм уу, ийм том бүтцийн өөрчлөлт хийхгүй бол тэтгэврийн сан дээр жишээ нь хувийн тэтгэврийн энэ боломжийг нээж өгөх, ЭМД-ын сан дээр мөн хувийн тэтгэврийн ийм боломжийг даатгалын боломжийг нээж өгөх ийм том бүтцийн өөрчлөлт хийхгүй бол яг энэ бүтцээрээ бол бид нар цаашаа явж чадахгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр цаашдаа бол зарлагаа бол бид нар хязгаарлах бодлого барина. Ирэх жилүүдээс бол энэ ДНБ-ий 24 хувиас доошоо бид нар аль болох бууруулах бодлого барина. Нэгдсэн төсвийн нийт зарлага 32.1 хувь байгааг бол 2028 он гэхэд бол 30-аас доошоо хувь руу бол бид нар аваачих ийм зорилготой бол ажиллаж байгаа. Тэгэхээр ийм байдлаар бол энэ урсгал зардлыг бол бууруулах ийм макро эдийн засгийн хувьд бол бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна аа.

Ц.Сандаг-Очир: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Энэ аймаг, нийслэл, сум дүүргийн ЗДТГ-ын нийт урсгал зардлын чинь 28 хувийг л цалингийн зардал эзэлж байгаа юм. 60 хувийг нь бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээ, засварт урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардал, байр хувьчлалтай холбоотой зардал бусад зардал ингээд 60 хувь нь эзэлж байгаа юм. Тэгэхээр бид нар ийм үр дүнгүй хөрөнгийг нь гаргаад байна л гэж байгаа юм. Тэгээд сая та тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуулт юм ярьж байна. Би сая орон нутгаар миний нэг минутыг нэмээд өгчхөөч. Амжихгүй байж магадгүй.

Хоёр дахь тодруулга. Би сая орон нутгаар 3 хоног ажиллаад ирлээ. Тэгээд тэнд бол тэтгэмжтэй холбоотой маш их асуудлыг ярьж байна. Тэгээд ахмад настны тэтгэвэртээ гарсан холбоотой тэтгэмжийг 2027 онд хувааж тавиулна гэхээр энэ өөрөө нэг талаасаа хүний эрхийн зөрчил болчихож байгаа юм байна лээ. Яагаад гэхээр бид нар чинь төсөв дээрээ хүн төвтэй төсөв гээд аягүй гоё юм ярьчихсан. Тэгтэл ингээд тэтгэвэрт гарч байгаа ахмадын тэтгэмжийг 2 хуваагаад өгчихөөр тухайн байгууллагадаа орон нутгийн байгууллагадаа хүнд ачаа үүрүүлчхэж байгаа юм байна лээ.

Ц.Сандаг-Очир: 2 дахь тодруулга нэг минут нэмье.

Ө.Шижир: Тэгээд статистик мэдээллийг аваад үзэхээр 2024 онд тэтгэвэртээ гарснаас хойш нийтдээ өнөөдрийг хүртэл бурхны оронд одсон буюу 1446 ахмад байна. Тэгээд ингээд тэтгэмжээ авч чадахгүй та нар 2027 оныг хүлээ гэж байгаа байхгүй юу. 2026 он чинь жоохон хүүхэд шиг тэр хооронд чинь маш олон ахмадууд яг ний нуугүй хэлэхэд бурхны оронд одно. Энэ тэгээд өв залгамжлалын хуулиар зохицуулагдахгүй юм байна лээ. Тэгээд та нар тэр хүмүүсийг яаж байгаа юм зүгээр яаж ийж байгаад 2007 он хүртэл манай хүн төвтэй төсөв гэж хэлж байгаа юм. Ийм

хүн төвтэй төсөв байдаг юм уу? Тэр чинь хуульд заагдсан 36 сар хүртэлх тэтгэмж шүү дээ. Энэ чинь өөрөө хүний эрхийн зөрчил байхгүй юу. Одоо энэ ХЭҮК-оос байна уу? Би асуумаар байгаа юм. Хүний эрхийн үндсэн зөрчил мөн үү гэж. Тэр хооронд бурхны оронд одсон ахмадуудын тэтгэмжийг яах юм аваад үлдэх юм уу. Энэ чинь Өв залгамжлагчийн хуулиар зохицуулагдахгүй юм байна лээ шүү. Тэгээд энэ дээр асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: ЗГХЭГ-ын дарга Монгол Улсын сайд Бямбацогт дарга Шижир гишүүний асуултад нэмж хариулт өгье.

С.Бямбацогт: Тэр сумын ЗДТГ-ын байртай холбоотой асуудал. Шижир гишүүн маш сайн урсгал зардлыг задалж дотор нь ангилж үзсэн байна. Маш зөв. Цаашдаа яг ийм зардлын шинжилгээ хийж үр ашиггүй зардлаа бууруулах, хаанаа юунаасаа болоод энэ урсгал зардлаа би дийлэхээ больчихов гэдэг дээр нэг дүгнэлт хийх цаг болсон. Урсгал зардлын сумын ЗДТГ-ын урсгал зардлын 30 орчим хувь нь л цалин, үлдсэн 70 хувь нь бусдаар үйлс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, байр ашиглалтын зардал гэж байгаа.

Тэр бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээ байр ашиглалтын зардал дээр үндсэндээ бол нэг том байртай тэр том байрных нь цахилгаан дулаан, тэгээд нөгөө цэвэрлэгээ, манаач, үйлчилгээ, жижүүр гээд энэ зардал нь хэт их данхайчихсан ийм л байдаг юм байна лээ. Харамсалтай нь бусдаар л гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ нь суманд нэг томилолтын мөнгө гээд шалиад байх юм байхгүй. Гар утсаар ашигласны мөнгө гэж байдаггүй. Бензин шатахууны мөнгө гэж юу ч байдаггүй.

Ц.Сандаг-Очир: ХЭҮК манай эрхлэх асуудлын хүрээнд орохгүй ээ. Ажлын хэсгийн 8 номерын микрофон нэмж хариулт өгье.

М.Санжаадорж: Гишүүний асуултад хариулъя. 36 сартай холбоотой тэтгэмжийн асуудлыг бол яах вэ өмнө нь эдийн засгийн хувьд бол төсвийн боломж тааруу байсан үеүдэд бол яг энэ арга хэмжээг хэрэгжүүлж байсан. 2017, 2018, 2019 онуудад. Тэгэхээр бол ямар яг ийм нөхцөл байдалд өмнө нь ямар тохиолдол гарч байсан бэ гэхлээр төрийн тусгай байгууллагуудын хувьд бол жаахан энэ нь хүндрэлтэй байдаг юм байна лээ. Ялангуяа одоо үүрэг гүйцэтгэдэг гадаа ажилладаг ийм хүмүүсийн хувьд бол аль болох эрт тэтгэвэрт гарахыг боддог юм байна лээ. Харин оффисын буюу юу багш, эмч бусад оффисын ажилчдын хувьд бол илүү сунгах хүсэлтэй байдаг юм байна лээ. Мэдээж хэрэг бид бол юу гэдэг юм энэ төсөв ингээд батлагдсан тохиолдолд боломжийг нь олгоно. Хэмнэлттэй зардлаасаа шилжүүлэн энэ хүний тэтгэврийг гүйцээж өгөх, эсвэл юу гэдэг юм 2-оос 3 сар хүлээгдэж байгаад сүүлийн хэсгийн хүмүүсийг нь өгөх юм бол мөн бид нар тэгшитгэн хувааж өгөх юм уу эсвэл бүхлээр нь өгч явчхаад ингээд явах ийм боломжуудыг нь бол гаргаж өгнө өө ийм байгаа.

Дээрээс нь бол төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд буюу бүүр сайдынхаа хэмжээндээ хэмнэлттэйүзэх боломжийг гаргаж өгнө өө.

Ц.Сандаг-Очир: Асуулт нь дахиж дутуу байна гэж байна. Гүйцээж хариулъя. Нас барсан улсуудын асуудал ярьж байна. Ажлын хэсгийн 8 номерын микрофон.

М.Санжаадорж: Өргөдлөө өгснөөс хойш тэтгэвэрт гарчхаад 36 сарын тэтгэмжээ авч амжаагүй тийм хүмүүсийн тийм тооны талаар статистик надад бэлэн

алга байна. Бид бол ямар зүйл гарах вэ гэхлээр хэрвээ тушаал гарсан бол тэр тушаалынх нь дагуу бол төрөөс санхүүжилтийг нь өгч л таарна. Энэ бол айхтар хэмнэлтийн бодлого гэхээсээ илүү 24 хувийн нөгөө урсгал зардлын нийт нөгөө таазандаа бид нар тулчхаад байгаа учраас эндээ багтаах л арга хэмжээ авч байгаа. Өөрөөр хэлбэл ирэх жил дээр энэ саяын бууруулж байгаа зардал маань болоод ачаалал болоод ороод ирэх юм байгаа юм.

Тэгээд тэр зардлаар бол бид нар энэ зардлыг нөхөж тавьж өгнө.

Ц.Сандаг-Очир: 2026 онд тэтгэмжийнхээ 50 хувийг авсан хүн нас барчихвал, үлдсэн 50 хувийг нь дараа жил нь олгох юм уу гэж асуугаад байна шүү дээ. Санжаадорж оо тэгсэн үү зөв үү? Харин тийм. Ажлын хэсгийн 8 номрын микрофон.

М.Санжаадорж: Уучлаарай. Тушаал гарсны дагуу бид нар тэр мөнгийг нь бол тэгээд шилжүүлээд л явна. Байгууллагаас бол тухайн хүн дээр бол тушаал гарна. Тэр тушаалынх нь дагуу бол бид нар бол тэр санхүүжилтийг нь бол мөнгийг нь төсөвлөөд л тавья гэсэн.

Ц.Сандаг-Очир: Амьдрал баян яаж ч магадгүй шүү дээ? Тийм учраас ер нь та бүхэн олгоно гэж ойлголоо. Зөв үү?

М.Санжаадорж: Зөв.

Ц.Сандаг-Очир: Зарчмын зөрүүтэй дараагийн 3 дахь хэлэлцүүлэг дээр Шижир гишүүн асуудлаа тавьж болно, олгоно оо гэж байна. Нас барсан хүний данс руу яаж хийх юм, яаж олгох юм? Ар гэрт нь олгох юм уу? Яах юм? Энэ журам юм тодорхой болоогүй байгаа байх тийм үү? Одоохондоо бол. Цаашдаа ийм асуудал гарах юм байна шүү. Санжаадорж дарга аа, Ганбат дарга энийгээ та нар журамлаарай.

Ц.Сандаг-Очир: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Бүгдээрэнд энэ өглөөний мэнд дэвшүүлье. Манай Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд энэ Монгол Улсын Шадар сайдууд тэр дундаа Онцгой байдал асуудал эрхэлсэн Шадар сайд Амарсайхан сайдын асуудал байгаа. Тэгэхээр онцгой байдлынхнаас 2 асуулт асууя. Энэ төсөв ингээд харж байхад юун дээр ОБЕГ-ын хөрөнгө оруулалт их засвар дээр 2025 оноос 2026 оны зөрүү нь 16 тэрбум, 168 сая төгрөг нэмэгдсэн байна. Энэ их засвар дээр ороод явж байна уу эс үгүй бол энэ салбарт нийтдээ орж байгаа хөрөнгө оруулалт уу гэдгийг нэг тодруулаад хэлээд өгөөч. Тэгснээ доод талд нь болохоор ОБЕГ-ын төсөв өнгөрсөн оныхоос 3 тэрбум төгрөгөөр багасаад ороод ирж байгаа юм. Тэгэхээр энэ 2-ын задаргааг нэг хэлээд өгөөч. Онцгой байдлаас болон Сангийн яамнаас ийм зүйл байна уу? Тэгээд энэ юу гэж хэлэх гээд байгаа вэ гэхлээр энэ онцгой байдал дээрээ бид нар ер нь нэлээн анхаарал тавьж өгье өө. Энэ хасагдсан нь ямар юм? Нэмэгдэж байгаа нь тэр тоног төхөөрөмж энэ тэр дээр байна уу үгүй юу. Сая ингээд л улс орон даяараа мэдэж байгаа. Хөвсгөл аймгийн Тариалан суманд 2 настай хүүхэд алга болоод л ингээд л эрэл хайгуул болж байгаад харамсалтай нь бурхан болсон байна лээ.

Тэгэхээр энэ дээр яг энэ онцгой байдлынхны чинь чадвар харагдаж байгаа. Тоног төхөөрөмж нь харагдаж байгаа байхгүй юу. Хөөрхий тэд нар ирээд л байна.

Нохой байхгүй, тоног төхөөрөмж, бензин тос гээд ийм нэг дутуу гацуу байдал чинь ингээд иргэнээ хүүхдээ ингээд эрүүл олоод авах боломжийг тодорхой хэмжээгээр би алдчихсан гэж бодож байгаа.

Тэгэхээр энэ дээрээ хэдүүлээ онцгой юман дээрээ анхаарал хандуулъя аа. Ингээд тэр гал түймэр энэ зунжингаа л Төв аймаг, Сэлэнгэ аймаг ингээд л энэ манай жоохон багахан ой дээр гарлаа. Энд хэрэглэж байгаа тоног төхөөрөмж бас л үнэхээр өрөвдөлтэй л байгаад байна. Тоног төхөөрөмжийн шинэчлэл муутай, ингээд л хэрэглэж байгаа тоног төхөөрөмжүүд нь хуучирсан. Дээрээс нь тендер зарлаад авсан тоног төхөөрөмжүүд нь бүүр хоцрогдчихсон, хүчин чадал болон чанар муутай ийм тоног төхөөрөмжүүд байгаад байна л даа.

Тэгэхээр би энийг яагаад мэдэж байна гэхээр манай тойрогт Сэлэнгэ, Төв, Дархан аймагт Дархан-Уул аймагт нэлээн түймэр гарлаа. Газар дээр нь очоод онцгойгийнхонтой ажиллалаа. Далайн Батбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн бид хэд тодорхой сайн тоног төхөөрөмжүүдийг авч өгөөд ингээд ажиллалаа. Тэгээд ингээд харахаар нөгөө тоног төхөөрөмжүүд нь үнэхээр үеэ өнгөрөөчихсөн, чанаргүй эвдэрчихсэн ийм л байгаад байна. Тэгэхээр тэр онцгой байдлын газрын хөрөнгө оруулалт энэ тэр дээрээ энэ зүйлээ сайжруулах зүйл дээр орж өгсөн үү үгүй юу гэдэг зүйл.

Дараагаар нь энэ нэг усан доор ажиллах хувцас гээд. Хөөрхий Сэлэнгэ аймаг дээр нэг хуучирсан усны гүнд шумбах ганцхан хувцастай. Тэрийгээ ээлжилж өмсөөд ордог гэж байгаа шүү дээ. Нуур голын гүн рүү. Тэгэхээр энэ дээр энэ нэмэгдэж байгаа зүйлээс чинь хөрөнгө оруулалт байдлаар орсон уу гэдэг асуултыг асууя.

Гуравдугаарт нь энэ аймаг дээр нэг эрэн хайх аварга аврах бүлэг гээд нэг гоё нэртэй ийм орон тоотой газрууд байна. Сумд дээр байна. Ийм газрууд чинь ингээд очоод уулзахаар хөөрхий цалин цавууны асуудал нь байхгүй, бас бусад энэ техник тоног төхөөрөмжтэй асуудлууд нь тавигдаагүй байна аа.

Тэгэхээр энд онцгойгоос хүн байвал яг энэ асуудлыг нэг тодорхой хэлээд өгөөч. Эрэн хайх аврах бүлгийн орон тоо нь яг хэд байгаа юм? Улсын хэмжээнд хэд байгаа юм. Эд нар ямар хэмжээний цалин авдаг юм. Ямар урсгал зардал энэ дээр тавигдсан бэ гэдэг асуултууд дээр хариулт авъя.

Ц.Сандаг-Очир: Гишүүний асуултад ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Б.Батбямба: Батбямба Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга байна аа. Би ерөнхий байдлаар хариулъя. Танд нарийвчилсан мэдээллүүдийг одоо ингээд хүргүүлъя. Онцгой байдлын байгууллагаас одоохондоо хүн байхгүй байна. Дарга нь өвчтэй байгаа ийм байдалтай байгаа. Тийм би бол яах вэ ерөнхий хариултуудыг өгч болж байна. Ер нь товчхон хариулахад таны асуугаад байгаа энэ 20 хэдэн тэрбумтай холбоотой асуудал бол 2025 оноос хойш ингээд он дамжаад явж байгаа, онцгой байдлын нөгөө сумдууд дээр байгаа ангиудын барилгын ажилтай холбоотой ийм хөрөнгө оруулалтын зардлууд явж байгаа. Энэ жил бол шинээр Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумд онцгой байдлын байгууллага нь 72 оноос хойш ингээд өөрчлөгдөөгүй, шинэчлэгдээгүй хуучны ийм байшин нөхцөлд ажиллаж үйл ажиллагаагаа явуулж байсныг бол шат шатандаа ярилцаж байгаад эхлүүлж байгаа.

Ерөнхийдөө бол энэ хөрөнгө оруулалтын 5 ийм ажил эхлүүлэхээр яригдсан. Энэний зөвхөн нийт үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтуудыг л бага хэмжээгээр тавьсан. Үлдсэн хөрөнгө оруулалт нь өнгөрсөн жилээс он дамжаад явж байгаа, хөрөнгө оруулалтын ажлын зардал дээр сууж байгаа. Тусгай хэрэгслийн тухайд бол харин харьцангуй. Ер нь өнөөдрийн байдлаар нийт онцгой байдлын байгууллагад хэрэгцээтэй байгаа тоног төхөөрөмжийн хангамж 57 хувьтай байгаа, шаардлагатай байгаа. Энийг бол энэ төсвийн хөрөнгө оруулалтаар шийдэх ямар ч боломж байхгүй. Нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад аваад үзэхээр. Ийм учраас Сангийн яамтай Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр ч гэсэн Засгийн газрын хуралдаан дээр энэ асуудлыг ярилцаад олон улсын зээл тусламжийн хөрөнгө рүү шилжүүлэх асуудлыг ярилцаад АХБ-ны санхүүжилт мөн бусад холбогдох зарим донор орнуудтай зээлийн хэлэлцээр хийж энэ асуудлыг шийдвэрлэх асуудлууд ингээд үе шаттайгаар хэрэгжээд явж байгаа. 57 хувийг энэ ойрын 5 жилдээ бол нэг 80-аас 90 хувьд хүргэх ийм төлөвлөгөө гаргачихсан.

Монгол Улсыг хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр дотроо энэ саналуудаа оруулчихсан явж байгаа. Нийт Монгол Улсын хэмжээнд 330 сум байгаагийн 73 дээр нь өнөөдөр онцгой байдлын байгууллагыг аврах бүлэг эрэн хайх ийм бүлгүүд нээгдэж ажиллаж байгаа. Энэ тоог бид нар ойрын 5 жилийн хугацаанд энэ бусад тооцоонууд дээрээ үндэслээд дор хаяж 3-ны 1-д нь бүтэн хүргэх ийм зорилтууд тавьж байгаа. Энийгээ бол Монгол Улсын хөгжлийн хөгжлийн бүсчилсэн хөгжлийн зорилттойгоо уялдуулаад нөгөө сумдуудыг бид нар хөгжлийн төвүүдээр тодорхойлж 91 нийтдээ Монгол Улсын хэмжээнд хөгжлийн төв байхаар ингэж тооцож ажиллаж байгаа. Энэ дээрээ тулгуурлаад энэний таталцлын сумууд, бусад байршил, хүн амын тоо зэргээсээ уялдуулаад дараа дараагийн шатдаа онцгой байдлын салбар нэгжүүдийг байгуулах ажлууд явж байгаа. Усны хувцасны тухайд харьцангуй хангамж нэмэгдсэн. Арай ч нэг хувцастай байхгүй байгаа. Арай өөр хэлбэрээр сая энэ 8 сард бас Засгийн газрын хуралдаанаас асуудал шийдээд улсын нөөц хөрөнгөөс 6 тэрбум төгрөгийн асуудал шийдэж энэ гал унтраах багаж хэрэгслүүд, энэ усны аврах хэрэгслүүдийг нэмж шийдвэрлэсэн байгаа. Одоо энэ жилийн төсвийн хөрөнгө оруулалт, ирэх жилийн төсвийн.

Ц.Сандаг-Очир: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Сангийн яам энэ нөгөө нэмэгдэл хасагдал 2 дээр нэг нэмээд хариулчхаарай. За яах вэ би Онцгойгийнхныг дэмжиж хэлээд байгаа юм. Тэр нэг хувцас бол байсан. Тэгээд сүүлд нь бид нарт хүсэлт өгөөд Амарсайхан даргад хүсэлтийг нь өргөдлийг нь дамжуулаад нэмж өгнө гэсэн. Тэгвэл өгөгдсөн юм байна. Тэгэхдээ л ер нь дундаа ганцхан хувцастай сууж байгаа Сэлэнгэ аймгийн онцгой байдлын газар гээд л сууж байгаа байхгүй юу. Манай Монголын хамгийн их том гол мөрнүүдтэй газар.

Тэгэхээр энийгээ хэдүүлээ жоохон анхаарвал яасан юм. Сая тэгээд таны ярьж байгаа тоон дотор ч гэсэн 57 хувийн гэдэг чинь тал нь байхгүй л гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ дээрээ хэдүүлээ нэг жоохон анхаараад энэ онцгой дээрээ анхаарахгүй бол саяын Хөвсгөлийн тэр эмгэнэлтэй явдал дээр гэхэд л маш их зардал гарлаа шүү дээ. Яг тухайн үедээ нэлээн өндөр хүчтэй эхний өндөр зохион байгуулалттай, техниктэй, аврах нохойтой ажиллачихсан бол олон хоног ажиллах шаардлагагүй байсан л гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр бас анхаарвал.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 9 номерын микрофон. Сангийн яамны ТНБД Ганбат.

Ж.Ганбат: Би нэмэлт мэдээлэл өгье. Энэ Шадар сайдын ахлах зөвлөх бүрэн мэдээлэлгүй. Энэ дээр арай л өөр ойлголт өгчихлөө дөө. Засгийн газраас Онцгой байдал дээр бүр онцгой анхаарч байгаа шүү дээ. Засгийн газраасаа онцгой байдлын албан хаагчдын цалингийн 40 хувийн нэмэгдлийг энэ онд Монгол Улсын ерөнхий сайд шийдсэн. Энэтэй холбоотой зардлуудыг нь бид бүрэн тусгасан. Нөгөө талдаа 2026 оны төсөв дээр бид нар ОБЕГ дээр сая яг таны ярьдаг асуудлуудыг шийдээд ер нь сүүлийн үед ОБЕГ дээр бид байнга тоног төхөөрөмжийн зардал тэр дутуу юмнуудыг нь дандаа нөхөж юунуудыг бүрдүүлээд онцгой анхаарч байгаа. Ирэх 2026 он дээр 29 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн зардлыг бид нар төсөвт тусгаж өргөн барьсан байгаа. Энэ асуудлаараа бол ер нь бүрэн шийдээд явах бололцоотой гэж үзэж байгаа. Аврах гал унтраах ангийн барилга дээр нийтдээ Хөвсгөл, Хөвсгөлийн Тариалан, Баянхонгор, Өвөрхангай, Завхан дээр гээд энэ барилгуудыг төсөвт өртөг нь 31.2, санхүүжих дүн нь 10.3 гээд энэн дээр бол бас.

Ц.Сандаг-Очир: Нэмж нэг минут өгье. 9 номерын микрофон.

Ж.Ганбат: Ингээд энэ барилга дээр бол 31.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй барилга байгаа. Тоног төхөөрөмж дээр 29 тэрбум төгрөг. Гадаад зээл тусламжаар би 523.8 тэрбум төгрөгийн өртөгтэй АХБ-ны 2 төслийг хэрэгжүүлэхээр тусгачихсан. Энэ бол хэлэлцээр нь хийгдээд энд бүрэн хэрэгжих бололцоотой. Энэ дээр бол Монгол Улсын гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл гээд энэ нь дандаа онцгой байдлын чадавхыг сайжруулах шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг худалдаж авах гэдэг ийм АХБ-ны төслөөр 2 төсөл хэрэгжиж байгаа. Энэ нийтдээ 523 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр ийм.

Тийм учраас ОБЕГ дээр бид нар хангалттай бол ерөнхийдөө Засгийн газрын түвшинд асуудлыг шийдэхээр оруулж ирсэн гэдгийг хэлье.

Ц.Сандаг-Очир: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Ер нь яах вэ 2026 оны Монгол Улсын нэгдсэн төсөвтэй холбоотой энэ асуудлыг ингээд судлаад ингээд хэлэлцүүлгүүдийн явцыг ингээд сонсоод ингээд үзэхээр ер нь манай энэ яг 2026 оны төсөв дээр яг шинэ юм яг юу байгаа юм. Яг ямар асуудлыг шийдчихэв гээд ингээд үзэхээр бол бас нэг тийм дорвитой юм би олж харахгүй л байгаа юм. Нөгөө л нэг жил жилийн төсөв зардал их байна одоо яах вэ? Ингэж явсаар байгаад л батлагдаад л тэгээд л гардаг.

Тэгэхээр энэ удаагийн төсвийн нэг онцлог бол нөгөө ард түмний иргэдийн саналыг авсан гэж байгаа шүү дээ? Тэгээд иргэд бол нэг 4 асуудал дээр анхаараач л гэж хэлсэн юм байна лээ л дээ. Эрчим хүч, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал.

Тэгэхээр бид яах вэ зүгээр 2026 оныхоо төсвийг батлахдаа өөрсдийнхөө бодит нөхцөл байдлаа ард иргэддээ үнэнээр нь хэлээд 4 асуудлыг нь шийдээд. Саяын ярьж байгаа энэ гишүүдийн хэлээд байгаа энэ урсгал зардал, данхар төр байдаг энэ бүх юмнуудаа нэг энэ 2026 ондоо цэгцлээд энэ татвар төлөгчдийн мөнгийг нэг зөв юм руу нь зарцуулдаг нэг ийм реформын шинжтэй төсөв болгочих

бололцоо ер нь бидэнд цаг хугацааны хувьд байна уу, үгүй юу гэж би хэлэх гээд байгаа юм. Одоо ингээд эргээд харахаар төрийн албан хаагчдын цалингийн асуудал шийдэгдээгүй. Нэг ч төгрөгийн нэмэгдэл байхгүй. Эрүүл мэндийн энэ салбар өнөөдөр надаа үйлдвэрчний эвлэлээс нь бичиг ирсэн байна лээ. Цалин цагаан нь хэвээрээ. Боловсролынхон ямархуу шаардлага тавиад сууж байгаа билээ. Цалин битгий хэл нэг ангид далан хүүхэд сууж байгаа ийм нөхцөлд бид нар байж байгаа шүү дээ.

Тэтгэврийн асуудал, нийгмийн хамгааллын асуудал. Эрчим хүч зуны одоо 90 хоног зуны 90 хоногийн увуулж цувуулж тасалсаар байгаад бараг 30 хоногийг нь тоггүй болгочхож байгаа шүү дээ. Яагаад гэвэл шугам засвар. Тийм ч засвар, ийм ч засвар гээд. Тэгэхээр яах вэ зүгээр миний хувьд асуулт асуухаасаа өмнө нэг энэ зүйлийг нэг хэлээд төсвөө бид бас нэг эргээд харвал яасан юм бэ гэсэн нэг ийм санал байгаа. Нөгөө талдаа яах вэ өнөөдөр өргөн баригдсан энэ төсөвтэй холбогдуулаад асуух зарим зүйлүүд байгаа юм.

Хэрэг эрхлэхийн газрын даргаас төрийн албан хаагчдын цомхотгол гээд 9 хувь цомхотгоно гэсэн. Ийм бүдүүлэг цомхотгол цаашаа арай явахгүй юм байгаа биз дээ 2026 онд. Халх хүнийхээ нэрийг явуулчхаарай гэдэг ийм цомхотгол Монголын төрийн албанд явсан шүү. Тэгэхээр 2026 онд энэ цомхотголоо ер нь яаж харж байгаа юм. Та нар 2025 оны төсөв их хэмнэсэн л гэж байна. Яг амьдрал дээр суман дээр яваад очихоор машиндаа хийх бензин байхгүй төрийн албан хаагч нар. Томилолт бүүр ярихгүй. Цалингаас өөр юм байхгүй. Тамгын газар нь суманд ганц байдаг ШТС-дээ өрөнд орчихсон, тэд нарын аманд ороод л сууж байгаа. Тэгээд бид нар төсөв тодотгочихлоо гээд хэмнэчихлээ гэж яриад байгаа юм. Би бол сая сумаараа явсан. Хэнтийн сумдаараа дээр явсан. Батширээт яг л ийм байдалтай. Гутайн давааны хамгаалалтын алба энэ дээр бас яг ийм байдалтай. Энэ бол улс даяар байгаа юуны асуудал. Тэгэхээр ер нь явж явж энэ нэг төрийн захиргааныхан энэ муу хэд ер нь эд нарыг өмөөрч хэлэх хүн байхгүй юм биш гэдэг шиг ингээд нэг ийм юм их явагддаг боллоо.

Тэгэхээр энэ дээр энэ цомхотголоо ер нь цаашид яаж харж байгаа юм гэдгийг хэлэх гээд байгаа юм.

Хоёрдугаарт энэ Тэргүүн шадар сайдын энэ багцад энэ хүрээлэнгийн асуудлууд байна л даа. Би бол бас Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүн. Тэрэн дээр ХААЯ-аас ганц тавьдаг зүйл бол энэ хүрээлэнгүүд энэ академийг яг яамныхаа харьяанд авмаар байна аа. Ингэж байж салбарын бодлого шинэ юм гаргаж ирэх шаардлагатай байна гээд. Тэгээд энэ бол ганцхан ХААЯ биш бусад яамдаас гарч ирээд байдаг байхгүй юу. Тэгээд энийг ингээд Эдийн засгийн хөгжлийн яаман дээр төвлөрүүлснээрээ ер нь ямар үр ашиг гарна гэж ингэж харж байгаа юм бэ гэдэг дээр 2 дахь асуулт.

Дараагийнх нь энэ Шадар сайдтай холбоотой, онцгой байдлын албатай холбоотой асуудлыг сая Туваан гишүүн нэлээн тодрууллаа. 2026 онд салбар нэгжүүд нэмэх үү? Ялангуяа сая Туваан гишүүний ярьж байгаа тэр хангайн сумдууд, ойн түймэр, уул ус, усны үер гээд олон зүйлүүд болдог энэ сумдууд руу.

Ц.Сандаг-Очир: Асуултад Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Төрийн албан хаагчдыг цомхотгох уу 2026 онд үргэлжлүүлээд гэж байна. Цомхотгохгүй. Улсын Их Хурал баталсан 2026 оны жилийн төлөвлөгөөнд төрийн албан хаагчдыг 9 хувиар цомхотгоо гэж Улсын Их Хурал хууль баталсан. Өнгөрсөн 7 сард бас 2025 оны төсөв дээр тодотгол хийхэд төрийн албан хаагчдыг 9 хувиар цомхотгоорой гэж төсвийн тодотгол баталсан. Засгийн газраас хууль хэрэгжүүлдэг байгууллага. Энэ хүрээндээ Улсын Их Хурлын баталж өгсөн хуулийн хүрээнд 9 хувийн цомхотголыг зохион байгуулж үндсэндээ 2025 ондоо дуусаж байгаа. Энэ дээр тэгэхээр юу гэдэг юм холбогдох чиглэлүүдийг өгөөд ажиллаж байгаа. Төрийн албан хаагчдыг ямар нэгэн байдлаар хомруулахгүй. Ажлаасаа гарсан хүмүүсийн оронд хүн нөхөж авахгүй байх, тэтгэвэрт гарсан хүмүүсийн оронд хүн нөхөж авахгүй байх, жирэмсний амралтаа эдэлж байгаа хүний оронд хүн нөхөж авахгүй байх, гадаад дотоодод шилжсэн хүмүүсийг оронд нь хүн нөхөж авахгүй байх ийм байдлаар орон тоогоо шах. Ийм байдлаар зардлаа бууруул. Нөгөө талдаа мэдээж ажлаа хийж чаддаггүй, хариуцлагагүй, бүтээмжгүй, сэтгэлгүй, чадваргүй, хүнд сурталтай ийм хүмүүстэй хариуцлага тооц оо. Иймэрхүү байдлаар л одоо энэ төрийн албыг 9 хувьд одоо зардал бууруулж барих ажлаа зохион байгуул гэсэн чиглэлийг ЗГ-аас холбогдох байгууллагуудад өгсөн. Үүнийг одоо зарим газар улс төрчид нугалаа гаргаж, хоморголох эс үгүй бол ялгаварлах иймэрхүү хандлагууд гарч байгаа юм байна лээ. Үүнтэй холбоотой гомдол санал ирж байгаа. Энэ бүгдийг тухайн шатанд нь шалгалт хийгээд шийдээд хариуцлага тооцох шийдээд явах ийм байдлаар шийдэж байгаа.

Цаашдаа бол төрийн албан хаагчдын гүйцэтгэлийг ил тод болгох. Дарга үнэлэхээрээ сайн гээд үнэлчихдэг, даргадаа тал засаж байгаад ард түмэн үнэлэхээрээ муу үнэлэгддэг. Хүнд сурталтай ажлаа хийдэггүй, ажилдаа ирдэггүй ийм одоо нэг ялгавартай ханддаг байдлыг ард түмнээр үнэлүүлдэг болъёо.

Даргын үнэлсэн бодитой юу бодитой бишийг ард түмнээр хянуулдаг байя. Иргэдийн үнэлгээг сонсдог анхаардаг байя. Ингэж төрийн албан хаагчдыг илүү хяналттай илүү хариуцлагатай, сэтгэлтэй ажилдаа ханддаг байх. Энэ бүтээмжийг нь нэмэгдүүлэх энэ чиглэл дээр тодорхой ажлууд хийж хэрэгжүүлж эхэлж байгаа. Төрийн албаны хуулийн шинэчлэлийг Их Хуралд өргөн барина. Үүнд одоо үүнтэй холбоотой тодорхой зохицуулалтууд орно.

ЗДТГ таны хэлдэг үнэн. Яг үнэндээ урсгал зардал нь ерөөсөө тэр том данхар байрандаа л зарцуулагдаад байгаа юм. Бусдаар томилолтын мөнгө байхгүй, хөдөө гадаа явах бензин шатахууны мөнгө байхгүй. Цалин дөнгөж урсгал зардлынх нь 30 хүрэхгүй хувь ийм байдалтай байж байгаа. Тийм болохоор л бид нар урсгал зардал дээр нэлээн томоохон бас нэг дүгнэлт хийж анхаарахгүй бол ийм одоо урсгал.

Ц.Сандаг-Очир: Нэмж хариулах хүн байна уу? Болсон уу? Эдийн засгийн хөгжлийн яамнаас хэн байна. Ажлын хэсгийн 6 номерын микрофон.

Б.Мөнхтөр: Эдийн засгийн хөгжлийн яам Мөнхтөр. Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Шинжлэх ухааны байгууллагын тогтолцоо өөрөө нэлээн тийм чиг үүргийн хүрээнд нэлээн өргөн цар хүрээтэй ийм тогтолцоо байдаг. Академи харьяа хүрээлэнгүүд мөн тодорхой чиглэлийн асуудлыг хариуцсан судалгааны болон төрийн захиргааны шинжтэй жишээ нь халдварт өвчинтэй тэмцэх гээд. Түрүүнд бас Идэрбат гишүүн дурдаж байна лээ. Энэ чиглэлийн хүрээнүүд байдаг. Ер нь бол

шинжлэх ухааны бодлого төлөвлөлт өөрөө нэгдсэн тогтолцоо байх нь зөв өө гэдэг ийм байр суурьтай бид нарын хувьд байдаг. Зүгээр зарим нэг онцлогтой байгууллага. Жишээ нь Улсын мал эмнэлгийн ариун цэврийн лаборатори зэрэг онцгой чиг үүрэгтэй байгууллага тодорхой чиг үүргийнхээ хүрээнд харьяа юу гэдэг юм яамандаа байх нь одоо ч тийм байгаа. Энэ харьяа байгаа яамандаа байгаа тогтолцооны хувьд зөв гэдгийг хэлэх нь зүйтэй байна аа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Онцгой ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Б.Батбямба: Батбямба Шадар сайдын ахлах зөвлөх. 2026 оны төсөв дээр бид нар 8 шинэ онцгой байдлын аврах бүлгийг 8 сум дээр байгуулахаар төлөвлөж байгаа. Түрүүн хэлсэн. Ингээд бүсчилсэн хөгжлийн нөгөө орон нутгийн хөгжлийн төвүүдтэйгээ уялдуулаад онцгой байдлын салбар нэгжүүдийг байгуулахаар зориод ажиллаж байгаа. Гол хүндрэл нь урсгал зардалтай холбоотой асуудал байгаа. Энэ байгуулж байгаа шинээр байгуулах гэж байгаа 8 онцгой байдлын салбар нэгж бүгд байргүй. Орон нутагтайгаа зөвшилцөөд, орон нутгаас орон байраар хангаад тоног төхөөрөмж боловсон хүчнээ онцгой байдлын байгууллагаас хангаад явахаар харилцан тохиролцож шийдээд ингээд байгуулж байгаа 8 сум байна аа.

Ц.Сандаг-Очир: Идэрбат гишүүн нэмэх үү? Тодруулъя гэж байна Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Тэр төсвийн зардал хянахтай холбоотой асуудал зөвхөн нэг хэдэн хүн халснаар хэдэн хүний оронд хүн авахгүй байснаар болохгүй л дээ наадах чинь. Бид тэр ажлын байрны тэр дахин инженерчлэл гэж яригдаад байгаа тэр зүйлээ хийж байж бид нар уялдуулахгүй бол нэг сумын Төрийн сангийн тасгийн дарга нь тэтгэвэртээ гараад явчхаад тэгээд тэрний оронд хүн авахгүй байх юм уу? Болохгүй биз дээ Санжаа дарга аа. Тэгээд 1 ийм нэг механик юмыг энд ярихаа болих хэрэгтэй. Үнэхээр тэр Тамгын газрын хэн нь илүү үлдээд байгаа юм. Тэрийгээ хүн биш механизмыг нь гаргаж ирэх ёстой байхгүй юу. Тэгэхгүй тэгээд хүний оронд хүн авахгүй би ердөө энийг ойлгохгүй. Би суманд ажиллаж байсан хүн. Мал эмнэлгийн тасгийн дарга нь тэтгэвэртээ гараад явчихвал эсвэл гадагшаа яваад өгвөл яах юм? Өөр тийш шилжээд явчихвал яах юм тэгээд авахгүй байх юм уу? Тэнд тэгээд төрийн ажил яаж явах юм? Тэгэхээр би энийг л хэлээд байгаа юм. Тэгэхээр төрийн цомхотгож болно оо. Жоохон тийм нэг суурьтай, судалгаатай юм хийгээч л гэж би хэлээд байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Идэрбат гишүүн механикаар ойлгож хэрэггүй л дээ. Тэр чинь нэг суманд 21 хүн ажиллаж байгаа, 9 хувь гэхээр 1-2 хүний асуудал яригдана. Тэр хүн тэтгэвэртээ гарвал түүний оронд хүн авахгүй тэр чиг үүрэг дээр нь дотроос нь зохицуулалт хийгээд л шилжүүлэх юм. Энийг тэгэхээр механикаар юу гэдэг юм мушгиж битгий ярь, мушгиж. Ингэж л зохицуулах юм. Цаашдаа бид нар процессыг нь дахин инженерчлэл, саяын ярьж байгаа төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг тийм үү ил тод болгох, Төрийн албаны хуулийн шинэчлэл хийж илүү төрийн албыг цомхон, чадварлаг, илүү бүтээмжтэй ажилладаг, сэтгэлтэй, иргэдийнхээ төлөө, төрийнхөө төлөө илүү сэтгэлтэй ажилладаг ийм одоо бүтэц зохицуулалтыг бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллаж байгаа. Энэ дээр тодорхой ажлууд хийгдэнэ ээ. Нэг дор өргөс авсан юм шиг нэг амьсгаагаар шийдэхгүй. Энийг тодорхой Их Хурлаас баталж өгсөн хуулийн хүрээнд эхлүүлсэн

өгсөн чиглэлийн хүрээнд тодорхой эхний ажлууд хийгдэж байна. Цаашдаа үргэлжлээд олон ажлуудыг.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Төсөвтэй холбоотой би нэг л зүйлийг ер нь бол асуугаад яриад байгаа тиймээ. Надтай адилхан саналтай гишүүд ч гэсэн маш олон байна. Яг энэ төрийн албан хаагчид тэтгэврээ тогтоолгоход төрөөс олгодог нэг удаагийн тэтгэмжийн асуудал. Зарим хүмүүс яах вэ үүнийг яа улс төржүүлж байна төсөв барьцаалж байна гээд манай намын энэ дотоод асуудалтай холбоотой холбож нэг үгүйсгээд байх шиг байна л даа. Тэгээд би Байнгын хорооны даргад нэг хандаж хууль зүйн лавлагаа албан ёсоор авч өгөөч гэдэг ийм хүсэлтийг хэлэх гээд байгаа юм. Яг энэ төрийн албаны тухай хуулийн 9.2, Төсвийн тухай хуулийн 6.4.8-ын заалтыг зөрчсөн эсэх дээр албан ёсны хууль зүйн лавлагаа авч өгөөч гэж. Тэгээд энэ маань өөрөө юу юм бэ гэхлээр төсвийн тухай хуулийн 6.4.8 дээр өр авлага үүсгэж болохгүй гэсэн заалт байдаг.

Тэгэхээр өр авлага үүсгэнэ гэдэг маань 2026 онд 50 хувь нь, 2027 онд 50 хувь нь өгнө өө гэдэг нь яг энэ өр авлага үүсгэж байгаа асуудал мөн. Төрийн албаны тухай хуулийн 9.2 дээр ер нь бол энэ төсвийн аливаа энэ авч байгаа арга хэмжээ, өөрөө яг энэ төрийн албан хаагчдын тэтгэврээ, тэтгэмж нийгмийн хамгааллын асуудлыг хөндөж болохгүй, бууруулж болохгүй, түр зогсоож болохгүй гэсэн ийм хуулийн заалт байдаг. Тэгээд яг энэ 50 хувийг нь олгож байгаа бол 50 хувийг нь түр зогсоож байгаа явдал мөн гэж би үзээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийг Ариунзаяагийн аманд хэлж байгаад нь итгэхгүй байлаа гэхэд надаа нэг тийм албан ёсны хууль зүйн лавлагаа авч өгөөч. Төрийн албаны зөвлөл яг энэ Төрийн албаны хуулийг зөрчиж байгаа гэж үзэж байгаа юу, үгүй юу? Та хэд маань одоо үүнийг хэрхэн яаж авч үзсэн юм бэ гэж хариулж өгөхийг хүсэж байна. Нөгөө талдаа би бас Аудитын ерөнхий газраас яг энэ хуулийн зөрчил байгаа гэж үзэж байна уу үгүй юу? Нэг жилийн төлөвлөгөөнд нийцээгүй байна, бүрэн нийцээгүй байна гэсэн ийм одоо дүгнэлтийг гаргасан байсан. Би зөв ойлгосон уу үгүй юу гэдэг ийм асуултыг тавимаар байна. Тэгээд яг энэ төсөвтэй холбоотойгоор, энэ тэтгэмжтэй холбоотой Сангийн яамнаас өгч байгаа тайлбар нь 2017, 2018, 2019 онд ийм арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан. Та нар ер нь бол тайван бай бид нар тэгж байгаад л яаж ийж байгаад л болгоно шүү дээ гээд байгаа.

Тэгэхээр яах вэ өмнө нь хууль зөрчөөд болж байсан асуудал өнөөдөр бас хууль зөрчиж болгоно гэсэн асуудал огт биш шүү дээ. Тэгэхээр яг үүн дээрээ миний хувьд бол уг нь эргүүлж татаад л энийгээ хуульд нийцүүлээд л өргөн баримаар барьчихмаар байгаа байхгүй юу. Эргүүлээд бидэнд бол ийм боломж байгаа шүү дээ 3 хоногийн дотор эргүүлээд өргөн барих ийм боломж байгаа.

Тэгэхээр зүгээр нэг улс төржүүлээд нэгнийгээ үгүйсгэх биш, харин яг одоо хууль тогтоомждоо нийцүүлээд төрийн аливаа бодлого явагдах ёстой юм гэдгийг онцолж хэлмээр байна. Тэгээд үүн дээр 2 байгууллагаас хариулт авъя.

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах вэ? Үндэсний аудитын газар ажлын хэсгийн 2 номер. Цэдэвсүрэн дарга уу? Аан за.

Л.Цэдэвсүрэн: ТАЗ-ийн дарга Цэдэвсүрэн. Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. 2026 оны төсвийн төсөлд ирэх жилд ер нь 7 мянга гаруй орчим төрийн албан хаагчийг тэтгэвэрт гаргахаар тооцож тодорхой хэмжээний санхүүжилтийн асуудлууд 2 хуваагдаж тавигдахаар байгаа. Тэгээд нэг тоо хэлье гэж бодож байна. Ер нь төрийн албаны 2024 оны албан ёсны статистик тоон мэдээллээр өнөөдөр бол 56-аас дээш насны эмэгтэй 6200, 60-аас дээш насны 1200, нийлбэр дүнгээрээ 7300 төрийн албан хаагч ажиллаж байгаа. Энэ бүх хүмүүсийг 2026 онд тэтгэвэрт шууд гарна гэж бодоход хэцүү байх.

Ариунзаяа гишүүний асуултад хариулахад мэдээж бид нар хууль тайлбарлах эрхгүй төрийн албаны хуулийн 9.2 дээр байгаа энэ төрийн албаны зардлыг бууруулах талаар төрөөс авч байгаа арга хэмжээ нь төрийн албан хаагчид олгож байгаа тэтгэвэр тэтгэмжийг түр зогсоох үндэслэл болохгүй гэдэг нь зөв. Энэ бол зөрчилдөөд байгаа. Нөгөө талаасаа сая тэгээд Төсвийн хуулийн 6.4-өөс гадна 2025 оны төсвийн тодотголыг хэлэлцэж байх үед төсвийн хуульд дахиад нэг өөрчлөлт оруулчихсан. Энэ нь төсвийн захирагч хэрвээ тухайн жилийнхээ төсөв дээр өр авлага үүсгэх юм бол тэр хүнийг ажлаас шууд чөлөөлнө өө гээд. Тэгэхээр энийг маш их асууж байгаа. Ялангуяа төсвийн шууд захирагч нар.

Хэрвээ ингэчих юм бол бид нар бүгд чөлөөлөгдөх юм уу гээд. Тэгэхээр энэ хууль хоорондын нийцлийн асуудлыг эргэж харах хэрэгтэй болж байгаа. Нөгөө талаасаа Төрийн албаны хууль дээр төрийн албан хаагч ингээд өндөр насны тэтгэврээ тогтоолгох үндэслэлээр хэрвээ чөлөөлөгдөх юм бол тэр хүнд нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно оо гэж байгаа. Нэг удаагийн.

Тэгэхээр энийг 2 удаа гэж ойлгох боломжгүй учраас энэ дээр хуулийн зөрчилдөөн гараад байгаа гэдгийг анхаарч одоо энэ төсөв хэлэлцэж байгаа хууль, дагаж байгаа ямар хуулиуд байгаа юм бид нар сайн мэдэхгүй байна. Тэр хуулиуд дээрээ өөрчлөлт оруулах асуудал хийгдэх юм болов уу гэж бодож байгаа. Өмнө нь 2019 он болон түүнээс хойш бат батлагдсан хуулиуд дээр одоо яг ийм нөгөө зөрчилдөөн болон үл нийцлүүд гараад байгаа учраас энийг бол яг нэг талд нь шийдэхгүй бол маш их нөгөө асуулт саналууд бид нарт ирээд байгаа гэдгийг Их Хурлын гишүүддээ хэлэх нь зөв байх гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 4 номерын микрофон. Үндэсний аудитын газар.

Ц.Наранчимэг: Үндэсний аудитын газар Наранчимэг Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Төрийн аудитын байгууллагын барьж байгаа бодлого чиглэл буюу аудит хийхдээ 36 сартай холбоотой асуудлыг үзсэн асуудал нь бид нар Төсвийн тухай хуулийн зарчим, түрүүн төсвийн тухай хуулийн 6.4.8-ыг төсвийг зохистой удирдаж авлага өр төлбөр үүсэхгүй байх ийм төсвийн зарчимтай.

Дараагийн нэг асуудал нь хэрвээ хувааж энэ 36 сарын тэтгэмжийг олгох юм бол Төсвийн тухай хуулийн 70.5 дээр төсвийн захирагч тухайн жилийн төсвийг зохистой удирдаагүйгээс өр авлага үүсгэсэн албан тушаалаас чөлөөлөгдөх үндэслэл болно оо гэсэн энэ хуулийн заалтуудыг баримталж ажиллах ёстой гэсэн ийм дүгнэлтийг хийсэн. Тэгэхээр энэ дээр одоо 50 хувилж өгөхөөсөө илүү бүх шатны төсөв захирагч нар тэтгэвэрт гарах гэж байгаа хүмүүсийн 36 сарын тэтгэмжийг олгохдоо өргөдөл өгсөн хүмүүсээ яг одоо.

Ц.Сандаг-Очир: Нэмж нэг минут. Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Ц.Наранчимэг: Тэтгэмжийг олгох асуудлаа өр авлага үүсэхгүй байхаар нь анхаарч хүмүүсийн авах ёстой 36 сарын тэтгэмжийг 100 хувь олгож ажиллах нь төсөвт захирагчийн өөрийнх нь Төсвийн тухай хуулиар заагдсан бүрэн эрх байгаа гэж ингэж үзэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Сангийн яамнаас хариулт өгөх үү? Тайлбар. Ажлын хэсгийн 9 номерын микрофон.

Ж.Ганбат: Бид 2026 оны Төсвийн тухай хуулийг дагалдуулж энэ Төрийн албаны хууль болон энэ 36 сартай холбоотой ямар нэгэн хууль өргөн мэдүүлээгүй байгаа. Нөгөө талдаа яг төсөв дээр бид энэ 50 хувийг нь заавал энэ онд өгөөд л 50 хувийг нь дараа өгнө гэдэг байдлаар ийм байдлаар уг нь хандаагүй шүү дээ Ариунзаяа гишүүн ээ. Бид ямар байдлаар хандсан гэхээр Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд төсвийн ерөнхийлөн захирагч төсөвтөө багтааж зохицуулна гэдэг. Бид нар батлагдсан дүндээ багтаагаад хүмүүсээ тэтгэвэр тэтгэвэртээ гаргаж болно. Дахиад нэмэлт эх үүсвэр шаардлагатай бол төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрсдөө төсөв дотроо зохицуулалт хийгээд хүмүүсээ тэтгэвэрт гарах нь нээлттэй шүү дээ. Угаасаа хүсэлтээ өгөөгүй мөртөө оны дундуур хүн тэтгэвэртээ гаръя гэж хэлэхэд тэр хүний хүсэлтийг нь хангуулаад төсөв дотроо бид нар тухайн төсвийн байгууллага өөрөө зохицуулаад гаргах бүрэн бололцоотой.

Нөгөө талдаа Улсын Их Хурлаар төсөв өөрөө хууль болоод батлагдаж байгаа. Энэ хуулийг бүгд хэрэгжүүлэх ёстой. Тэрнээс биш өр авлага үүсгэхгүй хэрэгжүүлэх ёстой. Бид төсвийн сахилга батыгаа хангуулахын тулд саяын төсвийн тодотгол дээр.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: 2 эмэгтэй даргадаа баярлалаа. Та бүхэн маань яг л үнэн бодит байдлыг хэллээ. Төрийн албаны тухай хуулийн 9.2, Төсвийн хуулийн 6.4.8-аас гадна 70.5 дээр бол анхаарах ёстой гэдгийг бол хэллээ. Ганбат дарга аа. Би зохиогоогүй шүү дээ. Энэ төсвийн номон дээр чинь байгаа 46 дугаар хуудсан дээр нь бүүр өгүүлбэрээрээ байгаа. 50 хувилна гэдэг нь байгаа шүү дээ. Ер нь тэтгэвэрт гарч байгаа хүмүүс чинь хүсэлтээ өгөөд яам яамаараа дамжуулаад төсвөө оруулдаг юм шүү дээ. Яам болгоноос ирүүлсэн тэр хүсэлтийг нь та нар 50 хувилсан л байхгүй юу даа. Одоо энд хариуцлагатай хүмүүс нь худлаа яриад яах вэ дээ. Тэгээд энэ хуулиудыг зөрчсөн эсэх, хууль зүйн цаасан дээр лавлагаа хэрэгтэй байна дарга аа. Тэгж байгаад үүнийг хэлэлцээд ярьсан нь зүйтэй байх аа. Ер нь төрийн албанд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын тэтгэмждээ санаа зовж байгаа бол Улсын Их Хурлын гишүүд яаж ч байсан энэ төсөв энэ бол бүрэн дүүрэн тавина гэдэгт нь бол итгэлтэй байгаарай битгий санаа зовоорой гэдгийг хэлмээр байна.

Ганбат даргын хэлж байгаа нэг үнэн юм юу вэ гэхлээр Төрийн албан хаагчдын тухай хуулийг бол өөрчлөхөөр энэ удаагийн хууль дээр бол Төсвийн хуулийг дагалдуулж өргөн бариагүй.

Ц.Сандаг-Очир: Сангийн яамны байр суурийг ойлгоод байгаа. Тухайн байгууллагад ирэх жил 2 хүн тэтгэвэрт гарахаар байдаг. Төсөв нь нэг хүнээр ирчхээд байдаг. Тэгвэл 1 хүнийг нь гаргаад, нэг хүнийг нь гаргахгүй ажиллуулж

болно. Тэгээд дараа 27 онд нь нэг хүнийг нь бүтээгээд ер нь гэх мэтчилэн зохицуулалт хийх боломж нь байгаа гэж ойлгоод байгаа зөв үү? Энэ дээр нэг ажлын хэсгийн 9 номерын микрофон.

Ж.Ганбат: Яах вэ сая таны хэлдгээр тийм зохицуулалтыг хийх бүрэн бололцоотой. Тэрнээс биш юу гэдэг юм нэг хүнийг гарахад энэ ондоо 50 хувиа аваад ирэх жил үлдэгдэл 50 хувиа ав гэсэн энэ ойлголт биш. Бид бол Ариунзаяа сайдын тэр гишүүний хэлээд байгаа дээр эх үүсвэрийг нь л бид юу гэдэг юм төсвийнхөө боломжид уялдуулаад л тавьсан. Энэ дундаа багтаад гараад 1-д.

Хоёр дахь нь Ариунзаяа гишүүн ээ нэг ийм асуудал байгаа шүү. Одоо бол нийтлэг тэтгэврийн доод насанд хүрсэн хүмүүсийг гарга гэж шахаж байгаа шүү. Бид бол тэрийг аль болох доод нас биш, хүсвэл доод насандаа гарна гэдэг тийм асуудал яригдаж байгаа шүү дээ. Бид бол хүсвэл тэр хүн өөрөө төрийн албан хаагч байна уу, хүсвэл гаргая гэдэг ийм л байр суурь Сангийн яам барьж байгаа.

Тэрнээс хүсээгүй байхад нь бид гаргая гэдэг байдлаар хандаагүй шүү.

Ц.Сандаг-Очир: Тодруулга нэг минут. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Ганбат дарга баярлалаа. Хөдөлмөрийн тухай хуулиар тэтгэврийн нас нь болсон бол тэтгэвэрт гаргах санаачилгыг ажил олгогч гаргаж болохгүй гэдгийг заагаад өгчихсөн байгаа шүү. Тэгэхээр ямар нэгэн байдлаар энэ төрийн цомхотголтой холбоотойгоор таныг тэтгэвэрт гарахыг шаардаж байгаа бол ямар нэгэн байдлаар албан шахаж байгаа бол энэ чинь хууль бус шүү гэдгийг төрийн албан хаагчдадаа мэдээлэл болгоё оо.

Тэгэхээр ирүүлсэн төсөв бол тэтгэмжийн авах өргөдлөө өгсөн хүсэлтийг гаргасан төрийн албан хаагчдын хувьд төсвийн эх үүсвэрийн 50 хувийг нь л тавьж өгч байгаа. Тэгэхээр дотроо тэгээд л түрүүлж төрсөн, хойно төрсөн, болно, болохгүй гээд л бөөн л юм болох юм байна л даа. Тэгээд яагаад төрийн албан хаагчид ийм их өргөдлөө өгчхөв өө гэхлээр төр өөрөө ийм дохио өгчхөж байгаа байхгүй юу. 36 сарын тэтгэмжтэй чинь холбоотой бид нар ер нь бол манай бодлого алсдаа нэг иймэрхүү байж магадгүй шүү гэдэг дохиог сүүлийн 3 сарын хугацаанд 3 дахь удаагаа өгч байгаа байхгүй юу. Тэгэхээр бүгдээрээ гарах хүсэлтээ гаргаж гаргаж байгаа нь бол яахын аргагүй ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа юм.

Тэгэхээр одоо нэг нэгэндээ ухаантай царайлж юм шидээд яах вэ дээ. Би бол зүгээр уншсан юмаа л ярьсан. Та бүхэн маань тавьсан төсвөө ч гэсэн ярилаа. Тэгээд хууль зөрчсөн үү, үгүй юу гэдэг дээрээ сууриалаад төсөв дээр бид нар ажлын хэсгийнхээ хүрээнд эх үүсвэрийг нь бүрэн тавих юм уу, эс үгүй бол хууль нь эргээд хуульд нийцэж эргэж орж ирэх юм уу гэдэг л ийм л 2 сонголт байна л гэж ойлгож байгаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: 2 асуулт байна.

Нэгдүгээрт нь ОБЕГ-аас асуулт асуумаар байгаа юм. Угаартах гэдэг нь өөрөө гамшиг гэдэгт орох уу гэдэг асуудал байгаа. Яагаад би энийг асууж байгаа вэ гэхлээр угаартахгаас гадна энэ байгалийн гамшиг ер нь гамшиг ослын онцгой нөхцөл

байдлын үед хамгийн их түрүүлж хохирдог бүлэг бол ахмад настан. Сонсгохгүй, харахгүй байгаа хүмүүс эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байгаа. Өнгөрсөн хэдэн сард билээ ордон дээр нөгөө гамшгийн нэг дадлага болсон шүү дээ. Тэгээд гишүүд ингээд чуулганы танхимд бүгдээрээ хуралдаж байтал яаралтай гарах хэрэгтэй болоод цугларах цэгт гарна уу гээд дуудсан. Аль хаалгаар яаж гарах мэдээллийг нь ойлгож гарах гэсээр байтал би яваад очиход тэр уулзалт нь ингээд дуусчихсан. 30 минутын дотор очиж амжаагүй гэсэн үг. Тэгэхээр энэ байдлаар би үхчихсэн байгаа гэсэн үг. Тэрүүгээр бол. Тэгэхээр Монгол Улсад ер нь энэ гамшиг ба хөгжлийн бэрхшээлийн асуудлаар тайлан мэдээлэл ер нь байдаг юм уу? Би төсөв дээр угаасаа ийм зүйл харахгүй л байгаа.

Тэгэхээр энэ дээр яг энэ байнгын хороон дээр орж ирснийх энэ хүмүүстэй уулзаж байгаагийнх энийг асууя гэж бодож байна.

Хоёрдугаарх нь ТА3-өөс асуулт байна. Яг төсөвтэй холбоотой энэ хөрөнгө ашиглалтын менежмент гэж 593.1 сая гэхчихсэн. Энэ яг энэ дотор яг юу байдаг юм бэ. Энэний зардлыг энэ дээр яг юу хийнэ гэсэн үг вэ гэдгийг нэг тайлбарлаад өгөөч гэсэн асуулт байна. Тэгээд мөн төслийн 1 дүгээр хавсралтын 13.1 дээр заасан хэд хэдэн зүйл байгаа. Төрийн албан хаагчдын ёс зүйн индексийг нэвтрүүлнэ. Ер нь төрийн албан хаагчтай холбоотой байна л даа. ТА3 хэдэн хүнтэй вэ гэдгийг хариулмаар байгаа юм. Тэгвэл бид нар Хөдөлмөрийн хуулийн 144 дүгээр заалтын тухай ярьж болох гээд байгаа байхгүй юу.

Танай дээр хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байгаа юу? Ажил хайж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс маш их байгаа. Төрийн алба ерөөсөө авахгүй байна, гадуурхаж байна, ялгаварлан гадуурхаад байна, чадахгүй байна, сонсдоггүй, хардаггүй, муухай ааштай гээд ингээд ажилд авахгүй байгаа хүсэлтүүд маш их ирж байгаа иргэдийн. Тэгэхээр төрийн алба өөрөө ер нь энэ албан хаагчдынх нь сургалт, шалгаруулалт тэгээд шалгалтын одоо тэр материал дотор жишээлбэл энэ хүний эрхийн асуудлууд ер нь яаж тусгагдаж байгаа юм. Сорилын санг шинэчилнэ гэсэн байна. Энэ дээр жишээлбэл яг энэ хөгжлийн бэрхшээлтэй хүн хүртээмжийн асуудлууд яг хэдэн сорил яаж тусгаж байгаа тухай мэдээлэл авмаар байна.

Ерөөсөө л энэ дээр ажил хийхгүй байгаа чинь нэг талдаа хөгжлийн бэрхшээл биш, иргэд өөрсдөө төрийн алба нь өөрсдөө тэр хүмүүсээ авахгүй байна шүү дээ. Энэ нь бүх шатдаа байна. Тэгэхээр энэ дээр би нэг тоймтой хариулт төлөвлөгөө авчхаад дараа нь тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Б.Батбямба: Саранчулуун гишүүний асуултад хариулъя аа. Шадар сайдын ахлах зөвлөх Батбямба. Би мэргэжлийн хүн биш. Тэгэхдээ яах вэ энэ салбарыг хариуцаж ажиллаж байгаа Шадар сайдын зөвлөхийн хувьд бол Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд яг энэ угаартахтай холбоотой асуудлыг гамшиг гэж үздэггүй ээ. Гамшгийн тухай ойлголт бол арай жаахан өргөн хүрээнд байгаль орчин, хүний амь настай холбоотой ийм их хэмжээний хохиролтой холбоотой ийм тайлбар мэдээллүүд байдаг.

Угаарын хордлогоос урьдчилан сэргийлэх 100 хувь урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой байдаг. Тийм учраас яг нэг ахуйн хүрээнд гэх юм уу иймэрхүү байдлаар угаартаж байгаа асуудлыг гамшигт оруулж тооцдоггүй ээ. Ер нь

урьдчилан сэргийлэх чиглэл дээр бол онцгой байдлын байгууллага дээр жилд 1-ээс 1.2 тэрбум төгрөгийн төсөв урсгал зардал дээр нь суулгаж явдаг. Энэ зардал бол ерөнхийдөө олон нийтэд хандсан яг энэ гамшиг ослын үед урьдчилан сэргийлэх чиглэлийн арга хэмжээнүүдийг хэрхэн яаж авах вэ? Хүний амь нас аврах хиймэл амьсгал бусад байдлаар ус болон бусад бусад гамшгийн үед яаж урьдчилан сэргийлэгч ажиллах вэ гэдэг энэ сургалт мэдээллийн ажилд бол зарцуулагддаг. Шаардлагатай зардал хаана нь ч хүрдэггүй гэдгийг бүгдээрээ мэддэг тэгээд бусад олон нийтийн байгууллагууд болон МУЗН-үүд, тэгээд аймаг орон нутгийн нутгийн захиргааны байгууллагуудтай хамтраад энэ ажлыг хийгээд явдаг.

Нийт батлагдаж байгаа төсвийн нэг хувиас доошгүй хэмжээний төсөв энэ бол энэ урьдчилан сэргийлэх зардал дээр суугдах ёстой байдаг юм. Гамшгаас урьдчилан сэргийлэх зардал дээр. Энийг бол ерөнхийдөө аймаг орон нутаг дээр нэг ч төгрөг энэ дээр тавьж чаддаггүй. Нэр төдий нэг 5, 10 сая төгрөг тавиад тэрийгээ урьдчилан сэргийлэх чиглэлийн ажил гээд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэйгөө хамтраад нэг тийм хөрөнгө мөнгөгүйн зовлон дээр тулгуурласан. Тэгэхдээ яах вэ олон нийтийн оролцоо цаана нь байдаг учраас ямар ч байсан энэ төрлийн ажил тасралтгүй явагддаг. Онцгой байдлын байгууллагаас мэргэжил арга зүй арга зүйн удирдлагаар олон улсын хамтын нийгэмлэгтэйгээ хамтраад Монгол Улсын хэмжээнд урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол үе шаттай зохион байгуулж явж байгаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 2 номерын микрофон.

Л.Цэдэвсүрэн: Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

ТАЗ-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв 2 байгууллагын төсөв гэдгийг гишүүд маань ойлгож байгаа. Нэг нь Төрийн албаны зөвлөл. Нөгөөдөх нь Ёс зүйн хороо. Хоёулаа биеэ даасан хуулийн этгээдийн чиг үүрэг хэрэгжүүлдэг. Хөрөнгө ашиглалтын менежментийг бид нар анх удаагаа 2026 оны төсөв дээр тавьж өгч байгаа юм. Яагаад вэ гэхээр 2020 оноос хойш манай ТАЗ-ийн явуулдаг гол чиг үүргийн нэг болох сонгон шалгаруулалтын техник тоног төхөөрөмж бол маш их элэгдэлд орсон. Шинэчлэл хийгдээгүй 2020 онд төслийн хүрээнд 20 компьютер анги танхим сайжруулсан байдаг. Энийг бүхэлд нь шинэчилж сайжруулахгүй бол сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд нэлээн энэ техник тоног төхөөрөмжтэй холбоотой асуудлууд үүсээд байгаа юм аа.

Нөгөө талаасаа төрийн албаны цахимжилтын үйл ажиллагааг дэмжихэд бид нар яг үнэндээ өөрийнхөө байгууллага Ёс зүйн хорооноосоо энийгээ.

Ц.Сандаг-Очир: Нэг минут.

Л.Цэдэвсүрэн: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд 2 байгууллага нийлээд 78 хүнтэй. Төрийн албаны зөвлөл 56, Ёс зүйн хороо 17. Одоогоор бид нарт 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэн манай байгууллагуудад ажиллаж байгаа. Ер нь Монгол Улсад нийт хөгжлийн бэрхшээлтэй 5 мянга гаруй иргэн төрийн албанд ажиллаж байна. 5800 гаруй. Тэгээд бид нар энэ төрийн албан хаагчдыгаа дэмжих, ялангуяа төрийн албанд, ялангуяа бүр төрийн захиргааны албанд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулахад дэмжих зорилгоор энэ сонгон шалгаруулалтын тестийн сан болон шалгалт өгч байгаа орчин нөхцөлийг сүүлийн 2, 3 жил нэлээн сайжруулж чадлаа. Энэний хүчинд бол ямар ч байсан хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн төрийн захиргааны албаны тусгай шалгалт өгөх тоо хэмжээ их хэмжээгээр нэмэгдэж байгаа.

Тэгээд таны хэлсэнчлэн ТЗ-д энэ хүмүүсийг авах нь, ажилд авах нь жоохон учир дутагдалтай байгаа гэдэгтэй санал нийлнэ ээ.

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу? Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Баярлалаа. Би яг тодорхой л асуучихмаар байна. Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд энэ хүртээмжийн журам гэдэг яг ийм бодлого байгаа юу? Цаасан дээр хүмүүст хүргээд бид нар ингэдэг юм гээд. Би жишээлбэл тэр зааврыг авахдаа алхаж, явж, салгалж явж, дээш доошоо явсаар байгаад тэгээд тэр хэрэг болох юм бол би явчихлаа шүү дээ. Тэгэхээр над шиг хүмүүс байна, надаас хэцүү ч хүмүүс байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хүмүүст онцгой байдлын үед авах арга хэмжээний журам дүрэм ер нь юу байгаа юм бэ? Би санаж байна. Цар тахлын үеэр хамгийн хүнд хэцүү хүмүүс гэртээ ганцаараа байсан ахмадууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шүү дээ. Тэгэхээр энэ дээр ямар ч бодлого байхгүй байна гэдгийг олон улсын нөгөө дараа нь нэг хэсэг нь судалгаан дээр гаргаж байсан байхгүй юу. Яг тэр өгүүлбэрийг хэлмээр байгаа юм. Дахиад тодруулъя.

Төрийн албаны шалгалтын сан дээр хөгжлийн бэрхшээлтэй хүн ер нь энэ хүртээмж хүний эрхийн сангийн талаарх шалгалтын агуулгыг тэр сорилын санд оруулах уу? Хир их юм оруулах вэ гэдэг дээр бүр нэг тойм тойм мэдээлэл. Авчихмаар байх юм.

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Б.Батбямба: Журам байлгүй яах вэ.

Энэ журмуудыг энэ ААН байгууллагууд хуулийн этгээдүүд нь бүгд өөрсдөө дагаад мөрдөөд явж байх ёстой. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг урьдчилаад холбогдох яг энэ ажлыг хариуцсан албан тушаалтнууд хангалттай сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулдаг. Тэгээд одоо жишээ нь энэ Төрийн ордон дээр бол Улсын Их Хурал ЗГХЭГ-ын холбогдох албан тушаалууд төрийн ордны захиргаанаас яг энэ журмыг бүх байршлууд дээр орц гарц аюул тохиолдсон үед гамшиг ослын үед аюулгүйн гарц гаргалгаа бүх юмыг энд ажиллаж амьдарч байгаа, ажиллаж байгаа бүх хүмүүст бүгдэд нь хүргэж энэ мэдээллийг ажилласан байх ёстой. Онцгой байдлын байгууллага энэ дээр нь боо нэмэлт одоо арга зүйн дэмжлэг үзүүлээд хамтарч ажилладаг. Бусад байгууллагууд дээр бол бүр гэм гэмт хэрэг зөрчил, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг гаргаад тэрийгээ бүх байгууллагынхаа алба хаагчдадаа танилцуулаад, бусад байдлаар тухайн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдэд ойлгомжтой байдлаар байршуулж байна.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 2 номерын микрофон ТА3.

Л.Цэдэвсүрэн: Нэмэлт тодруулга өгье. Одоо манай байгууллагын төстийн санд ерөнхий шалгалт болон тусгай шалгалтын санд хүний эрхийн боловсролтой холбоотой төстийн өгөгдлүүд байгаа. Бид нар энийгээ шинэчлэх зорилгоор ялангуяа сүүлийн жилүүдэд хийгдэж байгаа энэ хууль тогтоомжтой уялдуулаад хүний эрхийн комисстой хамтраад 150 шинэ төстийн асуулгуудыг гаргаад энийгээ хянан шалгах ажлууд явж байна.

Тэгэхээр энэ маань бол бүх төрийн албан хаагчдад хамаатай тестийн сан гэсэн үг. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусгайлсан тийм тестийн сан байхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг яагаад төрийн албанд илүү түлхүү оруулах гээд байгаа юм гэхээр тэр хүмүүсийн ерөнхий болон тусгай шалгалт өгөх тусгай танхим барель үсгийн ч юм уу ийм тестүүдийг хийж өгдөг юм. Тэр нь нийтлэг том тестийн сангаасаа түүврийн маягаар авдаг болохоос биш хөгжлийн бэрхшээлтэй хүнд тухайлан зориулсан тусгай тестийн сан байхгүй гэдгийг гишүүнд хэлье ээ.

Ц.Сандаг-Очир: 2 дахь нэг минут. Тодруулга Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Буруу ойлгоод байна шүү. Яах вэ ингэх гээд байгаа байхгүй юу. Төрийн албанд ажиллаж байгаа бүх хүн төрийн албаны ажилд шалгалтад орохдоо хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж хэн юм, тэгээд үндэсний цөөнх гэж юу юм, ахмад хүний асуудал ямар байдаг юм, хүүхэд, эцэг эхчүүд ер нь энэ хүнтэй ажиллахдаа хүний эрхийн мэдрэмжтэй байх тухай асуудлыг би яриад байгаа байхгүй юу. Тэрнээс биш хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авахтай холбоотой шалгалттай холбоотой асуудлыг би ойлгож байна аа. Тэгэхээр та хэд маань энэ дээр жишээлбэл ямар ч хамаагүй захын нэг хүн төрийн албанд ажилд орох гээд шалгалт өгөхөд тэр тусгай байна уу ерөнхий байна уу шалгалт дотор энэ асуудлууд байх ёстой. Одоо байгаа шалгалтын сорилын санг харахаар маш олон асуудлууд байгаа. Монгол бичиг, Монголын түүх зарим нь ямар хэрэгтэй юм гэмээр асуултууд байна шүү дээ. Цээжлээд ингээд орчихдог. Тэрний оронд л энэ жоохон ийм хүний эрхийн мэдрэмжтэй төрийн албыг хөгжүүлэх бодлоготой чинь холбоотой асуултууд баймаар байгаа байхгүй юу. Энэ талаас нь та нар ойлгож авах хэрэгтэй шүү.

Ц.Сандаг-Очир: Санал хэллээ. Саранчулуун гишүүн асуултаа асууж хариултаа авч дууслаа. Одоо Чинбатын Номин гишүүн асуултаа асууя.

Ч.Номин: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Би өнөөдөр хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар 2 асуулт асууна.

Нэгдүгээрт энэ хөрөнгө оруулалттай холбоотой. Би энэ асуудлыг хөндөхдөө энэ аудитын дүгнэлт дээр суурилж хөндөж байгаа. 1 дүгээрт төсвийн төслийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан улсын хөгжлийн нэг жилийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхэд чиглэсэн байхыг энэ заалтыг хангаагүй гэдэг дүгнэлт гарсан.

Өнөөдөр бид бүхэн хөрөнгө оруулалт дээрээ нийт хөрөнгө оруулалтынхаа 25 орчим хувийг шинэ төсөл арга хэмжээ оруулж ирж байгаа. 2.2 их наядын төсөвт өртөгтэй нэг орчим их наядын санхүүжих дүнтэй. 149 төсөл арга хэмжээ орж ирж байгаа. Энэ 149 төсөл арга хэмжээнээс хэд нь хөгжлийн төлөвлөгөөнд нийцээгүй 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцээгүй төсөл арга хэмжээ байгаа вэ гэдгийг үнэн бодитоор хариулж өгнө үү. Төрийн албан хаагчид маань бодит мэдээллийг өгөх үүрэгтэй байгаа гэдгийг сануулъя.

Хоёрдугаарт болохоор энэ аудитын зөвлөгөөн дээр гарсан. ЭМД-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т ЭМД-ын эрсдэлийн санг ЭМД-ын сангийн тухай тухайн жилийн орлогын 10 хувьд хүрэхээр хэмжээгээр байгуулах ёстой гэсэн энэ

заалтыг мөрдөөгүй байна гэж байна. Бидний хувьд мэдэж байгаа амьдрал баян. Дахиад ковид шиг дахиад ийм томоохон эрсдэл бүхий зүйлүүд гарч ирвэл энэ тохиолдолд яах вэ? Нөөц сангаасаа байнга авдаг. Нөөц сангаа 9 шидийн юманд зарцуулдаг. Тэгэхээр энэ тохиолдолд яаж энэ эрсдэл болзошгүй зүйлсийг хамгаалах гэж байгаа вэ гэдэг ийм 2 асуулт байна.

Тэгээд би эргээд асуултаа хариулсных нь дараа тодруулга хийе.

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах вэ? Номин гишүүний асуултад хэн хариулах вэ? Хаанах ажлын хэсгийн 5 номерын микрофон.

Ю.Энхтуяа: Аудитын газар Энхтуяа. Гишүүний асуултад хариулъя аа. Аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 оноос эхлэн хэрэгжүүлэх 149 төсөл арга хэмжээний 87.9 хувь нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдсан. Үлдсэн нь уялдаагүй гэсэн дүн дүгнэлт гарсан. Манай аудитын тайлангийн хавсралтад 18 төсөл арга хэмжээ бол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй гэсэн жагсаалтаар төсөл арга хэмжээний нэрийг үзүүлсэн байгаа.

Ц.Сандаг-Очир: Хоёр асуулт асуусан гээд байна.

ЭМД-ын сангийн энэ чинь хэн хариулах юм? Нийгмийн бодлогын байнгын хороонд л харьяалалтай даа. Та ахиад асуултаа тодруул даа. Номин гишүүний микрофоныг өг дөө.

Ч.Номин: Аудитын дүгнэлт дээр ЭМД-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т ЭМД-ын эрсдэлийн санг ЭМД-ын сангийн тухай хууль тухайн жилийн орлогын 10 хувь хүртэл хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна гэсэн. Энийгээ байгуулаагүй энийгээ төсөвтөө суулгаагүй орж ирсэн байна аа. Тэгэхээр одоо эрсдэл гарах дахиад ковид шиг зүйлүүд гарч ирэхэд ийм тохиолдолд яах вэ? Дандаа одоо ингээд нөөц сангаасаа зарцуулалт хийгээд яваад байх юм уу? Яагаад энийг байгуулаагүй юм бэ? Хууль зөрчиж байна гэсэн үг шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Сангийн яам. Ажлын хэсгийн 8 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя аа. ЭМД-ын сангийн төсвийг бол ерөнхий байдлаар нь буюу том дүнгээр нь Улсын Их Хурал дээр баталж байгаа. Тэгээд ЭМД-ын Үндэсний зөвлөл гэж байгаа. Зөвлөлийн дарга нь бол Эрүүл мэндийн сайд байгаа. Тэр зөвлөл дээр бол нарийвчилсан байдлаар бол төсвийг нь баталж байгаа. Тэнд бол тэр санг бол хуульд нийцүүлж байгуулах ёстой. Гэхдээ ер нь зүгээр надад байгаа мэдээллээс харахад бол ЭМД-ын сан маань өөрөө бол сан байгуулж тусдаа төсөв тусгаарлаж авах байтугай өөрөө сан нь өөрөө өрөнд орчхоод явж байгаа. Энэ жил дахиад өртэй орно оо гэдэг ийм зүйл ярьчихаад байгаа сан шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Хоёр дахь тодруулгаа авъя.

Ч.Номин: Би Аудитын ерөнхий газар руу энэ хөрөнгө оруулалтын талаар мэдээллийг авахаар хүсэлтийг өгсөн байгаа. Та бүхэн мэдээллээр хангах ёстой одоо болтол ирээгүй байгаа. Тэгээд энэ мэдээллээ 24 цагийн дотор ирүүлэхийг хүсье. Сая дутуу тоо хэлж байна. Бид нар дүн шинжилгээ хийсэн байгаа. Тэгээд тоонууд зөрж байна гэж үзэж байна. Миний мэдэж байгаагаар яг өнөөдрийн

байдлаар гэхэд соёл, спорт, аялал жуулчлалын салбар дээр хөгжлийн төлөвлөгөөнд орсон Хүүхдийн номын сан, хүүхэлдэйн театрын төсөв хасагдсан мөртөө хөгжлийн төлөвлөгөөнд ороогүй. Баян-Өлгий аймгийн спорт цогцолбор дахиад дээрээс нь энэ Ховд аймгийн спорт цогцолбор, Сэлэнгэ аймгийн спорт цогцолбор, Хөвсгөл аймгийн спорт цогцолбор гэсэн ийм зүйлүүд гарч ирж байгаа. Би энэ дээр ямар хар төрж байгаагаа хэлчихье. Сая 1 хэсэг гишүүдийн 15 тэрбум төгрөг гэж явсан. Энэ сайд нарын 15 тэрбум төгрөг болоод орж ирж байгаа юм шүү гэдэг ийм хар төрж байгаа учраас энийг асууж байгаа юм шүү.

Тэгээд энэ мэдээллээ Аудитын ерөнхий газар бүрэн дүүрэн гаргаж өгөх хэрэгтэй байна.

Ц.Сандаг-Очир: Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Тэгэхээр сайд нарын 15 гээд юм орчхов уу гээд Номин гишүүн маань ярьж байна аа. Тэгээд Ховд аймагт тэр Буянт суманд спорт заал гээд нэг юм тавигдсан юм байна лээ. Тэрийг хасаад сая баригдах гэж байгаа тэр хүүхдийн номын сан гэсэн үү? Тийм тэгээд тэр рүү тавьж болно оо болно шүү. Тэр ер нь Буянт сумд спорт заал барих шаардлагатай юу шаардлагагүй юу? Жишээ нь миний хувьд гэдэг юм уу тэр сайд нар гэхээр Ховдоос Их Хурлын гишүүн болсон Ховдоос сонгогдсон сайд гэхээр намайг хардаж байх шиг байна. Надад тийм зүйл тавьсан юм байхгүй. Тэрийг хасаад тэр хүүхдийн хэрэгтэй номын санд улсын хөгжлийн төлөвлөгөөнд орсон хөрөнгө оруулалт дээрээ тавьж болно оо тийм юм байхгүй гэдгийг хэлчихье.

Ц.Сандаг-Очир: Номин гишүүнд нэг минут.

Ч.Номин: Ингээд ороод ирсний дараа ийм зүйл гарч ирж байна. Тэгэхээр хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэх дээр мэдээж бид нар энэ Их Хурал дээр анхаарах нь зүйтэй гэж харж байгаа.

Хоёр дахь нь би энэ ЭМД-ын сан тантай холбоотой асуудлыг яг бичгээр Сангийн яам болон ЭМЯ, эрүүл мэндийн сангаас авах сонирхолтой байна. Энийг албан ёсоор өгөөч гэж хүсэж байна. Яагаад вэ гэхээр бид нар хуулийнхаа хүрээнд энэ эрүүл мэндийн сан дээр энэ эрсдэлийн сангаа бүрдүүлж явах ёстой. Тэгээд хууль нэгэнт байгаа байж байж хуулиа хэрэгжүүлэхгүйгээр өөр газар шийдэх болов уу гэдэг ийм зүйл явж байж болохгүй тэгэхээр хуульд бид нар нийцүүлэх дээр анхаарах нь зүйтэй гэж бодож байгаа.

Тэгэхээр саяын хэлсэн тодруулгыг албан бичгээр авах хүсэлтэй байна гэдгээ хэлье.

Ц.Сандаг-Очир: Хэдүүлээ эрхлэх асуудлынхаа хүрээнд л ярина шүү. Манай Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд асуудлуудаа ярьж хариултаа авах ёстой.

Дараагийн гишүүн Бөхчулууны Пүрэвдорж гишүүн байхгүй байна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуултаа асууя.

М.Бадамсүрэн: Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд Сангийн яамнаас 2 асуулт тавьсан. 15 хоногийн хугацаанд хариултыг маань

өгөөрэй гэдгийг хэлье. Ямар 2 асуулт вэ гэхээр нэгдүгээрт хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцээгүй хэдэн арга хэмжээг төсөвт тусгасан бэ? Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан боловч улсын төсөвт тусгагдаагүй хэдэн арга хэмжээ байгаа вэ? Энийг баримталж нийцүүлж явахгүй бол хөгжлийн төлөвлөгөө гэдэг зүйлийг батлаад ч хэрэггүй.

Хоёрдугаарт нь энэ улсын хэмжээнд гэж одоо энэ төсөв дээр 400 гаруй тэрбум төгрөгийн 40 шахам төсөл арга хэмжээ байгаа. Гэтэл энийг Төсвийн тухай хуульд юу гэж заасан байдаг вэ гэхээр Улсын Их Хурал төсөв батлах гээд 33 дугаар зүйл байгаа юм. 33 дугаар зүйлийн 2.6-д ингэж байгаа юм. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар гээд. Нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн жилийн санхүүжилтийн дүн гээд. Тэгээд Их Хурлын гишүүний хувьд Их Хурал төсөв батлахтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа. Энэ зохицуулалтын дагуу байршил, хүчин чадлыг нь заагаагүй улсын хэмжээнд гэдэг энэ багц энэ төсвийн татвар төлөгчдийн хөрөнгийг сайд ганцаараа мэдэж зарцуулах нь зохисгүй гэж би үзэж байгаа.

Тийм учраас асуултаа тавьсан байгаа. Тэр асуултыг маань нэг тодорхой өгөөрэй. Тэгээд энийг ард түмэндээ тайлагна. Энэ нэрээс гадна байршил хүчин чадал гээд. Тэгээд улсын хэмжээнд гээд тавьчихаар тэгээд яг нэн тэргүүнд шаардлагатай газраа хуваарилаад байгаа юм уу, эсвэл өөр газар хуваарилаад байгаа юм уу.

Тэгээд энэ олон жил яагаад ингэж явж ирсэн юм? Би энийг гайхаад байх юм. Энэнээс үүдэлтэй л хардалт маргаан яваад байгаа шүү дээ. Тэр сайд төсөвт тойрогтоо ингэчихлээ гээд. Энийгээ ил тод болгоод жагсаалтаар нь Улсын Их Хурлаар батлуулах ёстой. Энийг бол би шаардана. Яагаад гэвэл төсвийн хуваарилалт чинь шударга бус байна. Газрын тос Дорнод аймгийн нутгаас 95 хувийг нь олборлодог. Матад сумаас, Халх гол сумаас 20 шахам жилийн хугацаанд 4-өөс 6 их наяд төгрөг орсон төсөвт. Гэтэл 20 шахам жил цэцэрлэгийг нь шинэчлэх асуудлыг шийдээгүй. Тэгээд 4-өөс 6 их наяд төгрөг тэр 2 сумаас авчхаад тэгээд 3 мянган хүний эрх ашигт нийцсэн ганц цэцэрлэгийг шийдэж чадахгүй.

Өнөөдрийг хүртэл 20 жил Монголын төр Засгийн газар, Сангийн яам авсан гэхээр би бүр нүдэндээ итгэхгүй байгаа байхгүй юу. Би тэр аймгийн даргаар ажилласны хувьд энд орж ирээд энийг бүр гайхаад байгаа юм. Тийм учраас энэ зүйлийг хариулт өгөөрэй.

Хоёрт нь энэ төрийн албан хаагчдын тэтгэмжийг 50 хувь нь ингээд 178.1 тэрбум төгрөгийг ирэх жил хойшлуулна гээд. Та нар хүний эрхэнд ингэж халдаж болохгүй шүү дээ. Тэтгэвэрт гарна гэдэг чинь өөрөө тэр хүн тооцоод би ер нь тэтгэвэрт гарч өөрийгөө амраая эрүүл мэндээ би бодъё оо, урт насалъя гэж бодож энэ хүн өргөдлөө өгч гарч байхад та нар хүний эрхийг зөрчөөд хууль тогтоомжид заасаар байтал дараа жил 27 онд болгоно оо гэж ингэж болохгүй шүү дээ. Тэр хүн гэнэт нас нь богиносж гэнэтийн асуудал тэтгэвэрт гаргаагүйгээс болж энэ хүн зүрх судасны өвчлөл, цус харвалт төрөл бүрийн өвчин эмгэгт өртвөл хэн хариуцлага хүлээх юм. Тэгээд ийм механик байдлаар хандаж болохгүй. Энэ 178.1 тэрбум төгрөг аягүй бол байхгүй гэж хэлнэ, байна аа.

Зөвхөн энд тараагдсан байгаа материал дотор гэхэд энэ мэдээлэл сурталчилгааны зардал, судалгаа хөгжүүлэлтийн зардал, томилолтын зардал, зочин төлөөлөгчийн зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил, сургалт дадлага бэлтгэлийн гээд. Энэ зардлаа бууруул л даа. Тэгээд 178.1 тэрбум төгрөгийг тавих ёстой шүү дээ. Би харин хэлж байна шүү. Нэг ахмад энэнээс шалтгаалж эрсдэлд орвол Монголын төр энэ хариуцлагыг хүлээх юм уу. Энэ чинь байж болохгүй байхгүй юу даа. Энэ соёлт нийгэмд ийм механик аргаар ийм бүдүүлэг аргаар хууль зөрчиж хүний эрхийг хязгаарлаж болохгүй. Энэнээс чинь болоод 50 хувиар багасах юм гэнэ 36 сарыг 18 сар болгох юм гэнэ лээ гээд баахан хүн өргөдлөө өгөөд тэтгэвэртээ гарсан. Өөрөө хөөрхий хувьдаа бизнесгүй, тэгэхдээ л.

Ц.Сандаг-Очир: Эдийн засаг хөгжлийн яам. Ажлын хэсгийн 6 номер. Сангийн яам, хариулаадах. Сангийн яам дараа нь хариул. Эдийн засаг хөгжлийн яамнаас жилийн хөгжлийн төлөвлөгөө яриад байна шүү дээ. Сангийн яам уу? Ажлын хэсгийн 8 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой асуулгын хариуг бол бид бэлдэж байгаа. Хуулийн хугацаанд багтаагаад бол хүргүүлнэ.

Дараачийн асуудал бол байгалийн баялгийн хуваарилалттай холбоотой асуудлыг ярьж байна. Энэ хэсэг дээр бол яах вэ өмнө нь барьж явсан бодлогын хувьд бол ямар бодлого байсан бэ гэхээр энэ байгалийн баялаг өөрөө Монголын нийт ард түмний байгалийн баялаг учраас энэ бол тэгш хүртээмжтэй хүртэх ёстой гэдэг ийм агуулгаар л явчхаж байгаа. Бусдаар юу гэдэг юм Өмнөговь аймагт байгаа бүх байгалийн баялгийг Өмнөговь аймагт нь үлдээнэ гэх юм бол тэр орлого бол өөрөө болохгүй болчихоод байгаа.

Тэгэхдээ энийг бол зохистой харьцаа тогтоох ёстой гэдэг дээр бол би гишүүнтэй бол 100 хувь санал нэг байна. Тэгэхээр энэ асуудлыг бол бид нар ямар байдлаар, сувгаар хүргэх вэ гэдэг дээр бол дахиж ажиллана аа. Ирэх оны, ирэх жил бол бид нар төсвийн төсөл хүргүүлэх хүргүүлэхээс төсвийн төсөлд хүргүүлэхээс өмнө энэ дээр бол тодорхой бид нар хуулийн төслүүд боловсруулаад өргөн барихаар ажиллана гэж үзэж байгаа.

Орон нутгийн хөгжлийн сангаар дамжих юм уу, эсвэл тэр хөрөнгө оруулалтын сангаараа дамжих юм уу. Мөн улсын төсөв талдаа бид нар байгалийн баялгаасаа хэр хэмжээний орлогыг хуваарилах ёстой вэ гэдэг энэ агуулгуудаа бид нар үзнэ. Энэ дээр ажиллана гэдгийгээ хэлчихье ээ.

36 сарын тэтгэмжийн хувьд бол бидний барьж байгаа байр суурь бол бид бол юу гэдэг юм түрүүн зарим талаар тэр танилцуулга дээр байгаа асуудал бол уул нь бид нар эх үүсвэр талыг нь буюу төсвийг нь бол 50 хувиар бууруулж тавьчхаад байгаа. Энэ дээр бол юу гэдэг юм 2 хүн байлаа гэж бодоход тэр 2 хүнд нь 50, 50 хувиар өг гэдэг тийм агуулга бол биш. Төрийн албаны тухай хууль дээр бол тухайн тэтгэвэрт гарсан иргэн нь тухайн байгууллагаасаа бол тэтгэмжээ авах бол эрхтэй байгаа. Төсвийн ерөнхийлөн захирч болно төсвийн шууд захирагч нь бол зохицуулалт хийх боломж байгаа. Энэ хүрээндээ бол зохицуулалтаа хийгээд аль болох боломжоор уян хатнаар ингээд зохицуулах боломжийг нь бол бид нар нээж өгч ажиллана аа. Түрүүн бол асуусан тэр асуулттай холбоотой зүйлүүдийг бид нар анхаарах асуудлуудыг ойлгосон цаашдаа анхаараад ажиллана.

Ер нь бол яах вэ зүгээр энэ тэтгэмжийн асуудлыг бол бид нар том зургаараа бол яаж харж байна гэхлээр урсгал зардал маань бол өөрөө 24 хувьд байх ёстой гэдэг энэ том зорилгодоо бол хайчилж энэ рамдаа бол багтаж байгаа шүү. Энэ маань өөрөө бол Монгол Улсад нийт хөдөлмөр эрхэлж байгаа 1.4 сая иргэний эрх ашиг бол давхар явж байгаа. Бид нар урсгал зардлыг болон хөрөнгийн зардлыг аль болох нийт зарлагаа хэдий хэр хэмжээгээр хязгаарлаж чадна, нөгөө талдаа хувийн хэвшилдээ боломж олгоно гэж бол бид хэд тооцоод байгаа. Макро бодлогынхоо хүрээндээ. Төрийн зарцуулж байгаа мөнгө бага байх тусмаа аль болох хүү багатай зээлийн эх үүсвэр бол олдсон нэмэгдэнэ. Тэр хэмжээгээр бол бид нар ДНБ хурдан тэлэх боломжтой болно. Энэ хэмжээгээрээ бол төсвийн орлого бол нэмэгдэх боломжтой болно. Энэ хэмжээгээр төрийн үйлчилгээгээ бол бид нар сайжруулах ийм боломжтой болно оо гэдэг ийм макро бодлого бол явж байгаа шүү. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Юу гэсэн үг юм бэ? Жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй хэрхэн яаж уялдсан бэ гээд гаргаад хүргүүлье гэж. Төсвийн хэлэлцүүлэг 2 дахь хэлэлцүүлэг рүү орж байхад өдий болтол гаргаагүй байдаг юм уу? Өдийд та нар гаргачихсан бэлэн байж байх ёстой шүү дээ. Тэгээд сая Бадамсүрэн гишүүн асуугаад байна шүү дээ. Жилийн хөгжлийн төлөвлөгөөг батлах хэрэг байна уу үгүй юу. Энэ чинь хууль шүү дээ. Тэгтэл одоо гаргаад тэгээд хүргүүлье гээд ингээд ярьж байх юм.

Ажлын хэсгийн 8 номерын микрофон. Нэмэлт тайлбарыг өг дөө.

Ж.Дэлгэржаргал: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Төсвийн төслийн өргөн барьсан танилцуулга дээр жилийн төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан талаар танилцуулгыг оруулсан байгаа. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө өөрөө 19 их наядын хэрэгцээ шаардлагатай. Үүний 3.6 нь улсын төсвийн хөрөнгө оруулалт. Өргөн барьсан төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын дүн бол 3.2. Яг эх үүсвэрийн хувьд ингээд 400 тэрбумын зөрөө 1 дүгээрт үүсэж байгаа.

Хоёрдугаарт нь энэ уялдах асуудал дээр бол Төсвийн тухай хуулийн 27.1.8, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн 6.10.3 дээр хөгжлийн бодлогод суурилсан жилийн төлөвлөгөөг хангахад чиглэнэ гэж байгаа. Тэгэхээр аудитын дүгнэлт дээр бол нийт шинэ хөрөнгө оруулалтын 18 нь бол яг нэрээрээ уялдаагүй байна гэж байгаа. Зорилт болон зорилгын хувьд тухайн төслүүд уялдаад явж байгаа. Тэгээд таны асуулгын хариултыг өнөөдөр яг хуулийнхаа хугацаанд багтаж хүргүүлж байгаа нэмэлтээр.

Ц.Сандаг-Очир: Бадамсүрэн гишүүн нэмэлт тодруулга нэг минут.

М.Бадамсүрэн: Иргэдтэй байгуулсан гэрээ гэж хэлж болох энэ цалин хөлсний асуудал дээр битгий ийм огцом огцом шийдвэр гаргаарай цаашдаа. Бүхэл бүтэн Монголын төр шүү дээ. Тэгээд ард түмэн чинь юундаа итгэж найдах юм бэ? Та нар ингээд гэнэт гэнэт ийм шийдвэр гаргаад. Өмнө нь мөн л түрүүний тодотгол дээр ийм юм орж ирээд л ингээд л буцсан. Энэ чинь аягүй тийм төвөгтэй байдалтай байгаа шүү дээ. Тэгээд энийг анхаар гэж байгаа юм. Тэгээд миний энэ амжсангүй. Энэ Монополын эсрэг газар, Хөрөнгө оруулалт худалдааны газар гээд энэ 2 байгууллага ер нь яг юу хийдэг вэ? Энэ зах зээлийн эдийн засаг чинь энэ хамгийн чухал 2 газар шүү дээ. Энэ нэг хурал зөвлөгөөн хийсэн байх, гадаад дотоод явсан хийсэн байх. Би эрх зүйн шинэчлэл тодорхой ийм арга хэмжээ авч үнэд үнийн

өсөлтөөс сэргийллээ. Монополын эсрэг тэмцлээ. Хөрөнгө оруулалтыг ингэж нэмлээ гэдэг юм би ерөөсөө сонссонгүй. Энэ байх хэрэгтэй юм уу. Энэ төсөв дээр энэ дээр байна.

Тэгээд газар олголт газрын талаар байгаа юм. Үгүй газрын асуудал хариуцсан байгууллага чинь хамгийн чухал нь иргэдээ газартай өмчтэй болгох ёстой шүү дээ. Аж ахуй эрхлэхэд нь зориулж. Тийм ямар ч зорилт байхгүй. Энэ шалгуур үзүүлэлтүүдээ та нар.

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах юм? Бадамсүрэн гишүүний асуултад. Тэр 2 нэр бүхий агентлагийн нэрийг дурдаж байна. Юу хийдэг газар юм бэ? Юу хийж байна вэ гээд Шадар сайдын харьяанд байна уу, Өрсөлдөөний газар, Эдийн засаг хөгжлийн яаманд байна уу.

Наашаа ороод нэг микрофон дээр суугаадаа даа. Өөрийгөө танилцуулаад. Ажлын хэсгийн 8 номерын микрофон.

Д.Энхбаяр: Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны даргын үүрэг гүйцэтгэгч Энхбаяр байна. Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя аа.

Монополын эсрэг газар гэж хуучин нөгөө Шударга өрсөлдөөн хэрэглэгчийг эрхийг хамгаалах газрын чиг үүрэг, үндсэн бүтэц нэр нь өөрчлөгдөөд ийм болсон байгаа. Тэгээд Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль гэх мэт ингээд тодорхой нэг хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг хэрэгжүүлэх ийм чиг үүрэгтэй байгууллага байгаа. Тэгээд энэ байгууллагын төсөв дээр бас нэг зах зээлийн судалгаанууд, хувийн хэвшил дэх энэ төрийн оролцоог бууруулах чиглэлийн зах зээлийн судалгаанууд болон гадаад туршлага судлах төсөв 2026 оны төсвийн төсөөлөлд суусан байгаа.

Хөрөнгө оруулалт худалдааны газрын хувьд бол Хөрөнгө оруулалтын тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээд явж байгаа. Ийм Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг.

Ц.Сандаг-Очир: Хоёр дахь тодруулга. Нэг минут Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Ер нь та бүхэн хариулахдаа нөгөө байгууллагаа танилцуулаад хэрэггүй. Бид нар мэднэ шүү дээ. Яг юу хийсэн юм бэ? Энэ хараа зах зээлийн эдийн засаг чинь юу онол нь ийм байхгүй юу. Хувийн өмчийг дэмжих хамгаалах тэр газар олголтыг чинь би яриад байгаа юм. Аж ахуй эрхлэгчид нь зориулж дэмжих.

Хоёрдугаарт нь энэ монополийг хязгаарлах одоо энэ гурил дээр байна. Бусад бараан дээр байна. Үнийн өсөлт чинь мянга цалин нэмээд энэ инфляц чинь залгичхаад байгаа байхгүй юу. Тэгээд энэний хамгийн чухал 2, 3 тулгуурын 2 дахь нь энэ.

Гурав дахь нь энэ томоохон энэ бизнес эрхлэгчид аль болох төрийн бизнест оролцохгүй байх. Өөрөөр хэлбэл улс төрд нөлөө бүхий этгээдүүд аль болох энд оролцохгүй байх. Энэ 3 юм чинь хамгийн чухал 3 юм шүү дээ. Тэгээд энэ дээрээ ийм хяналт хариуцлагыг хэрэгжүүлж ажиллах маш чухал газар байхгүй юу даа. Энэ 2

агентлаг чинь өөрөө. Тэгээд энэ яг юу хийгээд байгаа юм бэ? Нүдэнд харагдаж гарт баригдах юм байна уу? Би ард түмний өмнөөс асуугаад байгаа байхгүй юу энийг. Тэгээд битгий байгууллагаа танилцуул яг юу.

Ц.Сандаг-Очир: Санал хэллээ. Энхбатын Болормаа гишүүн асуултаа асууя.

Э.Болормаа: Ингээд ТББХ-ныхоо гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Энэ бид ер нь нийтээрээ төсөв хэлэлцэж байгаа арга барилаа өөрчилмөөр байна. Тэгээд би энэ дээр арай туршлагатай энэ дээр олон жил ажиллаж байсан энэ гишүүд сайд нараасаа асуумаар байна. Та хэд ер нь нийтээр нь солих арга аргачлалыг ер нь бодож үзсэн үү? Бусад улс орнууд яг манайх шиг ер нь ийм замаар туулсан юм байна. Ерөөсөө төрийн байгууллагуудын мөрөөдлийн жагсаалтын нийлбэр төсөв. Ингээд л бид нар төсвийн санал авахдаа яг л Сангийн яамны хэлээд байгаа 5 сар гэхэд бүх төрийн агентлагууд нь өөрсдийнхөө саналуудаа өгөөд л тэндээс нь Сангийн яам эрх мэдлээрээ нэмж хасаад л ийм санал өгсөн өгөөгүй гэдэг байдлаар. Тэгээд бусад улс орнуудыг хараад байхаар яасан юм гэхээр зарим нь 80, 90 он хамгийн сүүлд Солонгос гээд. Ингээд л 2000 оных гэхээр шинэчлэлтүүдээ яаж хийж байна гэхээр яг л нөгөө ийм зорилтод хүрэхийн тулд яамдуудын цалин төсвийг жилээс жилд ингээд нэг бага бага хувиар нэмэх биш яг тоог нь өгөөд энэ дотор бүх зохицуулалтаа хийж энэ зорилтууддаа хүр. Жишээлбэл эрүүл мэндийн салбарт байна уу, боловсролын салбарт байна уу яг зорилтуудаа энэ өвчлөлийг тэдэн хувиар багасгана ч юм уу эсвэл боловсролын ийм үзүүлэлтүүдийг сайжруулна гэдэг ч юм уу ийм байдлаар харах ийм суурь концепцын өөрчлөлтүүд бид нар хиймээр байгаа.

Гэтэл өнөөдөр уул нь энэ шинэ 126 гишүүнтэй парламент яг л ийм өөрчлөлтүүдийг хүсээд ийм зарчмын шаардлага тавихаар өөдөөс ингээд улс төржүүлээ, төсөв барьцааллаа гээд ингээд нэг их сонин байдлаар хандаад байгаа байхгүй юу. Уул нь бид нар нэг л юмны төлөө ингээд зөв явчих гээд байдаг эсвэл та хэд өөрсдийнхөө сурсан байдлаар зөвхөн ийм байдлаар хандаж ирсэн болохоор ингээд буруу ойлгоод байгаа юм уу? Лука гишүүн яг л зөв юм энэ шалгуур үзүүлэлт яриад байна. Гэтэл өөдөөс нь өө тийм таны зөв гээд л ингээд л ямар ч өөрчлөлт орж ирэхгүй байна. Тэгэхээр энэ төсөв дээр би энэ Сангийн яамныхнаасаа илүү их асуумаар байгаа юм. Эдийн засаг хөгжлийн яамныхан та бүхэн бүүр суурь концепцын өөрчлөлтийг юу гэж боддог вэ? Төрийн байгуулалтын байнгын хороо учир би энийг асууж байгаа юм л даа. Би энэ дундаас энэ нэг зардал чинь яасан гээд ийм жижиг сажиг хэрүүл хийхээс илүүтэйгээр ингэж явж ирсэн төсвөө бүгдээрээ буруу гэдгээ хамтдаа хүлээн зөвшөөрөе өө. Одоо үр дүнд суурилсан энд эдийн засгийн өсөлт өнөөдөр бид нар ийм хэмжээний төсөв ярьж байгаа гэдэг үнэхээр бас бахархуштай. Монгол Улс ядуу улс биш. Бид нарын энэ төсвийн ярьж байгаа мөнгөний хэмжээ бага ч биш.

Энийг яаж улс орныхоо зөв хөгжлийн төлөө хамтдаа зарцуулах вэ гэдэг суурь концепцын өөрчлөлтийн ажил дээр та нар ажиллаж байсан уу? Магадгүй та нар аягүй гоё санаа бодсон байсан чинь дарга сайд нар чинь үгүй үгүй ингэдгээрээ л явна гээд ингээд загнаад дараад байдаг юм уу эсвэл энэ ингэж явж байгаа аргачлалыг та нар зөв гэж бодоод байна уу? Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн, Эдийн засгийн хөгжлийн яамныхан, Сангийн яамныхнаас энийг асууя.

Ц.Сандаг-Очир: Эдийн засаг, хөгжлийн яам, уг нь Бямбацогт сайд бас Хэрэг эрхлэх газрын даргын хувьд хариулах л ёстой юм байна. Бямбацогт даргаас эхлээд явъя.

С.Бямбацогт: Болормаа гишүүн маш зөв асуулт хөндөж байна асуудал. Энийг бид нарыг харах цаг нь болсон. Уул нь амьхандаа харах гээд 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгээд түүндээ бас Монгол Улсын хөгжлийн бодлого нь урт, дунд, богино хугацаандаа уялдаатай байна. Салбар дундын зохицуулалттай байна, бүс орон нутагтайгаа уялдана. Ингээд хийчихсэн. Үүн дээрээ тулгуурлаад бид нар Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хийсэн. Энэ дээрээ урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050-ийн үед баталсан. Дунд хугацааны хөгжлийн зорилт, хөтөлбөрүүдээ батлах ёстой, 8 зорилт, хөтөлбөрөөс ганцхан бүс нутгийн хөгжлийн зорилтот хөтөлбөр баталсан 7 нь батлагдаагүй байж байгаа. 5 жилийн төлөвлөгөөтэй болсон 1990 оноос өмнө 5 жилийн төлөвлөгөөтэй байсан. Үүнээс хойш тасарсан. Ялсан нам болгон өөрийн бодлогоо хэрэгжүүлнэ гээд өмнөхөө үгүйсгэдэг, байгуулагдсан Засгийн газраас Ерөнхий сайд болгон тийм үү өмнөх засгийн газраа үгүйсгээд шинээр юм хийдэг, ийм болчихсон. Үүнийг нь уялдуулах гээд 5 жилийн төлөвлөгөөтэй, Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй. Энэ дээр тулгуурлаад жилийн төлөвлөгөөтэй, төлөвлөгөөн дээр тулгуурлаад төсөвлөдөг байя гэж. Өөрөөр хэлэх юм бол төлөвлөдөг байж байж төлөвлөчхөөд түүндээ тааруулж төсөвлөдөг байя. Энэ үүднээсээ Эдийн засгийн хөгжлийн яаманд төлөвлөлтөө хийе. Төсөвлөлтөө Сангийн яам нь хийе. Төлөвлөлт дээрээ тулгуурлаж төсөвлөдөг байя. Ингээд юмнуудаа хийгээд уул нь урьд өмнөхөө бодоход жоохон жоохон суурь нь тавигдаад яваад байгаа юм.

Гэхдээ бүтэн тийм үү үр дүнд хүрэхгүй байгаа юм. Одоо яг энэ жилийн төсөв дээрээс харагдаж байна. Урсгал зардал маань ингээд бүр дийлдэхээ больчихсон. Бүгдийг нь хуульчлаад өгчихсөн. Хөрөнгө оруулалт хийх бололцоогүй болчихсон. Хөрөнгө оруулалт нь оновчтой байна уу, оновчгүй байна уу гэхээр тийм үү үзэмжээрээ шийддэг янз янзын байдлаар гишүүдийн гэдэг юм уу сайд нарын гэдэг юм уу эс үгүй бол нөлөө бүхий хүмүүсийн гэдэг юм уу ингээд шаардлагатай шаардлагаар хөрөнгө оруулалт суудаг болчихсон. Энэ бүгдийг л бүгдээрээ нийлж байгаад нэг шийдмээр байгаа юм. Энийг одоо ингээд л жилийн жилд л ингээд л яриад л байдаг, яриад л байдаг, шийдэж чаддаггүй байдаг хэвээрээ байгаад гэхдээ жоохон бага зэрэг сайжирч байгаа. Бүрэн юу гэдэг юм аягүй сайн болчихсон гэж хэлэхгүй. Тэгэхээр энийг л бид нар одоо нэг шийдэх тал дээр нэг хамтраад ямар одоо бололцоо боломж байна? Энэ дээр бас нэг Сангийн яам маань илүү ингээд байнга л яригдаж байдаг асуудал дээр нэг зөв шийдэл гаргаад хөдлөөсэй гэж бодож байгаа. Маш том юу гэдэг юм хөрөнгө оруулалтын болон урсгал зардлуудаа том шинжилгээ хийгээд ямархуу зарчмаар яаж эрэмбэлэх юм, яаж ангилах юм, ямар шалгуур шаардлага тавьдаг байх юм, яаж үр дүнг нь үнэлдэг хэмждэг байх юм.

Ийм л юм хиймээр байгаа юм л даа. Нөгөө хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй. Өнөөдөр бид нар хэмжиж чадахгүй байгаад байгаа юм. Хэмжээд тэгээд энэ нь болж байна энэ нь болохгүй байна гээд гаргаж ирээд тэгвэл болохгүй юмаа ингээд засъя гэдэг дээр л тэгээд л нэг аргацаагаад л домноод л яваад байгаа. Энэ дээр л одоо манай яг холбогдох яамдууд төлөвлөдөг яам, төсөвлөдөг яам 2 маань энэ дээр нэг бодлогын шинэчлэл хийгээсэй гэдгийг яг тантай санал нэг байна аа. Энэ аягүй чухал асуудал.

Ц.Сандаг-Очир: Болормаа гишүүн тодруулъя. Нэг минут.

Э.Болормаа: Харин ингээд аягүй сонин юм нь бид нар ингээд бүгдээрээ уул нь санал нэгдээд байдаг, ингэх ёстой, ингэх ёстой гээд байдаг. Одоо яг хэн хийх ёстойг нь л би ойлгохгүй байна л даа. Ер нь бараг санал зөрөлдөж байгаа хүн алга. Яг энэ юмнуудыг солих ёстой гэсэн нөгөө хийх ёстой хүмүүс нь яг үнэн зөв өө л гээд байдаг. Тэгээд хэн хэзээ хийж оруулж ирэх юм бэ? Одоо та сая хэллээ Бямбацогт сайд. Гишүүд, сайд нар юм уу ингээд хөрөнгө оруулалтын нөлөөнүүд орж ирдэг гэж аягүй ноцтой юм хэлж байна шүү дээ тэ. Энэ 126 л энийг өөрчлөхгүй бол болохгүй. Би бол баттай манай шинэ гишүүд бол ийм юм ярьж байгаа хүн нэг ч байхгүй байх гэдэгт бүрэн итгэж байна. Ер нь бид нар хоорондоо ч тийм юм ярьдаг.

Тэгэхээр хэн энэ төсвийн бодлогыг чинь алдагдуулаад ингэж нөлөө үзүүлээд гишүүд сайд нарын хөрөнгө оруулалтын дарамт шахалт байгаа. Энийгээ зүгээр ил тод зарлаад энэ хий.

Ц.Сандаг-Очир: Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Хэн хийх вэ гэдэг дээр бид нар чинь нэг эрх зүйн орчноо бүрдүүлэх ёстой. Хуулийг Улсын Их Хурал баталдаг, Засгийн газраас хэрэгжүүлдэг. Засгийн газраас тийм үү яг ийм асуудлаа ингэж шийдье гэж оруулж ирэх тийм үүрэг нь байж байгаа. Энэ дээр бид нар анхааръя. Одоо нэгэнтээ төсөв хэлэлцэж байгаа үедээ Их Хурлын гишүүд маань энэ чинь болохгүй байна энэ чинь бүтэхгүй байна гэж байгаа бол тийм төсвийнхөө хэлэлцүүлэг хийчхээд хэлэлцүүлгийн 2, 3 дахь үе шатны явцад тийм үү энэ болохгүй юмнуудаа яг ингэж ингэж өөрчилье гээд ингээд санаачилга аваад явах бололцоо байж байгаа.

Засгийн газраас та нар хийгээгүй байна. Тийм учраас Их Хурал та бүгдийн хийгээгүй ажлыг чинь гүйцээгээд, засаад залруулаад, сайжруулаад хийе. Эс үгүй бол Засгийн газарт үүрэг өгөөд энийгээ ийм хугацаанд хийгээд ир гэж үүрэг өгөх ёстой. Яг үнэндээ хийх гээд ингээд санаачилга байдаг ч гэсэн тодорхой хэмжээнд ингээд цаг хугацаа алдаад жоохон хойшлоод байгаа тал байгаа. Тийм болохоор Их Хурлаас ташуурдаад өгөөсэй. Энэ энэ тал дээр биднийг.

Ц.Сандаг-Очир: Болсон уу? 2 дахь нэг минутын тодруулга авъя.

Э.Болормаа: Хууль тогтоогчид бид чинь одоо энэ дээр яг л ийм хурлууд дээр санал бодлуудаа хэлж байгаа. Одоо ингээд ажлаа хийгээч гээд бид нараар гуйлгуулаад, загнуулаад ийм юм руу явмааргүй байна аа. Нэг гишүүн гэхэд нэг зөвлөх нэг туслахтай. Тэр хуулийг бүгдийг нь бичээд биш Засгийн газарт бүрэн эрх мэдэл бүхэл бүтэн хүний нөөц нь, төсөв санхүү мөнгө нь ингээд байж байгаа учир энэ бүх хэлж байгаа гишүүдийнхээ санал санаачилгыг бариад зөв болгоё оо гэсэн дээрээ энийгээ төсвөөсөө урьтаж оруулж ирэх ёстой байсан. Та жишээлбэл 20 жил Их Хуралд байгаа энэ бүх асуудлуудыг мэдэж байгаа шүү дээ. Бид нараар хэлүүлэлтгүйгээр энэ төсвийн болохгүй байгаа саяын хэлээд байгаа хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд гар бие оролцсон бид нарыг зас гээд тэрнийхээ тулд бид нарыг ташуурд гээд суугаад байгаа нь аягүй утгагүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид нараар хэлүүлэлтгүй та нар зүгээр ажлаа хийчихмээр байна шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Санал хэллээ дээ. Бямбацогт сайд нэг минут хариул.

С.Бямбацогт: Харин 20 жил биш л дээ 17 жил болж байна. Гэхдээ би 12 оноос хойш энэ асуудлыг ярьж байгаа. Энэ төрийн бодлого тодорхой байх ёстой, тогтвортой байх ёстой, харилцан уялдаатай, дээрээс нь залгамж чанартай байх ёстой юм гэж. 2014 онд бас Улсын Их Хурлын гишүүн байхдаа ажлын хэсэг ахлаад 2030 он хүртэл Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал гээд батлуулаад, 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийж энэ Монгол Улсын төрийн бодлого урт, дунд, богинохон уялдаатай байх асуудлыг хийгээд 2020 онд Улсын Их Хурлын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг санаачилж Их Хурлаар батлуулаад, энэ төрийн бодлого уялдаатай байх асуудлыг хийгээд ингээд амьхандаа бол ямар ч байсан үе үеийн Их Хуралдаа хийсэн ажилтай, хэлэх үгтэй ажиллаж байгаа. Ганцхан хэрэгжүүлэх тал дээр илүү анхаараад хэрэгжүүлэх ажил дээр та бүгдийн дэмжлэгтэйгээр энийг бодитой үр дүн гаргаж хэрэгжүүлэх шаардлагатай байна аа. Энийг мэдэж байгаа хийгээд явж байгаа. Ер нь олон гишүүд байсан олон гишүүдээс харьцангуй илүү өгдөг энэ тал дээр илүү санаачилга гаргаж байсан.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Ер нь Болормаа гишүүний асууж байгаа асуулт чухал шүү. Манай Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамныхан бодох ёстой, бодлогын суурь өөрчлөлтийг яаж хийж, бодож байгаа юм бэ, харж байгаа юм бэ л гээд байна шүү дээ. Одоо яг байдгаараа ингээд 35 жил бид нар нэг л хэв маягаар төсвийн төлөвлөлтөө боловсруулалтаа ингээд л хийгээд л яваад байгаа. Тэгээд яг энүүгээрээ явахаар одоо болж бүтэхгүй байгаа олон асуудлууд гараад байна шүү дээ. Яаж өөрчлөлт шинэчлэл хийх юм бэ гэдэг юмыг л асуугаад байна шүү дээ.

Сархадын Зулпхар гишүүн асуултаа асууя. Микрофон.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүд, ажлын хэсгийн гишүүдийн өдрийн амгаланг айлтгая аа. Бид угаасаа хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээг л эрэлтийг л яаж би зохицуулах вэ гэдэг л ийм л шийдэл хайсан, шийдвэр гаргасан нэг ийм л хурал болдог. Тэгээд л тэр хурал маань болж байна. Болох ч байх цаашдаа. Өнгөрсөн жилийн 7 сард Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль орж ирэх үед шинжлэх ухаанаа бид Эдийн засаг хөгжлийн чиг үүрэг хариуцсан сайдын эрхлэх асуудал болгоод ингээд өгчихсөн юм. Урьд нь бол өөр байсан гэсэн үг шүү дээ. Уг нь зөв л дөө яах вэ эдийн засаг хөгжлийн бодлого бол шинжлэх ухааны суурьтай байх ёстой юм гэдэг үүднээс ингээд өгчихсөн байж байгаа. Тэрнээс гадна 2026 онд Эдийн засаг хөгжлийн яам өөрөө одоо жишээ нь оны төлөвлөгөө хөгжлийн төлөвлөгөө хийхдээ шинжлэх ухааныхаа зардлыг ДНБ-ий 0.5 хувь болгоно оо гээд ингээд шалгуур үзүүлэлтээ тавьчихсан. Энийг ер нь урьд урьд нь ч гэсэн бид нэг байнга яриад ирсэн л дээ.

Тэгсэн одоо ингээд тооцсон чинь энэ жилийн шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн энэ чинь 24 хүрээлэн байна л даа. Яг танай тарифтай бусад нь тусдаа байгаа. Тэрнээс гадна үндэсний шинжлэх ухааны судалгааны тусдаа сан байж байгаа. Энийг аваад үзэхээр 78 тэрбум төгрөг л байгаа юм. 78 тэрбум төгрөг. Тэгээд энэ ДНБ-ий 0.12 хувь байна гэсэн үг.

Тэгэхээр бид нөгөө шалгуур үзүүлэлтдээ хүрэхгүй байна. Би энэ ямар нэгэн байдлаар дутуу байгааг нь яахаасаа илүүтэйгээр бид нөгөө тавьсан шалгуураа зорилтоо хангах чиглэлээр ажиллаж байна уу үгүй юу гэдгийг. Тухайлбал энэ геологийн хүрээлэн байгаа юм л даа. Энэ чинь геологийн хүрээлэн чинь манайх чинь уул уурхайн жишээ нь улс орон гэдгийг өөрсдөө мэдэж байгаа. Тэр чиглэлээр

томоохон зорилтуудыг тавьчихсан байгаа шүү дээ. Геологийн хүрээлэн дээр бол 1.5 тэрбум төгрөг л тавьсан байгаа. Би энэ хүрээлэнгийнхэнтэй уулзсан. Хүрээлэнгийнхэн нь юу гэж байна гэхлээр зэрэг бид ингээд хээрийн судалгаанд гарахлаар зэрэг бидэнд томилолт байхгүй. Тэр нь нөгөө хэмнэлтийн хуулиар бусад юмаар яаж байсан. Бид нэг ийм сонин гаж юман дээр л байгаад байдаг. Тэр аудитынх нь гүйцэтгэлийн аудит хийх үедээ энийг бас ер нь харж хэлмээр юм байна аа. Ямар чиг үүрэгтэй байгууллага юуг ашиглах ёстой вэ гэдгийг тэнд хээрийн судалгаа хийхгүй мөртөө, тэгээд тэр шинжлэх ухааныг хөгжүүлээд тэгээд хөгжлийн бодлогыг тодорхойлоод явах боломжтой юм уу? Би энийг Батхүү дарга байж байна. Батхүү даргаас зориуд асууж байна аа. Нэг зүйл тодруулах гэж байна. Би ахиад 2 зүйл тодруулна. Дараа нь нэмэлтээрээ.

Бямбацогт сайдаас энэ төрийн албаны шинэчлэлийн хүрээнд их чухал 2 ажил хийгдэж байгаа юм байна л даа. Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд төрийн бүтээмжийн нэгдсэн мэдээллийн систем, хиймэл оюун ухаанд суурилсан төрийн нээлттэй өгөгдлийн платформ гээд. Тэгээд энэ хаана вэ гэсэн чинь Улаанбаатар, СБД гээд тавьчихаж. Энэ үндэсний хэмжээнд хэрэглэх платформ болон ийм бүтээмжийн нэгдсэн мэдээллийн систем мөн үү гэсэн ийм асуулт байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 6 номерын микрофон.

Б.Мөнхтөр: Эдийн засаг хөгжлийн яам Мөнхтөр. Зулпхар гишүүний асуултад хариулъя. Энэ жилийн хувьд шинжлэх ухаан технологийн салбарт 159 тэрбум төгрөг төсөвлөгдсөн байгаа. Задаргааны хувьд бол урсгал зардал 74 тэрбум энэ үндсэндээ 100 хувь тусгагдсан. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардалд 10.2 тэрбум тэрбум төгрөг туссан байгаа. Гэхдээ энэ маань бид нарын анх төлөвлөж байснаас тийм одоо төлсөн хэмжээнд хүрээгүй үзүүлэлт. Хөрөнгө оруулалт шинжлэх ухааны нэгдсэн байр буюу академийн байрны барилга дээр 40 тэрбум, тоног төхөөрөмж лабораторийн сайжруулалт дээр 32.5 тэрбумд үндсэндээ суусан байгаа. Энэ маань үндсэндээ бол ДНБ-ий 1.16 хувийг эзэлж байгаа. Яг бид нарын тавьсан зорилтод бол хараахан хүрээгүй. Ер нь цаашдаа бид нар шинжлэх ухаан технологийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ийм бодлого барьж байгаа. Одоо 2026-аас 2030 оны бид нар 5 жилийн үндсэн чиглэлд бол ер нь шинжлэх ухаан технологийн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэг ДНБ-тэй харьцуулахад 2 орчим хувьд байлгах ийм зорилт тавьж байгаа. Нэг хэсэг нь яах вэ Засгийн газрын нөгөө нэг үйл ажиллагаатай холбоотойгоор энэ зун төсөв тодорхой хэмжээгээр тасалдсан ийм асуудал байгаа. Одоо бол үйл ажиллагаа үндсэндээ жигдэрчихсэн, томилолтууд үндсэндээ хэвийн үргэлжлэх боломжтой болсон байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Бямбацогт сайд нэмж хариулъя.

С.Бямбацогт: Тиймээ энэ төрийн албаны шинэчлэлийн хүрээнд төрийн бүтээмжийн нэгдсэн мэдээллийн систем, хиймэл оюун ухаанд суурилсан төрийн нээлттэй мэдээллийн өгөгдлийн платформ байгуулна гээд. Энэ бол нөгөө СБД гэж тавигдсан ЗГХЭГ Төрийн ордон СБД-ийн нутаг дэвсгэрт байрладаг учраас энэ утгаар тавигдсан. Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын харьяанд үндсэндээ бол бүх төрийн яамдууд төрийн захиргааны төв байгууллагуудын ажлыг уялдуулдаг, орон нутгийн 21 аймаг, 330 сумын үйл ажиллагаа, бодлого, үйл ажиллагаагаар чиглүүлж удирддаг. Энэ үүднээсээ үндсэндээ энэ төрийн албатай холбоотой бүхий л тийм салбарт энэ үйл ажиллагаа хамрагдана гэж ойлгож болно оо.

Ганцхан жишээ хэлэхэд 1111 төв дээр иргэдийн санал хүсэлт, гомдлыг сонсдог, өдөрт мянга орчим дуудлага ирдэг. Түүнээс 200-д нь хариу лт өгч чаддаг, 800-д нь бид нар хариулт өгч чадахгүй байгаад байгаа юм. Хүн ажиллаж байгаа. Тэгвэл хиймэл оюун ухаанд суурилаад бид нар энэ 800 алдаж байгаа дуудлагаа барьдаг болох. Яг үүнтэй адилхан төрийн үйлчилгээг гэрээс нь гар утаснаас нь иргэддээ хүртээмжтэй, чанартай, хурдан шуурхай.

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүн тодруулъя. Нэг минут.

С.Зулпхар: Баярлалаа. Би Цэдэвсүрэн даргаас тодруулах гэсэн юм л даа. Төрийн албаны шинэчлэлийн бас нэг бүрэлдэхүүн хэсэг нь төрийн албаны төв байгууллага буюу жишээ нь Төрийн албаны зөвлөл танай төсөв хангалттай байна уу? Ноднин л жишээ нь бидэнд хангалтгүй байна. Саяын хэлсэн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой зүйл дээр бид хүнд гацчихлаа гэсэн шүү дээ. Тэгээд яаж тавигдсан гэдэг нэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт Бямбацогт сайдаас дахиад нэг тодруулга. Төрийн албан хаагчдын чинь хөгжлийн асуудал, төрийн албаны шинэчлэлийн нэг бүрэлдэхүүн нь бол төрийн албан хаагчдын сургалт хөгжлийн асуудал байгаа юм. Тэгэхээр энэтэй холбоотой бид төсвийг нь танаж байсан. Сая тодотголоор 2026 онд энэ хангалттай орж ирсэн үү?

Торгохгүйгээр хөгжүүлэхгүйгээр бид яаж явах вэ гэдэг ийм асуулт тавиад байна л даа. Цаана нь төрийн албан хаагчид. Мөнхтөр дарга яах вэ мэдээж хэрэг бид их гоё бодож байгаа зөв бодож байгаа бүгдээрээ л би зөв бодож байгаа юм чинь гэхдээ их хангалтгүй төсөв байна шүү дээ. Үнэнийг хэлье. Та хэд өөрсдөө 0.5 гэдэг шалгуур тавьчихаад 0.12 тавьчихсан ийм байж байгаа. Тэр яах вэ академийн байрны тусдаа гэхдээ энэ төсөв нь бол хангалттай биш гэдгийг та бас тодорхой хэлмээр байна аа.

Ц.Сандаг-Очир: Бямбацогт сайд хариулъя. Дараа нь Цэдэвсүрэн дарга.

С.Бямбацогт: ЗГХЭГ-ын доод талд нэлээн олон байгууллагын төсөв байдаг. Энэ төсөв 2024 онд 238 тэрбум байсан, 2025 онд 96 тэрбум болсон, 2026 онд 110 тэрбум болж байгаа. Эндээс ЗГХЭГ-ын төсөв 2024 онд 33 тэрбум байсан, 27 онд төсвийн тодотголоор 30 тэрбум болж хасагдсан багассан. 2026 онд 30 тэрбум болж 3 тэрбумаар 25 онтой харьцуулахад нэмэгдэж байгаа. Үүний цаад талд сая таны ярьж байгаа төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтын зардал нэмж суулгасан. Өөрөөр хэлэх юм бол сая төсвийн тодотголоор бол нөгөө мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтын зардлыг хасчихсан байсан. Энийг одоо ирэх оны төсөв дээр нэмж суулгасан. Үүнтэй холбоотойгоор ЗГХЭГ-ын төсөв жоохон нэмэгдсэн байгаа гэдгийг та бүхэндээ танд хариулъя аа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 2 номерын микрофон. ТА3-ийн дарга Цэдэвсүрэн дарга.

Л.Цэдэвсүрэн: Гишүүний асуултад хариулъя. ТА3-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв бол ТА3, Ёс зүйн хорооны 2 байгууллагын төсөв гэдгийг дахин тодотгож хэлье. 2025 онд төсөв батлуулах үедээ Улсын Их Хурлын гишүүддээ энэ 2 байгууллагын чиг үүргийг нэлээн сайн ойлгуулж тайлбарласны үр дүнд бид нар төсвөө тодорхой хэмжээнд хангалттай батлуулж чадсан. 2026 оны төсвийн төслийг

боловсруулаад Сангийн яамтайгаа 2, 3 удаагийн уулзалт хийж, 2026 оны улсын жилийн төлөвлөгөө болон авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2, 3 хуулийнхаа хэрэгжилтийн хүрээнд энэ оны төсөв дээр бид нар 15.4 тэрбум буюу өмнөх одоо энэ 2025 оноосоо 300 саяхан төгрөгийн илүүтэй төсөв маань орж ирж байгаа. Энэ маань хангалттай. Тэгээд дотроо бол Төрийн албаны зөвлөл, ёс зүйн хороондоо бол төсвийн ерөнхийлөн захирагчийнхаа хүрээнд тодорхой зохицуулалтаа хийгээд явах боломжтой гэж үзэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 6 номерын микрофон.

Б.Мөнхтөр: Үндсэндээ ер нь шинжлэх ухаан технологийн салбарын төсөв хангалттай биш байгаа. Бид нарын хувьд энэ жил нэг 200 орчим тэрбум төгрөгийн саналыг бэлтгэж Сангийн яаманд хүргүүлсэн байгаа. Батлагдсан нь 159 тэрбум байгаа. Ер нь бол цаашдаа ер нь шинжлэх ухаан технологийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага бид нарт байгаа. Учир шалтгаан нь болохоор өмнө нь бид нар бол шинжлэх ухааны салбарыг ерөнхийдөө эрдэм шинжилгээ судалгааны байгууллага гэдэг өнцгөөр харж байсан. Одоо Эдийн засаг хөгжлийн яаманд ирснээр бид нар энэ салбарыг эдийн засагтай уялдуулах бодолтой байгаа. Энэ шинжлэх ухаан технологийн салбараас орж ирж байгаа мэдлэгийн асуудлыг эдийн засагтай уях энэ тодорхой зорилт тавиад ажиллаж байгаа. Энэ агуулгаараа яалт ч үгүй төсөл санхүүг нь нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага бидэнд байгаа. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би бас нэг 3 асуулт асууя. Сонгуулийн хорооноос асууя. Ирэх жилийн төсөвт суухгүй бол 2027 онд Ерөнхийлөгчийн сонгуультай. Танай дээр ашиглагддаг сонгуулийн тооллогын хар машины 90 орчим хувь нь хугацаа дууссан актлагдсан гэж ойлгож байгаа. Гэтэл одоо ирэх жил шинэчилье гээд төсвөө саналаа өгөхөөр тэр 3-ны 1-ийг нь л шинэчлэх, үлдсэн 3-ны 2 нь шинэчлэгдэж чадахааргүй байгаа.

Тэгэхээр 2027 оны сонгууль хэл ам маргаангүйгээр явах бололцоо боломж нь ямар байгаа юм бэ. Гарах юм уу, гарахгүй юм уу гэдэг асуудал.

Дараа нь асуудал гарвал хэн хариуцлагыг нь хүлээх вэ гэдэг асуудал.

Танайх саналаа яаж хүргүүлсэн бэ? Төсвийн төсөлд яаж сууж байгаа вэ гэдгээ нэг тодорхой хэлээдэх ээ. Ерөнхийлөгчийн төсөв дээр бас нэг тодорхой асуулт асуумаар байх юм. Бас одоо янз бүрийн харьцуулалт хийгээд л өмнөх Ерөнхийлөгч нартай харьцуулаад л ингээд. Сүүлийн үед манай улсын гадаад харилцаа гадаад, дотоодоос төрийн тэргүүнүүдийн ирэх айлчлал, гадагшаа явах айлчлалууд олон нэмэгдсэн гэж харж байгаа.

Тэгвэл энэ Ерөнхийлөгчийн төсөв дээр ер нь ирэх жил хэрхэн яаж сууж яаж гадаад харилцааны чиглэлээр төсөвт хөдөлгөөнд нь сууж байгаа вэ. Энэ дээр нэг хариулт өгөх бололцоо боломж байна уу үгүй юу.

3.Мөн МҮОНРТ гэж нэг байгууллага байна аа. Эрхлэх асуудлынхаа хүрээнд манай ТББХ-нд харьяалагддаг. Тэгсэн хэрнээ төсөв нь манайд орж ирдэггүй. Ингээд хайгаад үзэхээр Сангийн сайдын багцад явж байх юм. Тэгээд төсөв нь Сангийн сайдын багцад үйл ажиллагаа, тайлан сонгон шалгаруулалт Үндэсний зөвлөлийг хийхдээ бид нар Төрийн байгуулалтын байнгын хороо хийдэг. Тайлангаа манайд

тавьдаг. Удахгүй Үндэсний зөвлөлийн тайлан тавина. Тэнд бас нэлээн асуудалтай байгууллага байна. Хэл ам ихтэй байна. Хурал чуулганаа хийж чаддаггүй гэж байна. Төсөв, төлөвлөгөө, аудитын газраас нэлээд зөрчилтэй дүгнэлтүүд гарсан. Хяналтын зөвлөлийнхөн тайлангаа авч хэлэлцдэггүй гээд асуудлууд байгаад байдаг. Гэсэн хэрнээ энэ байгууллагын төсөв яагаад Сангийн сайдын багцад яваад байдаг юм бэ.

Хэрвээ тэгвэл Сангийн сайд энэ харьяалахын асуудлаараа тэр чигээр нь авах юм уу? Хэрвээ манай Байнгын хороонд байх юм бол төсөв төлөвлөгөөтэй нь өгөхгүй юм уу? Ирэх жилийн төсөв төлөвлөгөөн дээр 9 тэрбум төгрөг төсөвлөсөн байх юм. Энэ чинь бусад телевизүүдээс олон нийтийн гэдэг утгаараа төрөөс татвар төлөгчдөөс мөнгө авч явдаг ийм байгууллага. Энэн дээр одоо бас Сангийн яамныхан нэг хариулт өгөөч. Ийм 3 асуултыг асууя.

Ажлын хэсгийн 3 номерын микрофон СЕХ-ны дарга Дэлгэрнаран дарга.

Ж.Дэлгэрнаран: Сандаг-Очир даргын асуултад хариулъя. Манайх бол 2027 онд Ерөнхийлөгчийн ээлжит сонгуультай. Манайх санал тоолох төхөөрөмж бол нийт 3 мянган ширхгийг хэрэглэж байгаа яг одоогийн байдлаар бол. Цаашдаа бол энэ тоо өсөх магадлалтай. Сонгогчдын тоо өсөх хэсгийн хороодыг нэмж байгуулахтай холбогдуулаад бол хэрэглэх төхөөрөмжийн тоо бол өснө өө. Ер нь 3 мянган төхөөрөмжийг шинээр авах шаардлагатай гэж үзэж байгаа. Энэ бол 2012 онд авсан төхөөрөмжүүд маань 3 удаа ашиглалтын хугацааг сунгасан. Одоо дахиж сунгах ямар ч боломжгүй. Хэрэв сунгасан тохиолдолд бол сонгогчдын итгэл энэ дээр бол хардлага сэрдлэг бол үнэхээр асуудалтай болно.

Тэгэхээр бол шинээр төхөөрөмжүүдийг шинэчлэх шаардлагатай. Бид нар 3 мянган төхөөрөмжийг шинээр авъя гэж байгаа. Яг одоогийн байдлаар бол ашиглалтын хугацаа бүрэн дуусаад гарчихсан 2493 төхөөрөмж байгаа. Ингээд 2027, 2028 оны ээлжит сонгуулиудад 3 мянган төхөөрөмж шаардлагатай гэж үзээд бид Сангийн яаманд энэ онд бол 3 мянган төхөөрөмжөө авъя гэж өнгөрсөн онд ч мөн бид нар санал тавьсан. Төсвийн тодотгол дээр ч мөн санал тавьсан. Энэ бол байж бай, түр хүлээж бай, хэцүү байна гээд ингээд бүгдийг нь хойшлуулаад байгаа. Энэ жилээс цааш бол хойшлуулах хугацаа байхгүй. Нийт 3 мянган төхөөрөмжийг авахад бол 41 тэрбум 720 сая төгрөг шаардлагатай байгаа. Тэгээд энэ жил Сангийн яамны хянаснаар бол 12 тэрбум, 516 сая төгрөг буюу 1 мянган төхөөрөмж авахаар л ингэж төсөвлөж байгаа. Тэгэхээр одоо хэрэв энэ чигээрээ явах юм бол 2027, 2028 онуудад бол бид нар төхөөрөмж бол талдаа ч хүрэхгүй ийм байдал үүснэ.

2027 онд шуурхай арга хэмжээ аваад төхөөрөмжийг нөхөж авлаа гэж бодоход бид нар программ хангамж болон зүгшрүүлэлтийн ажлууд сургалтын асуудлууд бол хийж гүйцэх тийм хугацаа бол маш хомс. Ийм эрсдэлтэй байдал үүсэх юм аа. Тэгэхээр яах вэ зүгээр энэ хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд орсноор бол энэ 41 тэрбум 720 сая төгрөгийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ гээд сүүлд нь нэг жаахан арай жаахан өөрчлөлт ороод явчихсан байгаа. Эхлээд бол 12 тэрбум гээд бүр ингээд хатуу хасчихсан байснаа тэгээд энийг 3 жилд гэх юм бол ирэх жил 2026 он, 2027, 2028 он нөгөө сонгуулиуд явж байхад төхөөрөмжөө авна гэж яагаад ч тооцох боломжгүй. Бид нарт бол бэлдэх хугацаа ирэх жил л байгаа юм. Тэгээд ингээд одоогоор мянган төхөөрөмжийн 12 тэрбум 516 сая төгрөгийг л Сангийн яамны хянаснаар туссан байгаа. Бидэнд шаардлагатай хөрөнгө бол 41 тэрбум 720 сая төгрөг байх аа.

Ц.Сандаг-Очир: Энэ дээр ажлын хэсгийн 9 номерын микрофон, Санжаадорж дарга. Сонгуулийн хорооны даргын нэг дэх асуулт дээр.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя Дэлгэржаргал. Тэгэхээр СЕХ ер нь Онцгой байдал гээд энэ яг тусгайлан анхаарсан бодлогын хувьд яг эрэмбэлж салбаруудыг бодлогынх нь хувьд эрэмбэлээд мэдээж хэрэгцээ шаардлагын хувьд нийтдээ 14 их наядын санал ирсэн. Энэ хөрөнгө оруулалтуудыг бид нар 3.2-т ийм багтаах ийм шаардлага үүссэн. Тэгэхээр салбар хооронд нь бодлогын эрэмбэлэлтүүд хийгдсэн байгаа. Тэгээд энэ дотроо бол мэдээж онцгой байдлын салбар хүний хүний хөгжлийн салбар, СЕХ.

СЕХ гээд аваад үзэх юм бол хязгаар дээр угаасаа огт хязгаар байхгүй. Тэгэхээр бид нар 47 тэрбумаар тусгах ямар ч боломж байгаагүй.

Хэрвээ энэ ирэх жил худалдан авалтуудаа хийгээд тоног төхөөрөмжөө авах юм бол бид нар 2028 оныг 2027 он дээр.

Ц.Сандаг-Очир: Гүйцээж хариулъя 9 номер.

Ж.Дэлгэржаргал: 2027 он дээр татаад үлдэгдлийг нь тавих боломжтой. Тэгэхээр бид нар 12 тэрбумыг тавихын тулд төсөвт өртгийн хувьд 47, санхүүжихийн хувьд 12. Тэгэхээр 12 тэрбумыг тавихын тулд бусад салбарын хөрөнгө оруулалтуудаас босгох боломжтой. Хөрөнгө оруулалтуудыг хасаж байж тусгасан гэсэн үг. Тэгэхээр хязгаар угаасаа огт байгаагүй ийм зохицуулалт хийсэн. Тэгэхээр заавал 2028 он гэж харах биш яг гүйцэтгэл 100 хувь гарах юм бол бид нар 2027 оны төсөв өргөн барихдаа оныг нь нааш нь татаад үлдэгдлийг нь тавиад 2027 оны нэг сард санхүүжилт авах боломж байгаа.

Ц.Сандаг-Очир: Сая Сонгуулийн хорооны даргын тайлбарыг сонссон уу үгүй юу? Сонгууль, Ерөнхийлөгчийн сонгууль ээлжит сонгуулиуд ямар ач холбогдолтой билээ. Тухайн ондоо багтаж амжихгүй ээ. Зүгшрүүлэлт хийнэ, сургалт сурталчилгаа хийнэ. 2026 ондоо л багтаж авч байж бид нар ажлаа амжуулна л гээд яриад байна шүү дээ. Тэгээд та болохоор 2027 оны 1 сар, 2 сард нь багтаачихна гэсэн юм ярих гэж байна. Тэгээд энэ цаг хугацааны хувьд боломжгүй байна гээд Сонгуулийн хорооны дарга яриад байна. Энийгээ одоо та нар маань Сангийн яам бас онцгой анхаараарай. Энэ ахиад яригдах байх шүү. Ахиад яригдана. Аягүй бол зарчмын зөрүүтэй санал гаргах байх. Энэ дээр та бүхэн манай хариулт юмнуудаа тооцоо судалгаа хийгээрэй. Ажлын хэсгийн 8 номерын микрофон.

Г.Ганболд: Гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийлөгчийн төсөвтэй холбоотой Хэвлэл мэдээллийн хэрэгслээр өмнөх Ерөнхийлөгчийн үеийн төсөв нэлээн өссөн байдлаар мэдээлэл яваад байгаа. Энэ дээр тодорхой бодит мэдээлэл өгье өө гэж бодож байна. Ерөнхийлөгчийн төсөв бол Ерөнхийлөгчийн төсөв, Ерөнхийлөгчийн Тамгын газрын төсөв, Монцамэ агентлаг, Монгол Улсын хэлний зөвлөл гэсэн 4 байгууллагын төсвөөс бүрдэж байгаа. Төсөв өссөн үндсэн шалтгаан нь бол 2021 онд тухайн үеийн Засгийн газраас Монцамэ агентлаг буюу 114 хүнтэй энэ агентлагийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын харьяанд байх нь зүйтэй юм гэж үзээд энэ байгууллагыг төсөвтэй нь удирдлагыг нь ингээд шилжүүлчихсэн байдаг юм. Энэ агуулгаараа бол энэ байгууллагын төсөв

нэмэгдсэнтэй холбоотой ерөнхийлөгчийн төсөв бага зэрэг өссөн ийм дүн харагдаад байгааг та бүхэн 1 дүгээрт ойлгох ёстой.

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд хариулъя.

Г.Ганболд: Гол өссөн зардлууд дотор бол 2 зардал байгаа юм. Нэг нь гадаад арга хэмжээтэй холбоотой. Нэг нь энэ төрийн одон медальтай холбоотой 2 зардал өмнөх жилүүдтэй харьцуулбал бага зэрэг өссөн. Энэ бол Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад бодлогод маш их ач холбогдол өгч байгааг та бүхэн мэдэж байгаа байх. Өнгөрсөн өмнөх Ерөнхийлөгчийн төсөвтэй харьцуулаад байгаа учраас би нэг харьцуулсан 2, 3 тоо хэлье гэж ингэж бодож байна. Өмнөх Ерөнхийлөгч бол 4 жилийн хугацаанд Монгол Улсад нийтдээ 4 гадаад том хэмжээний айлчлал хийгдсэн байдаг юм. Гадагшаа нэг 11 удаагийн айлчлал гээд нийтдээ 4 жилийн хугацаанд 15 айлчлал хийгдсэн байдаг бол энэ удаагийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлого идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой өнгөрсөн 4 жилийн хугацаанд 35 удаагийн төрийн өндөр хэмжээний айлчлалуудыг зохион байгуулсан. Тэр дундаа та бүхэн мэдэж байгаа бол Монгол Улсад НҮБ-ын Ерөнхий нарийн.

Ц.Сандаг-Очир: Гүйцээж хариулъя.

Г.Ганболд: НҮБ-ын ЕНБД Ромын Пап лам, Японы Эзэн хаан, Францын Ерөнхийлөгч, Польшийн Ерөнхийлөгч, Австрийн Ерөнхийлөгч, Австралийн амбан захирагч гэх мэтчилнээр 15 удаагийн төрийн өндөр хэмжээний айлчлал хийгдсэн. Энэнтэй холбоотой гадаад арга хэмжээний зардал бага зэрэг өссөн байгаа. Төрийн одон медальтай холбоотой асуудал бол 2021 онд Монгол Улсын Ерөнхийлөгч сонгогдсон тухайн жил Ардын хувьсгалын 100 жилийн ой тохиосон юм билээ. Энэ 100 жилийн ойтой холбогдуулаад бүх аймгуудын 100 жил зөвхөн өнгөрсөн жил гэхэд 120-оод сумын 100 жил. Тэгээд Монгол Улсад энэ ардын хувьсгал ялснаас хойш эрчим хүчний, тээврийн, харилцаа холбооны гээд бүх байгууллагуудын энэ 100 жилийн ойнууд буцсантай холбоотой төрийн шагналуудын тоо нэмэгдсэн. Нөгөө талаараа бол.

Ц.Сандаг-Очир: Ойлголоо. Нэг минут.

Г.Ганболд: Тухайлах юм бол алдарт эхийн одон гэхэд өнгөрсөн жилүүдэд бол 7 мянга гаран эх алдарт эхийн одон авдаг байсан бол сүүлийн жилүүдэд энэ хүн амын тоо өссөнтэй холбоотой зөвхөн энэ жил гэхэд 14500 эх Алдарт эхийн одон авсан байгаа юм. Тийм учраас энэтэй холбоотой бага зэргийн зардлууд өссөнийг эс тооцох юм бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөв дээр хөрөнгө оруулалттай холбоотой ямар ч зардал байхгүй. Тэр битгий хэл та бүхэн ордонд байдаг хүмүүс мэдэж байгаа байх. Ерөнхийлөгчийн Тамгын газрын ажилтан албан хаагчид бол сүүлийн бараг хориод жил тавилга тоног төхөөрөмжийн ч зардал тавигдаж байгаагүй юм билээ. Энэнтэй холбоотой яг бодит зардлууд бага зэрэг өссөн ийм зүйл байгаа гэдгийг хэлье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. 3 дахь асуултад Сангийн яам хариулъя. Ажлын хэсгийн 9 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Олон нийтийн радио

телевизийн тухай хууль 2005 оны 1 сарын 27-нд батлагдсан байдаг. Хууль дээр бол батлагдсантай холбоотойгоор бол улсын төсвөөс бол санхүүгийн дэмжлэг бол Үндэсний олон нийтийн радио телевизэд бол олгож болохоор заасан байдаг. Энэ хууль батлагдсантай холбоотойгоор 2006 оноос хойшоо бол Сангийн сайдын багц дээр бол энэ дэмжлэг бол батлагдаад явсан байдаг. Ийм тоотой юм байна лээ дээ.

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. 2026 оны Төрийн байгуулалтын байнгын хорооны харьяаны төсөвтэй холбогдуулаад гишүүд үг хэлж болно оо нэрсээ өгнө үү. Саранчулуун гишүүнээр тасаллаа. Шижир гишүүн үгээ хэлье.

Ө.Шижир: Сая 3 хоног Завхан аймгийн сумдуудаар ажиллаад ирсэн. Тэгээд тухайн аймгийн сумдад ажиллаж байгаа одоо жишээ нь Отгон сумын эмчтэй уулзахад бол 28 дахь жилдээ ажиллачхаад ирэх жил тэтгэвэртээ гарах гэтэл миний 36 сарын тэтгэмжийг өгөхгүй байхаар би энд 28 жилд ажиллачхаад 1.7-хон сая төгрөг гар дээрээ авч байхын оронд Улаанбаатар хотод ч очиж хувийн эмнэлэгт сувилагч байтугай хийсэн нь надаа дээр байна гэж байгаа юм. Үүн дээр ахмадууд маш их бухимдаж байгаа юм.

Яагаад үг хэлж байхад гараад явчхаж байгаа юм. Энэ ажлын хэсгийнхэн. Хэнд хэлэх юм надад хэлээгүй шүү дээ Шижир гишүүн гишүүд. Дуудаач. Эдийн засаг, хөгжлийн яамныхан, Сангийн яамныхан. Энэ тэндээс дуудаад байгаа юм уу Байнгын хороодууд дуудаагүй биз дээ. Ядаж төлөөллөө оролцуул л даа бүгдээрээ тал хувь нь, 50 хувь нь гараад явчихлаа шүү дээ үг хэлнэ гэхэд. Тэгээд бид нар яах юм өөдөөсөө харж байгаад гишүүд өөр өөртөө үгээ хэлэх юм уу?

Ө.Шижир: Угаасаа Ийм л болчхоод байгаа шүү дээ. Сайд нар нь байхгүй. Ганцхан Бямбацогт сайдтай. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асууна гэхэд Бямбацогт сайдаас өөр ямар ч захирагч ирж орж ирсэнгүй шүү дээ.

Ц.Сандаг-Очир: Ядаж үг хэлэхэд нь бай даа, наашаа оруул даа наад улсуудаа. Байнгын хорооны хуралдаанд орж байгаа бол эхлүүлээд дуустал нь хурал дуустал нь суух ёстой шүү дээ. Сууж байгаа улсууд гишүүдийн асуусан асуултад бичиж авч тэмдэглэж, үнэн зөв бодит тоо баримттай хариултыг өгөх үүрэгтэй шүү дээ. Шижир гишүүний микрофоныг ахиад өгье.

Ө.Шижир: Сая 3 хоног дахиад л давтахаас. Хөдөө яваад ирэхэд Завхан аймгийн Отгон суманд байгаа эмч 28 дахь жилдээ ажиллачхаад тэтгэвэрт гарах гэхээр миний тэтгэмжийг 2 хувааж өгөх юм байна аа. Би 1.7-хон сая төгрөг гар дээрээ авдаг учраас 30 жил гарчхаад тэтгэмжгүй хоцрох юм байна гэдэг асуудал ярьж байгаа юм. Энэ хооронд миний түрүүн сая Сангийн яамнаас асуугаад хариулт авч чаддаггүй хүний амьдралд болдог амьдрал чинь олон өнгөтэй шүү дээ. Хүний амьдралд болдог зүйл нэг бол яах вэ тэр тэтгэмж дээр яах вэ гэж байгаа юм. Тэтгэвэртээ гарч байгаа Ахмад настны тухай хуулийг нь хуульчилсан юм л даа. Тэгээд энэ нэг талаасаа хууль зөрчөөд байгаа юм шиг байна. Тэгэхээр би энэ дээрнэг хууль зүйн дүгнэлт Байнгын хорооны даргаас чиглэл өгөөд гаргуулах юм уу гэдэг асуулт асуумаар байгаа юм.

Хоёрдугаарт энэ хүний эрхийн зөрчил мөн үү гэдэг дүгнэлт бас гаргуулмаар байгаа юм. Бид нар чинь мөнгөгүй биш мөнгөтэй улс шүү. Сүүлийн 5 жил Сангийн яам 135 их наяд төгрөгийг зарцуулсан шүү. Зөвхөн 2024, 2026 оны төсөв дээр чинь

шилжиж орж ирж байгаа 139 барилга байгууламж анхны төсөвт өртгөөсөө 805 тэрбумаар өссөн. Энэ анхны дүн биш 805 тэрбум, ахмадаас харамлаад байгаа 375 тэрбум чинь энэ дотор байгаа юм. Сургууль, цэцэрлэгийн хүртээмжээс харамлаад байгаа мөнгө чинь энэ дотор байгаа юм. Сургууль, цэцэрлэг, барилга байгууламж, төрийн байгууллагууд хугацаандаа барихгүй болохоор мөнгө нь байна гээд өгөөд байдаг. Ахмадаасаа харамлаад хүүхдүүдээсээ харамлаад байдаг байж болохгүй энэ чинь. Энгийнээр ярих юм бол хүүхдийнхээ хичээл, сургууль, хичээлийн гадуурх хөтөлбөр, хэрэгцээнээс нь мөнгийг нь харамлачхаад тэр мөнгөөрөө аав нь шоудаад архи уугаад байна гэсэн үг шүү дээ. Мөнгө байхгүй биш байгаа байхгүй юу. Анхны төсөвт өртгөөсөө ингээд 800 тэрбумаар өсөж байна шүү дээ. 2026 онд хэрэгжиж байгаа 139 төсөл чинь. Энэ чинь мөнгөгүй улсын зовлон юм уу. Энэ чинь мөнгөтэй улсын зовлон. Та нар төсвөө буруу хийж байна гэсэн үг. Та нар мөнгөөр төлж байна гэсэн үг байхгүй юу. Түрүүн хэлсэн хамгийн багадаа би дахиад хэлж өгье. Хамгийн багадаа 5 дахин нэмэгдэж байна. 500 хувиар буюу 5 дахин нэмэгдэж байна. Урсгал зардал нь 855 хувийн хувиар буюу 85 дахин өсөж байна. Багаж техник хэрэгсэлтэй холбоотой зардал нь 2800 хувиар буюу 280 дахин өсөж байна. Зөвхөн урсгал засвар нь 85 дахин өсөж байна. Тэгээд бид нар ингээд нэг бүгдийг нь шийдсэн болох гээд тэр хэрээрээ нэг сумын төвд 1.5-хан километр замыг 3 жил бариад.

100 хүүхэдтэй хүүхдийн дотуур байрны барилгыг 7 жил бариад, 320 хүүхдийн сургуулийн барилгыг 8 жил бариад төсөвт өртгийг нь нэмсээр байгаад явдаг. Энэний ард шалгадаг байгууллага байдаггүй юм уу? Одоо энэ аудитын дүгнэлтээр чинь 39 барилга байгууламж ав, магадлан байхгүй гээд биччихсэн байна лээ шүү дээ. Тэгээд бид нарын төсөв хэлэлцсэн болдог, та нарын сонссон болдог тэгээд төр ороод ирдэг хугацаандаа шахагдаад. Нэг ийм байдлаар хэдэн жил явах гэсэн юм бэ? Энэ чинь айлаар ярих юм бол та нар санхүүгийн сахилга бат маш муу айл байгаа байхгүй юу. Аягүй өндөр цалинтай орлоготой аав ээж 2 байгаад байдаг. Хүүхдүүдийнхээ хувийн хэрэгцээг шийдэж чаддаггүй. Гэр орныхоо хамгийн анхны анхан шатны хэрэгцээг шийдэж чаддаггүй ийм маш сахилга муутай айл болж байгаа байхгүй юу.

Тэгээд энэ төсөв дээр нь боловсролын жил гээд зарлачихсан. Тэгээд Боловсролын дэд сайдынх нь хүргэх үр дүн, арга хэмжээ, чанар дээр нь 51 ээлжийн сургуульд нь нэг ээлжлэлийн сургуулийг 61 болгоно гээд биччихсэн. Тэгээд 2 ээлжтэй, 3 ээлжтэй, сургуулиа нэг ээлжтэй болгох зорилт тавьдаггүй юм уу? Хэрэглэгчийн эрхийг 100 хувь хамгаална гээд биччихсэн. Зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг 100 хувь бүрдүүлнэ гээд бичсэн. Гэтэл төрийн ДНБ-ий чинь 74 хувийг төр үйлдвэрлээд байна шүү дээ. Тэгээд ямар ийм зах зээлийн чөлөөт нийгмийн орчныг 100 хувь бүрдүүлнэ гэж бичээд байгаа юм? Энэ Эдийн засаг хөгжлийн яамныхан байна уу? Хэрэглэгчийн эрхийг та нар 100 хувь хамгаалаад байгаа юм уу? Монголд тийм хэрэглэгчийн эрхийн гомдол гаргаж байгаа гомдол байхгүй болчихсон юм уу? Энэ цаасан дээр чинь ингээд биччихсэн байгаа байхгүй юу 100 хувь, 100 хувь, 100 хувь гээд. Тэгээд бид нар чинь хүн төвтэй төсөв ийм байдаг юм уу? Мөнгөтэй юм байж хүн. Хөвтэй төсөв нь ахмадынх нь тэтгэмжийг 2 хувааж өгдөг юм уу? Засгийн газрынхаан.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Төрийн байгуулалтын байнгын хороо төрийн албан хаагчдынхаа энэ эргэлзээг тайлах хэрэгтэй. Тэгээд би түрүүн бас асуултаа асуухдаа хүсэлтээ илэрхийлсэн. ТББХ-ноос албан ёсны хууль зүйн лавлагаа авах хэрэгтэй. Бид төсвөө хэлэлцэх эсэх нь шийдвэрлэгдээд, хүлээн аваад ажлын хэсгийн хүрээнд

яригдсан ч тэр энэ 178 тэрбум төгрөгийг эргүүлэн тавихад хуулийн дагуу зайлшгүй тавих ёстой юм гэдэг албан ёсны энэ тайлбараа бол авчих нь зүйтэй. Тэгэхээр миний дараа нэг 3 хүн үг хэлэхээр байх шиг байна. 10 минутын дараагаар санал хураана гээд нэг ирцээ бүрдүүлээд Байнгын хороодын гишүүддээ нэг зарыг нь хүргээд яг энэ төрийн албан хаагчдынхаа эргэлзээг нь тайлах тал дээр Төрийн байгуулалтын байнгын хороо анхаарах хэрэгтэй байна аа. Энэ дээр одоо анхаарч хэрэвзээ заавал санал хураахгүйгээр Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга өөрөө энэ лавлагаа авах боломжтой бол та өөрөө авна биз. Хэрэвзээ боломжгүй, заавал санал хураах ёстой гэвэл нэг Байнгын хорооны хуралдаанаа хаахгүйгээр заавал ч үгүй энэ ирцээ бүрдүүлж байгаад энэ хууль зүйн лавлагаа авах санал хураалтыг явуулж өгөөч гэдэг ийм хүсэлттэй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд юу гэж заасан бэ гэхээр 6.4.8, төсвийг зохистой удирдаж авлага өр төлбөр үүсгэхгүй байх. Төсвийн тухай хуулийн 70.5 дээр төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно. Төрийн албаны тухай хуулийн 9.2 төрийн албаны зардлыг бууруулах талаар төрөөс авах арга хэмжээ нь төрийн албан хаагчид олгох цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, тэтгэвэр тэтгэмж болон бусад төлбөрийн хэмжээг бууруулах төр буюу бүр бүрмөсөн зогсоох үндэслэл болохгүй гэж ингээд хуульчлаад заагаад өгчихсөн байгаа юм.

Тэгэхээр яг энэ маань Төсвийн тухай хууль дээр орж ирсэн өндөр настны тэтгэвэртээ гарах хүсэлтээ илэрхийлсэн байгаа төрийн албан хаагчдын төсвийн эх үүсвэрийн 50 хувийг нь л оруулж өгсөн нь 50 хувийн эх үүсвэр бол дутагдана аа. Тэгэхээр энд бол гарцаагүй хуулийн маргаан үүсэх учраас үүн дээр эхнээс нь одоо бид асуудлыг маш тодорхой болгож төсвөө батлахдаа энэ хуулийн зөрчилгүй байх тал дээр нь анхаарч төрийн албан хаагчдадаа бас нэг тайван байх дохиог нь өгөхгүй бол энэ ердөөсөө болохгүй ээ. Тэгээд нэн ялангуяа Төрийн байгуулалтын байнгын хороо энэ асуудалд зайлшгүй анхаарах хэрэгтэй. Тэгээд энэн дээр бол ирцээ бүрдүүлээд санал хураалгаж өгөхийг хүсэж байна.

Хэрэв зээ заавал санал хураахгүйгээр та өөрөө явуулчихна гэж үзэж байгаа бол зайлшгүй энэ лавлагааг цагаан цаасан дээр хараар буулгаж баталгаажуулж өгөхийг хүсэж байна аа.

Ц.Сандаг-Очир: Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн заалтын дагуу хууль зүйн лавлагаа зөвлөмж авахыг авах тохиолдолд Байнгын хорооны гишүүдийн санал хураалтаар шийдэх ёстой юм байна.

Тийм учраас Ариунзаяа гишүүнээс тавиад байгаа төсөв дээр орж ирж байгаа төрийн албан хаагчдын тэтгэмжтэй холбоотой асуудал дээр хууль зүйн зөвлөмж гаргуулья гэдэг хүсэлтийг гаргасан тохиолдолд Байнгын хорооны гишүүдийн дунд санал хураалт явуулна.

Ажлын алба санал хураалт явуулах юм байна ерөнхийдөө. Дэг дээр яг заавал тэгж байгаа учраас би дур мэдээд Байнгын хорооны дарга гээд бичиг явуулахаар бас дэг зөрчихөөр байгаа учраас нэгхэн санал хураалт явуулахаар байна гээд дотор байгаа гишүүдээ дуудаадхаач.

Тэгээд санал хураалт. Одоогийн байгаа ирцээр санал хураавал уначихаар харагдаад байна.

Саранчулуун гишүүн үгээ хэлье.

О.Саранчулуун: Нөгөө түрүүний асуулттайгаа холбогдуулаад 3 байгууллагадаа хандсан үгнүүдийг хэлье.

Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дүгээрт Монгол Улсын иргэн төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагад сонгох сонгогдох эрхтэй гэж заасан. Сонгуулийн байрны хүртээмж сонгуулийн орчныг мэдээллийн болон орчны хүртээмжийг бүрдүүлээгүй байгаа. Энд бид нар ингээд зөвхөн юу гэдэг юм мөнгө байхгүй байна гээд ярьж байгаа нь өөрөө хууль зөрчиж байгаа асуудал гэж би үзэж байгаа. Тийм болохоор энэ дээрээ төрийн байгууллагын төсвөөс гадна маш олон гадаадын, дотоодын тусламж олон улсын төслөөр олон ажлуудыг хийж болоод байгаа ажлууд яваад л байх юм. Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалтай холбоотой нэг ийм хүртээмжийн юм ярихлаараа эсвэл нийгмийн эрүүл мэнд гамшгийн асуудлыг ярихаараа энэ салбар дундын юм ярих болохоороо манайд мөнгө байхгүй эсвэл Сангийн яам зөвшөөрөөгүй гээд Сангийн яам нь болохоор өгсөн мэдээлэл нь л энэ байна шүү дээ. Шалгуур нь байхгүй байна шүү дээ гэж. Ингэж хандаж бие бие рүүгээ теннисний бөмбөг шидэж байгаа юм шиг ингэж хариулдгаа болихыг албан ёсоор шаардаж байна, дахин шаардаж байна.

Хоёрдугаарт болохоор ер нь энэ гамшиг, гамшгийн үед онцгой байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэхгүй ер нь энэ эмзэг бүлгийн хүн амд зориулсан мэдээлэл угаасаа тодорхой биш. Стратеги бодлого чинь нүдэнд харагдаж гарт баригдахаар байхгүй л байгаа шүү дээ. Тэрийг энд ирэхээрээ байгаа шүү дээ бололгүй яадаг юм. Хаа газар байгаа гээд. Тэгвэл яагаад би тэр ганцхан удаагийн онцгой байдлын шалгаруулалтын юу билээ сургуулилтын үеэр тэгээд гарах гэсээр байгаад тэгээд гарч амжаагүй юм. Яагаад надад хүрээгүй юм. Улсын Их Хурлын гишүүн болсон хүнд хүрэхгүй байгаа мэдээлэл гишүүн биш иргэнд яаж мэдээлэл хүрэх юм бэ. Хүртээмжийн хувьд бодоод үзэхээр. Тэгэхээр ийм амьдралтай мэдээллүүдийг ярьж мэдээлэл өгмөөр байна. Бүтэн жил төрийн албаны Засгийн газрын хүмүүстэй ярьж, маш сайхан хандаж, араас нь заримдаа гуйж, аргадаж, тайлбарлаж, багш шиг зааж зөвлөж л явлаа.

Алийн болгон Засгийн газрын зөвлөх шиг ажлыг хийх юм бэ? Тэгээд 1 иймэрхүү юм асуухаар дандаа та л гишүүн ээ, та нэг зөвлөөч, та ингээч гэдэг яриагаа хэзээ болих юм. Та нар өөрсдөө энэ та нарын ажил шүү дээ. Энийгээ гарга л даа. Гамшгийн асуудлаар Онцгой байдал дээр.

Гуравдугаарт нь ТАЗ-д төрийн албаны тусгай болон ерөнхий шалгалтын сорилын сан, төрийн албаны шалгалтын ер нь энэ агуулга дээр хүний эрхийнхээ асуудлыг илүү тод оруулмаар байна. Хөтөлбөрт нь оруулъя гэхлээр удна. Энэ чинь ингээд хөтөлбөртөө оруулаад батлагдсаар байтал удна. Одоо нэгэнт сорилын сангаа шинэчилж байгаа бол тэрэндээ оруулчих. Хүмүүс тэрэнд бэлдэхийн тулд уншиг судлаг. Хөгжлийн бэрхшээл гэж юу юм, түгээмэл хандлага гэж юу юм? Хүртээмж гэж юу юм? Универсал дизайн гэж юу юм. Хаалга яагаад налуу байх ёстой юм, харааны бэрхшээлтэй хүн мэдээллийн хүртээмж гэж юу юм гэдэг наад захын ойлголтоо аваг л дээ. 1111 рүү залгахад хүртэл өнөөдөр асуудалтай байж л байгаа шүү дээ өнөөдөр.

Тэгэхээр иймэрхүү зүйлүүдээ бодитой ажил болгож хиймээр байна. Өмнөх жил шиг асуучхаад араас нь ингээд хариу ирэх юм болов уу гээд хүлээдэг. Ийм жил байхгүй гэдгийг анхааруулъя. Улам ихээр шаардлага тавина, улам ихээр асууна.

Бичгээ ч явуулна болохгүй бол явж очно оо. Энэ бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх юм билээ. Иргэдийг төлөөлж байгаа учраас. Тэгэхээр энэ 3 байгууллагад гурвууланд нь би хэлсэн үгээ үүрэг даалгавар гэж цохож бүр тэмдэглэмээр байна. Тэгээд хариуг нь албан ёсоор байгууллагынх нь сайт дээр бичнэ үү намайг хаяглана уу? Бид нар ингэж байгаа тэгж байгаа гэдгээ иргэдэд мэдээлээд өгөөч ээ. Би мэдээлэл авч чадахгүй байхад надаас хэцүү байгаа хүмүүс яаж та нарын тэр болж байгаа бүтэж байгаа мэдээллийг чинь авах вэ дээ. Тэгээд яагаад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авахгүй байгаа юм бэ? Ажилд авах тухай Бямбацогт сайдтай бид нар өмнө нь ярьсан шүү дээ. Албан бичиг гаргаад явсан. Тэрний хэрэгжилтээ өнөөдөр ярья. Энэ жил тоог нь өсгөө төрийн албанд ажиллаж байгаа хүмүүсийн тоог жинхэнээсээ ажилд авмаар байна. Худлаа дүр эсгэж биш.

Ц.Сандаг-Очир: Бямбацогт гишүүн үг хэлнэ.

С.Бямбацогт: Саранчулуун гишүүнтэйгээ хамтарч ажиллана аа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилтай болгох тал дээр анхаарч хамтарч ажиллаж эхэлсэн байгаа. Хоёулаа үр дүн гаргахын төлөө хамтраад сайхан ажиллая аа. Улсын Их Хурал бол хууль тогтоох дээд байгууллага, төрийн бодлого тодорхойлох дээд байгууллага. Засгийн газар бол гүйцэтгэх дээд байгууллага. Улсын Их Хурлын баталсан хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Үндсэн хуулиар ингэж заасан байдаг. Энэ дээр л нэг жоохон жоохон асуудал яг ялангуяа төсөв хэлэлцэх хүртэл бид ярьдаг, үүсээд байдаг. Нэг талдаа ажил хий гэдэг, нөгөө талдаа ажил хийх бололцоог нь хязгаарлачихдаг. Тэгээд үүнээсээ болоод ингээд тодорхой орон зай дотор ажиллах хэцүү, ажиллахгүй байх хэцүү. Үүнийг бас нэг зөв зохицуулахдаа бас нэг эрэмбэ дараа зарчим шаардлага. Энэ дээр жаахан алдах тал байдаг. Энийгээ засаж залруулдаггүй дахиад дээрээс нь юу гэдэг юм ажил хариуцсан албан тушаалтнууд нь заримдаа одоо асуудалдаа хайнга, хариуцлагагүй ханддаг гэх мэтийн одоо олон талын алдаанаас асуудлаас болоод төсвийн хэлэлцүүлэг, төсөв батлах процесс, үйл явц маань нэг тийм сайн л биш байгаад байна л даа.

Улсын Их Хурал төсөв батлах энэ хамгийн том ажил. Засгийн газар төсвийг Их Хуралд өргөн барих хамгийн том ажил. Урьд нь хаа хамаагүй төсөв өргөн барьдаг байсан үүнийг төлөвлөгөө дээр суурилж төлөвлөлт дээр суурилсан төсөвлөлт байх ёстой шүү гээд жилийн төлөвлөгөө баталдаг болсон. Үүн дээрээ суурил гэсэн. Гэтэл энэ маань хэрэгждэггүй. Төсвийн хэмнэлтийн тухай хуулиар бүх зардлуудыг нь хасаад танаад ингэчих гээд хязгаарлачихдаг. Жилийн төлөвлөгөөгөөр бид нар тийм үү төсвийн урсгал зардал ДНБ 24-өөс хэтрэхгүй байх ёстой юм шиг хязгаарлачихдаг. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиараа төсвийн алдагдал гадаад өрийн тааз хэмжээ энийг хязгаарлачихдаг. Төсвийн хүрээний мэдэгдлээрээ хөрөнгө оруулалтын хэмжээ, урсгал зардлын хэмжээ гээд бүгдийг хязгаарлачихдаг.

Тэгээд энэ хязгаар дотор нь жилийн төлөвлөгөөн дээр жишээ нь юу гэдэг юм төрийн албан хаагчдын орон тоог 9 хувьд цомхотгох гээд өгчихсөн Засгийн газраас цомхотгохоор цомхотголоо гэж ярина.

Иймэрхүү л байдалтай л яваад байна л даа. Яг үүнтэй адилхан юу гэдэг юм тэгчхээд төсөв оруулаад ирэхээр хөрөнгө оруулалт хийсэнгүй, хөрөнгө оруулалт шийдэх ёстой, зам барих ёстой, сургууль барих ёстой эмнэлэг барих ёстой энэ яачихсан юм энийг хийгээч гээд. Цалин тэтгэвэр нэмээч гээд. Гэтэл нэг урсгал зардал нь 24-д баригдах ёстой биш 24 дотор л хязгаарлагдчихсан нэг ийм л байдалтай болчихоод байгаа юм л даа. Нэг талаасаа чөдөрлөчхөөд ташуурдаад байдаг, уул нь чөдрийг нь авчхаад ташуурдах юм бол арай ч хурдан давхих байх. Чөдөртэй морь чинь хол давхихгүй шүү дээ. Ингээд нөгөө бусад хуулиудаараа Засгийн газраа чөдөрлөчхөөд дээрээс нь одоо юм шийд гээд ташуурдаад байхаар чинь давхихгүй л дээ. Нэг иймэрхүү л байдалд бид нар орчихоод байгаа юм.

Тийм болохоор Улсын Их Хурал дээр энэ Засгийн газрынхаа чөдрийг явах энэ хязгааруудаа. Тэгээд ташуурдах энэ юмаа л нэг сайн хийгээд энэ төсөв хэлэлцэж байгаа үедээ яг юунаасаа болоод юу нь болохгүй байгаа юм яаж ямар асуудал байгаа юм. Ямар шийдэл байгаа юм. Энийг шийдсэн нь ямар үр дүн гарах юм, ямар ач холбогдолтой юм гэдгээ нэг тодорхой бүгдээрээ харж сайхан тойрч суугаад Их Хурлаараа, Засгийн газраараа энэ төсөв хэлэлцэж байгаа үедээ. Ингээд нэг алдаануудаа засчихвал яасан юм бэ? Олон жил ярьсан алдааг өнөөдөр энэ шинэ 126 засмаар байна. Шинэ уур амьсгал орж ирж байгаад талархаж байгаа.

Тийм болохоор энийг л одоо нэг жилийн хугацаанд суралцлаа, ойлголоо. Одоо бүгдээрээ энийгээ нэг засаад нэг урагшаа хараад явахаар энэ төсвийн хэлэлцүүлгүүд маань болоосой. Төсвийнхөө хэлэлцэх эсэхийг нь шийдээд дараа дараагийн хэлэлцүүлгүүд дээр энэ ал алдаануудаа хамтад нь засаад ганцхан төсөв биш төсөвтэй холбоотой нэг талаас нь хязгаарлачхаад, нөгөө талаас нь чөдөрлөчхөөд ташуурддаг. Энийг л одоо нэг хамтад нь нэг шийдчих юмсан. Энийг гишүүд анхаараасай л гэж хүсэж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Сархадын Зулпхар гишүүн үг хэлнэ.

С.Зулпхар: Хөгжлийн бодлого төлөвлөлтийг нэгдмэл байлгана. Гэхдээ салбарын онцлогтой байлгана гэдэг үүднээс Эдийн засаг хөгжлийн яамыг бол бид нар байгуулсан шүү дээ. Эдийн засаг хөгжлийн яам бол шинэ яам гэж тухайн үед ойлгож байсан. Гэхдээ энэ шинэ биш, сайтар мартагдсан. Жишээ нь сайн зүйл байсан байхгүй юу. Социализмын үед төлөвлөгөөний комисс үндэсний хэмжээний хөгжлийн бодлого төлөвлөлтийг нэгтгэдэг байсан.

Тэрийг л буцаж эргээж авчирсан. Энэ өөрөө сайн зүйл. Шүүмжлэл тэр үед явж байсан юу гэж явж байсан гэхээр зэрэг Сангийн яаман дээр ерөөсөө хамаг жишээ нь төлөвлөлтөө хийгээд байна аа. Сангийн яаман дээр 1 дүгээрт яах вэ ачаалал өгч байна.

Хоёрдугаарт энэ өөрөө буруу гэдэг үүднээс Эдийн засаг хөгжлийн яамыг байгуулсан юм. Тэгээд Мөнхтөр даргаа тэр үүднээс энэ сая Бямбацогт сайд ч гэсэн хэлж байна. Хөгжлийн бодлогыг чинь нэгдмэл байдлыг гол зангидаг газар чинь өөрөө энд бол гол асуудлаа мэдээд хэлье. Өөрөө хариулаад, өөрөө хамгаалаад, зарим зүйл дээр магадгүй жишээ нь хүлээн зөвшөөрөх юм уу, хүлээн зөвшөөрөөд явдаг, ийм л болно гээд ингээд хийчихсэн зүйл. Энийг бол тухайн үед оролцож байсан бүх улсууд энд сууж байгаа учраас би зориуд сануулж байна гэж байгаа юм. Бид юугаа ч мэдэхгүй эс үгүй бол нэг юм хийгээд байгаа юм шиг ийм ойлголт яваад

байна аа. Тийм биш шүү дээ. Бид бүх зүйлээ салбар салбараар зохих түвшинд судлаад тэндээс саналаа өгөөд тэр саналыг нэгтгэдэг энэ зохион байгуулалт байж байгаа.

Мэдээж хэрэг зарим нэг сорилтууд байгаа. Тэр нь шалгууртай холбоотой, аргачлалтай холбоотой, туршлагатай холбоотой, мэдлэгтэй холбоотой гэдэг ч юм уу ийм зүйлүүд байгаа байх. Тэр тэртээ тэргүй жишээ нь шийдэгдээд явах ёстой зүйл шүү л гэж байгаа юм. Энийг зориуд хэлье ээ. Энэнтэй уялдсан байдлаар мэдээж хэрэг саяын шинжлэх ухааны асуудлыг ярьж байгаа юм байна. Мөнхтөр дарга аа. Яг одоо энэ саналыг гаргасан улсууд энэ дотор сууж байна. Тухайн үед жишээ нь энийг хийж байх үед бид яасан гэхээр зэрэг үе үеийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр тэр шинжлэх ухааныхаа бид зардлаа нэмэхгүй бол тооцоо судалгаагүй, салбарын бодлого нь ямар нэгэн жишээ нь судалгааны суурьгүйгээр яваад байна гэдэг ийм зүйл ярьсан байхгүй юу.

Тэгэхээр зэрэг та бүхэнд эрх нь байгаа. Танай харьяаны 24 ийм хүрээлэн байгаад байна шүү дээ. Жишээ нь би зүгээр статистик хэлье. ХАА-н салбар чинь энэ жилийн энэ жилийн манай ДНБ-ий би 2025 оны тухайд ярьж байгаа шүү дээ. Энэ 1 тэрбум доллар нь ХАА-н салбараас ирэхээр боллоо гээд сайд нь хэлчихсэн. Өөрөөр хэлбэл маш том өсөлт гарч байна, бодлогын дэмжлэг үзүүлсэн учраас гээд. Манай одоо жишээ нь ДНБ-ий 67 хувь нь уул уурхайн салбар. Тэгэхээр одоо би энэ хүрээлэнгүүд дээр байж байгаа зардлыг чинь харахаар зэрэг сая хэлээд байна шүү дээ. Геологийн хүрээлэн чинь ерөөсөө геологийн судалгаа хийгдээгүй байгаагаас болоод би нөгөө нэг уул уурхайн салбар дээр ямар нэгэн байдлаар гацалт үүссэн гээд яриад байгаа шүү дээ.

Тэгэхээр энийгээ шийдэхийн тулд энэ дээр та бүхэн хүссэн ч хүсээгүй ч хөгжлийн бодлого төлөвлөлт хийдэг танай шинэ яам бол энэ дээр төсөв тавьж өгөх ёстой. Сангийн яам бол мэдээж хэрэг байгаа хүрээндээ л энэ чинь үйл ажиллагааны зардлыг нь хуваарилсан байх. Гэтэл цаана нь зарим хүрээлэнгүүд дээр судалгаа байхгүй сууж байна шүү дээ. Судалгаагүй сууж байна. Суурь судалгаа хийгдэж байх ёстой зорилтот судалгаа хийгдэж байх ёстой. Шинжлэх ухаан хийгдэж байж энэ чинь дараа нь жишээ нь салбар салбарын бодлого чинь үндэстэй гарах ёстой учраас энэнээс бид ерөөсөө айж болохгүй ээ. Бид ингээд сошиалын жишээ нь янз янзын мэдээнд хөтлөгдөөд шийдвэр гаргачихдаг мөртөө шинжлэх ухааныхаа жишээ нь үндэстэй шийдвэр гаргаагүй дараа нь хоорондоо ингээд яриад сууж байна гэсэн ийм шүүмжлэлд өртсөн учраас танайхан энийгээ анхаар. Одоо засаад оруулж ирдэг юм бол засаж оруулж ир. Би тэр Үндэсний Шинжлэх ухаан технологийн сангийнхантай уулзсан чинь тэд нар хэлж байна шүү дээ. Бидэнд бол ийм санал өгсөн. Зарим хүрээлэнгүүд дээр судалгаагүй сууж байгаа гэдэг ингээд хэлж байгаа байхгүй юу ийм л байгаа. Та сая бол бид болж байгаа гэж хэлж байна.

Тэгэхээр болж байгаа гэдэг бол сайн байна л даа яах вэ төрийн албан хаагч хүний хувьд болгох гэж хичээж байгаа байх. Гэхдээ энэ чинь болохгүй байгаа юмаа бид нар үнэнээр нь хэлээд урагшаа явах ёстой шүү дээ. Улс орны чинь хувьд хүний хөгжил хамгийн одоо жишээ нь том мега төсөл нь юм бол хүний хөгжлийн чинь суурь нь бол эрдэм боловсрол, эрүүл мэнд, цаана нь шинжлэх ухаан л байгаа шүү дээ. Тэрнээс эс үгүй бол энэ сошиалын мэдээ ерөөсөө биш шүү дээ. Сошиал дээр бид нар яаж хэрэлдэж байгаа нь бидний хөгжлийг тодорхойлохгүй шүү дээ.

Тэгэхээр энэ талаас нь та бүхэн хандаж нийгмээ бас нэг соён гэгээрүүлэх мэдээллийг нь зөв хийх талаас нь ажиллахгүй бол. Төрийн байгуулалтын байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Ц.Сандаг-Очир: Хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. Гэхдээ Одоо Байнгын хорооны гишүүн Ариунзаяа гишүүнээс дэгийн тухай хуулийн 35.4 дээр төсөв дээр төрийн албан хаагчдын нэг удаагийн тэтгэмжийг он дамнуулж олгохтой холбоотойгоор энэ төсөл нь холбогдох хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж байгаа эсэхийг дүгнэлт гаргуулмаар байна, зөвлөмж гаргуулмаар байна гэсэн ийм санал тавьсан. Энэ нь 35.4 дээр Байнгын хороо хүсэлт гаргасан бол Тамгын газар хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж зөвлөмж гаргах бөгөөд хууль зүйн зөвлөмжийг Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлсэн байна гэсэн ийм заалттай байна.

Тэгэхээр Байнгын хорооны гишүүдийн хуралдаанд оролцож байгаа гишүүдийн дунд санал хураалт явуулаад олонх дэмжсэн тохиолдолд эрх зүйн шинжилгээ, дүн шинжилгээ, зөвлөмж гаргах ийм дэгтэй байна аа. Энэ дээр Сангийн сайд тайлбар байна уу? Та ирцэд Жавхлан Сайдын микрофоныг хуруугаа хийгээд уншуул.

Б.Жавхлан: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Саяын асуудал дээр яах вэ зөвлөмж гаргаж болох л байх тийм эрхтэй л юм чинь зүгээр. Би юманд тайлбар хэлье.

Улсын Их Хурал дээрээс гаргасан төлөвлөгөө дээр жилийн төлөвлөгөө дээр урсгал зардал 24 хувиас хэтэрч болохгүй гээд таазыг нь заачихсан. Гэтэл 200 гаруй хууль, мянга гаран заалтаар хэрвээ бүх хуулийн энэ төсвийн хуваарилалтыг багтаах юм бол бараг 30 их наяд гараад явчихна. ДНБ-ий 4 хувиас 4 хувиас багагүй байна аа. Боловсролын салбар, батлан хамгаалахын салбар, шинжлэх ухааны салбар гээд бүгдээрээ ийм заалтуудтай байдаг. Өшөө олон ч салбарууд байгаа. Өөрөөр хэлбэл хэдийгээр хуульд заасан ч гэсэн төсөвт тусгаж чадаагүй цаана нь ингээд хүлээгээд байж байгаа бараг 4 их наяд гаруй төгрөгийн ийм төсвийн хуваарилалт байж байгаа.

Тэгвэл тэр болгон дээр бүгдэн дээр нь зөвлөмж гаргаад бүгдэнг нь багтаа. Тэд нарыг багтаахын тулд эргүүлээд хуулиар заалттай тэр 4, 5 их наядын тэр зардлуудыг хасах асуудлыг УИХ бас шийдэх хэрэгтэй. Энэ жил маш олон хязгаарлалтууд дунд энэ төсөв ер нь бодлогын орон зай маш бага орж ирж байгаа. Маш бага бараг байхгүй шахуу орж ирж байгаа. Ийм л зүйлүүд байгаа юм аа.

Тийм учраас яах вэ зөвлөмж бол гарч болохгүй зүйл байхгүй. Гэхдээ гишүүд бодно биз ээ. Нөгөө талдаа ямар зардлыг, ямар хуулийг нь хойшлуулж ямар хуулийг нь хүчингүй болгож энэ бусад зардлууд чинь багтах вэ гэдэг дээр хариулттай байх хэрэгтэй.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Ингээд үндсэндээ Ариунзаяа гишүүн горимын санал гаргасан. Дэгийн тухай хуулийн заалтын дагуу 2026 оны төсөв дээр төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн тэтгэмжийг 2026, 2027 онд дамнуулан олгохоор орж ирсэн дээр эрх зүйн шинжилгээ хийлгэж, зөвлөмж

гаргуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд эхлээд хуруугаа уншуулаарай.

Санал хураалтдаа бэлдээрэй гишүүд, бэлдчихсэн үү? Саналын томьёоллыг ойлгож байгаа тийм үү. Ариунзаяа гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. 22 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 63.6 хувиар Ариунзаяа гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

Олонх дэмжсэн учраас зөвлөмж гаргуулахаар ТБХ-оос санал хүргүүлэх нь ээ. Өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүддээ талархал илэрхийлье баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА